



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

185.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай	Дугаар 29	833
186.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 30	834
187.	Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 31	834
188.	Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 32	835

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ИЛТГЭЛ

189.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл		836
------	--	--	-----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Дондовын Ганзоригийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Дүгэржавын Мөнхгэрэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Лувсанвандангийн Болд, Чүлтэмийн Улаан нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ядамсүрэнгийн Санжмятав, Дэндэвийн Тэрбишдагва нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү, Цэвэлмаагийн Баярсайхан, Цэрэнпилийн Даваасүрэн, Самбуугийн Дэмбэрэл, Цэдэвдамбын Оюунгэрэл нарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баянсэлэнгэ, Даваажавын Ганхуяг, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Дэндэвийн Тэрбишдагва, Содномзундуйн Эрдэнэ нарыг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Нямжавын Батбаяр, Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннъямын Гантөмөр, Санжаасүрэнгийн Оюун нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулга, Логийн Цог нарыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулга, Лувсаннъямын Гантөмөр нарыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Батболд, Дамдингийн Дэмбэрэл нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр, Дашжамцын Арвин нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ёндонгийн Отгонбаяр, Даваажанцангийн Сарангэрэл, Янгугийн Содбаатар, Отгонбилэгийн Содбилэг, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Данзангийн Лүндээжанцан, Миеэгомбын Энхболд нарыг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболд, Самбуугийн Дэмбэрэл нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатар, Чимэдийн Хүрэлбаатар нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Баттогтохын Чойжилсүрэн нарыг Хууль



зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү, Алмаликийн Тлейхан нарыг Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ИЛТГЭЛ

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь удаагийн илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн барьж байна.

Энэ удаагийн илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн хяналт шалгалт, судалгаа, Комиссын шаардлага, зөвлөмжийн дагуу байгууллагуудаас ирүүлсэн арга хэмжээний тайлан, иргэний нийгмийн болон бусад байгууллагуудын хийсэн судалгаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэгдсэн мэдээлэл болон Засгийн газрын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, иргэдээс Комисст хандан гаргасан гомдлыг үндэслэн боловсруулав.

Илтгэлд хүний эрхийн дараах асуудлыг тусгав.

1. Уул уурхайн салбар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байгаа боловч хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр байгаль орчин доройтож, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, газар эзэмших, өмчлөх, аж ахуй эрхлэх болон соёлын эрх ноцтой зөрчигдөх боллоо. Иймээс уул уурхайн үйл ажиллагаа хүний эрхэд хэрхэн нөлөөлж байгааг тусгайлан авч үзлээ.



2. Хүүхдийн эрхийн төлөв байдлын хүрээнд сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх, мөн хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хөндлөө.
3. ЛГБТ хүний төрөлхийн байдлыг нь хүлээн зөвшөөрдөггүйгээс нийгмийн бүхий л салбарт ялгаварлан гадуурхагдах, бие махбод, нэр төр, хувийн нууцад нь халдах, гутаан доромжлох, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх явдал энгийн үзэгдэл болжээ. Өнөөдөр ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрх, эрх чөлөөг нь бодитойгоор эдлүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого, үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай байгаа тул энэ асуудлыг тусгаж байна.
4. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүний эрхийн хороо, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хүний эрхийн тодорхой асуудлын хүрээнд багцлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар харьяалах яамд болон Засгийн газрын бусад байгууллагаас ирүүлсэн мэдээллийг УИХ-д танилцуулахаар шийдвэрлэсэн юм. Учир нь эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил урсгалаар явагдаж байгаад сэтгэл зовниж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар тодорхой асуудлаар санал хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УУЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ

“амьд явах эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалт)

*“эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол,
байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”*



(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт)

**“эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн
тусламж авах эрхтэй”**

(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт)

**“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн
засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг
бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй
тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх
үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”**

(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалт)

Уул уурхайн салбар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байгаа боловч хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр байгаль орчин доройтож, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, газар эзэмших, өмчлөх, аж ахуй эрхлэх болон соёлын эрх ноцтой зөрчигдөх боллоо.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэлдээ уул уурхайн үйлдвэрлэл түшиглэсэн нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа боловч Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийн асуудал хурцаар хөндөгдөж байгаа тухай дурдаж байсан билээ.

Комисс 2012 онд уул уурхайн үйл ажиллагааны явцад Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний заалт хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран 8 аймгийн 15 сумын нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийлээ. Мөн Өмнөговь аймагт судалгааны ажил гүйцэтгүүллээ. Хяналт шалгалт болон судалгааны ажлыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэй зохион байгуулсан болно. Мөн Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн багтай хамтран Өвөрхангай аймгийн Уянга, Төв аймгийн Заамар сумдад судалгаа хийлээ.



Энэ удаагийн илтгэлээр дээр дурдсан шалгалт, судалгаа, төрийн болон төрийн бус байгууллагуудаас гаргасан тайлан, судалгаа зэрэгт үндэслэн уул уурхайн үйл ажиллагаа нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх болон зан заншил, соёлын эрхэд хэрхэн нөлөөлж байгааг тусгайлан авч үзлээ.

1.1 Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 12-ын б-д “гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах” хэмээн тус эрхийг баталгаажуулсан. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

Төр энэхүү үүргийнхээ хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хууль тогтоомж болон үйл ажиллагаагаараа зөрчихгүй байх, хөндлөнгийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох, хохирлыг барагдуулах журмыг тогтоох, иргэдийг мэдээллээр хангах, шийдвэр гаргахад оролцуулах, хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, идээшиж дассан нутаг орондоо амар тайван амьдрах боломжийг хангасан бодлого, үйл ажиллагаа явуулах учиртай.

Байгалийн унаган төрхөө хадгалж үлдсэн нь манай орны онцлог байсан бол сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, хүний үйл ажиллагаанаас шалтгаалж байгаль орчин эрчимтэй доройтож байна. Манай орны байгаль орчин, газар, бэлчээрийн доройтол, усны хомсдол, агаарын бохирдол ихсэх зэрэгт уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаа ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Ашигт малтмалын газрын жилийн тайланд дурдсанаар 2013 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар 20.1 сая га талбайг хамарсан 3537 тусгай зөвшөөрөл олгогдсон байна¹. Тусгай зөвшөөрлийг хэт ихээр олгосноос үүдэн зарим аймаг, сумын газар нутгийн ихэнх хэсэг аж ахуйн

¹http://www.mram.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=14&Itemid=34&lang=mn



нэгжүүдийн мэдэлд орсон байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 2.8 сая га нутаг дэвсгэрийн 1.1 сая га буюу нийт нутгийн 40 гаруй хувьд тусгай зөвшөөрөл олгосноос 11 аж ахуйн нэгж ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж үүнээс 3 компани нүүрс олборлож эхэлжээ. Хэрэв үлдсэн 8 компани олборлолтоо эхлүүлбэл тус сумын нутагт мал аж ахуй эрхлэх боломжгүй болж, нүүдлийн мал аж ахуй устаж алга болоход хүрч болзошгүй байгааг Комисс хяналт шалгалтаар ажиллахдаа тогтоосон болно.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор ашигт малтмал эрэх, хайх, олборлох, зам тавих, барилга байгууламж барих явцдаа байгалийн унаган төрхийг алдагдуулж, улмаар хэвийн байдалд нь оруулахгүй орхисноос байгаль орчин доройтох, улмаар хүн, мал, ан амьтан осолдож, гэмтэх, дайжих эрсдэлд хүргэж байна.

Энэ байдал ердийн үзэгдэл болсон төдийгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нөхөн төлбөр олгох тал дээр хариуцлагагүй хандаж байна. Өөрөөр хэлбэл энэ нь биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаа хийгдэхгүй байгааг харуулаад зогсохгүй хяналт тавих үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаа сул байгааг нотолж байна.

Ашигт малтмалын тухай хуулиар аж ахуйн нэгж хайгуул, олборлолтын явцад эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сум, дүүргийн Засаг дарга хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг тус тус хүлээсэн боловч бодит байдал дээр хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Комиссын хийсэн шалгалтаас үзэхэд Дорноговь аймгийн Айраг суманд 46.7 га, Өвөрхангай аймгийн Уянга суманд 562.6 га, Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд 500 орчим га бэлчээр нутагт нөхөн сэргээлт хийлгүй орхисон байв.

Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлд байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох сум, дүүргийн Засаг даргын тусгай дансанд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд тус тус байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд тухайн аж ахуйн нэгж байгаль хамгаалах үүргээ биелүүлээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар



гаргуулах талаар заасан. Гэвч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь дээр дурдсан тоо баримтаас харагдаж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уурхайн талбайг бусдад дамжуулан түрээсэлж байгаагаас аливаа хохирлыг хариуцах эзэнгүй болгох, зарим иргэдийг зохион байгуулалтгүй, эмх замбараагүйгээр ашигт малтмал олборлох байдал руу түлхэх, хяналтгүй болгох, татвараас зайлсхийх, нөхөн сэргээлт хийлгүй орхих зэрэг дутагдал гарах үндэс болж байна.

Түүнчлэн нутгийн захиргааны байгууллагууд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, тухайн төлөөлөгчид уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн үйл явцыг шалгах боломж олгож чадахгүй байна.

Уул уурхайгаас байгаль орчинг доройтуулахад хүргэж байгаа өөр нэг шалтгаан бол ашигт малтмалын тээвэрлэлтийн асуудал юм. Зөвхөн Дундговь аймгийн 7, Дорноговь аймгийн 9 сумын нутгийг дайран өнгөрсөн тус бүр 30-150 метр өргөн, 15-32 салаа замаар ашигт малтмал, уурхайн тоног төхөөрөмжийг 40-100 тоннын даацтай тээврийн хэрэгслээр зөөж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас хилийн Гашуун Сухайт боомт хүртэл 245 км хатуу хучилттай зам тавьсан боловч тус замаар “Энержи ресурс”, “Эрдэнэс-Тавантолгой” зэрэг компаниуд нүүрс тээвэрлэж, бусад тээвэр эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нүүрс тээвэрлэх гэрээ хийгээгүй, замын төлбөр өндөр гэх шалтгаанаар нүүрсээ шороон замаар тээвэрлэсээр байна². Нүүрс тээврийн зам дайран өнгөрдөг тус аймгийн 6 сумын нутагт олон салаа замаас үүдэлтэй газрын хөрс эвдрэх, малын бэлчээр талхлагдах, агаарт дэгдэж буй шороо, тоосжилтоос шалтгаалж хүн, мал, ан амьтан нутагшин амьдрахад туйлын хүнд болсон байна. Өнөөдөр Тавантолгойн ордоос Гашуун Сухайт дахь Авто замын шалган нэвтрүүлэх боомтын хооронд 66 аж ахуйн нэгжийн 6122 том оврын тээврийн хэрэгсэл нүүрс зөөж байна. Хайрган хучилт хийж замыг сайжруулсан гэх “Алтайн хүдэр” ХХК-ийн Говь-Алтай аймаг дахь Таяннуурын уурхайгаас Бургастайн боомт хүртэлх 168 км замд ч гэсэн тоосжилт багасахгүй, агаар, хөрсний бохирдол үүссээр байна. Үүн дээр уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа бусад аймаг, сумын нутгаар дайран өнгөрч буй машин техникийн тоо, эвдрэлд орж доройтсон газрыг нэмбэл маш их тоо гарна.

²Дундговь аймгийн Засаг даргын 2011 оны 1/1088 дугаар албан бичиг



Зөвхөн Дорноговь аймгийн Айраг суманд гэхэд тоос шороо, жонш шатаалтаас үүссэн утаанаас болж иргэдийн дунд уушигны архаг үрэвсэлт өвчин нэмэгдэж байгаа тухай Эрүүл мэндийн нэгдлийн ажилтнууд анхааруулж байв. Комисс тус суманд шалгалтаар ажиллах үед уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компани жонш олборлох, бутлах ажлаа сумын төвийн салхины дээд талд явуулдгаас болж ялгаруулж буй утаа, хэрэглэж буй химийн хорт бодис, үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт нь сумын иргэдийн амгалан, тайван амьдрах нөхцлийг алдагдуулж, иргэд энэ талаар гомдол, шүүмжлэл гаргаж байлаа.

Комисс энэ дагуу Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраар шалгалт хийлгэж, улмаар сумын Засаг дарга Айраг сумын төвийн салхины дээд талд жонш бутлах, баяжуулах үйлдвэр ажиллуулахыг хориглосон шийдвэрийг гаргасан гэх мэт жишээ, баримтыг дурдаж болно.

Цаашид нүүрс, төмрийн хүдэр зэрэг овор ихтэй ашигт малтмал ашиглах бол тухайн орон нутгийн иргэдийн хүний эрх, эрх чөлөөг хангахад шаардагдах төмөр зам, хатуу хучилттай замыг байгуулсны дараа олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл олгох зохицуулалтыг хуульчлах, мөн уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой автомашины болон замын даац, ашиглалтын талаарх бодлого, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн батлах шаардлагатай болжээ.

Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Гурвантэс зэрэг сумын нутагт хулан, зээрийн сүрэг олон мянгаараа сүрэглэн бэлчиж байсан бол өдгөө дайжиж алга болсон талаар нутгийн иргэд харамсан өгүүлж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Өмнөговь аймагт нүүрс тээвэрлэлтийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхойлсон судалгаанд аймгийн эдэлбэр газарт 5.4 тэрбум, хөрсөнд 20.4 тэрбум, ургамалд 11.1 тэрбум, амьтны аймагт 18.7 тэрбум, агаарын бохирдлоос үүссэн хохирол 2.5 тэрбум төгрөг нийт 58.1 тэрбум төгрөгийн хохирол учирч, Тавантолгойгоос Цагаан-Хад хүртэлх 235 километр урт замын хоёр талаар нийт 35250 га газрын хөрс эвдрэлд орсон байна гэжээ.

“Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлэх талаар заасан байдаг. 2011 оны улсын усны тоо бүртгэлийн нэгдсэн дүнгээр 6646 гол, горхи бүртгэгдсэнээс 551 нь тасарсан, ширгэсэн, 3613 нуур, тойром бүртгэгдсэнээс 483 нь ширгэсэн, 9320 булаг, шанд бүртгэгдсэнээс 1879 нь усгүй болж, уур амьсгалын өөрчлөлт, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр усны горим, нөөц, чанарт өөрчлөлт орж, хомсдсон гэсэн дүн гарчээ.



Монгол Улсын уул уурхайн гол үйлдвэрлэл гадаргын ус хомс говь нутагт төвлөрч байгаа билээ. Тиймээс уул уурхайн үйл ажиллагаанд шаардагдах усны хэмжээг тухайн газар нутгийн усны нөөцтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна. Хэрэв энэ ажлыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхгүй бол говийн бүсийн байгаль-экологийн системд томоохон хохирол учирч, үүнээс шалтгаалан иргэдийн эрүүл мэнд, амьдралын түвшин, нийгмийн хөгжилд, улмаар үндэсний аюулгүй байдалд ч сөргөөр нөлөөлөх аюултай байна.

Усаар хангагдах эрх нь хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм. Гэтэл иргэд энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь Комиссын хийсэн шалгалт, судалгаагаар тогтоогдсоор байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2010 оны 8 сарын 3-ны өдөр баталсан 64/292 дугаар тогтоолоор цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг хүлээн зөвшөөрч, аюулгүй цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламж бол хүний амьдрах, аливаа эрхээ бүрэн эдлэх тулгуур гэж үзсэн байдаг³.

Цаашид бодлогын түвшинд манай орны гадаргын усны нөөцийн 70 хувийг бүрдүүлж буй сав газрын эхэд хамаарах хэсэг, газрын доорх цэнгэг усны орд газруудыг улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай байгааг⁴ Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас анхааруулсан билээ. Түүнчлэн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, холбогдох байгууллагуудад олборлолтод шаардагдах усны нийт хэмжээ болон олборлолтын явцад ашиглаж буй усны хэрэглээгээ заавал тайлагнах зохицуулалтыг хуульд тусгах нь зөв юм.

Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллага, Цаг уур орчны шинжилгээний газар, түүний харьяа байгууллага, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори зэрэг олон байгууллагаас уул уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн бүс нутгийн иргэд хөрс, агаар, усны бохирдлын ямар орчинд амьдарч байгаад хяналт шалгалт, судалгаа, хэмжилт хийжээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2012 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг (Цагаан-Хад) дахь гаалийн хяналтын талбайн орчны агаарт хийсэн хэмжилт, шинжилгээнээс үзэхэд том ширхэглэлт тоосны дундаж агууламж “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2007 стандартад заасан хүлцэх хэмжээнээс 45 дахин их, нарийн ширхэглэлт тоосонцор 34-35 дахин их байгаа нь агаарт бохирдол

³http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/64/292

⁴Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх олон улсын бага хурал дээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тавьсан илтгэлээс. УБ., 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр



үүсгэж, хөрс, усны чанар, аюулгүй байдал алдагдаж хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцөл бүрдсэн⁵ гэж дүгнэжээ.

Дээрх байгууллагууд хяналт шалгалт, хэмжилт шинжилгээний талаарх дүн мэдээллээ тухайн орон нутгийн удирдлага, ялангуяа иргэдэд хүртээмжтэй байдлаар эргэж мэдээлдэггүй талаар иргэд, малчид шүүмжилж байгаагаас үзэхэд төрийн байгууллагууд иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах талаарх санаачлага дутагдаж байгааг харуулж байна.

Уул уурхайн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд химийн хортой болон аюултай бодисыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар ашиглаж, хадгалж, устгахгүй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2011 онд 8 аймагт уул уурхай, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны хамгаалалт, химийн хорт бодисын ашиглалт хадгалалтын байдалд хийсэн үзлэгийн дүнгээр 30.7 хувь нь хангалтгүй дүнтэй гарсан байна. Тус яамнаас гаргасан тайлангаас⁶ үзвэл уул уурхайн үйлдвэрлэл, ялангуяа алт олборлолтын нөлөөгөөр 10 аймгийн нутаг дэвсгэрт 120 гаруй цэгт мөнгөн ус, цианидаар бохирдсон 200,000 орчим тонн хаягдал, шлам үүсч, 53 га талбай, олон арван худаг бохирдоод байгааг тогтоожээ. Цаашид алтны үндсэн ордын ашиглалт нэмэгдэхийн хэрээр цианы болон хүхрийн хүчил, уул уурхайн технологийн хэрэгцээний бусад хорт бодисоор гол мөрний ай сав газар бохирдож, бохирдлын байнгын эх үүсвэрүүд буй болох нөхцөл бүрдэж байна гэж уг тайланд дурджээ. Иймд уул уурхайн технологид ашиглаж буй химийн хортой бодис нь тухайн орон нутгийн иргэдийн амьдрах орчин, ундны усыг бохирдуулж, эрүүл мэнд, амь насанд нь аюул заналхийлж байгаад төрөөс онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Химийн хортой, аюултай бодисыг ашиглах, хадгалах, устгал хийх явцад төрийн холбогдох байгууллагууд хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу тогтмол хяналт шалгалт, шинжилгээ хийх, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага тулгарч байна.

Шигтгээ:

“Жолооч нар бензин хийдэг хувингаараа худгийн уснаас хутгаж, уухын аргагүй үнэртэй болгодог. Өөр худаг байхгүй учир аргагүй эрхэнд л ууж байна.”

Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын малчин Ц-тэй хийсэн ярилцлагаас. 2012 он

⁵Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2012 оны 4/2056 дугаар албан бичиг

⁶“Монгол Улсын Байгаль орчны төлөв байдлын 2008-2010 оны тайлан”

Мөн уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, тээвэрлэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, осол нэмэгдэх хандлагатай байна. Нүүрсний тээврийн машинд дайруулан нас барах, гэмтэж бэртэх, уурхайн хилийн шав, тэмдэг тогтоож ухсан шуудуу, карьер, цооног, өрөмдлөгөөс тогтсон усанд унаж нас барах зэрэг ноцтой осол олонтаа гарах боллоо.

Өмнеговь аймгийн хэмжээнд 2011-2012 оны эхний 9 сарын байдлаар нийт 350 зам тээврийн осол бүртгэгдэж, үүнээс 190 буюу 54.2 хувь нь Тавантолгойн уурхайгаас Гашуун Сухайтын боомт, Нарийн Сухайтын уурхайгаас Шивээ Хүрэнгийн боомт хүртэлх нүүрс тээвэрлэлтийн замд гарчээ. Тус гэмт хэргийн улмаас нийт 26 хүн нас барж, 44 хүн хүндэвтэр болон хүнд зэргийн гэмтэл авсан байна. Энэ тоог ердийн зорчигч, тээврийн хөдөлгөөн харьцангуй өндөр боловч уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт хийгддэггүй Завхан аймагтай харьцуулж авч үзье. Завхан аймагт 2011-2012 оны эхний 9 сарын байдлаар нийт 131 зам тээврийн осол бүртгэгдэж, үүний улмаас нийт 9 хүн нас барж, 18 хүн хүндэвтэр болон хүнд зэргийн гэмтэл авсан байна. Өөрөөр хэлбэл Өмнеговь аймагт бүртгэгдсэн зам тээврийн осол нь Завхан аймгийнхаас 2.7 дахин их, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо нь 3.8 дахин их байгаа нь нүүрс тээвэрлэлтийн замд хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэл өндөр байгааг харуулж байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барсан болон эрүүл мэндээрээ хохирсон хүний тоо ч Өмнеговь аймагт их байна.

Ашигт малтмалын тухай хуульд уурхайн талбайн байнгын шав тэмдэг тавихыг үүрэг болгосон ч хэрхэн тавих талаар нарийвчилсан журам, стандартыг гаргаж мөрдүүлээгүйгээс компаниуд хялбарчлан гүн суваг, шуудуу ухаж тэмдэглэх жишиг тогтжээ. Тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн талбайн шав тэмдгийг хамгаалах бөгөөд төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр талбайн хилийг өөрчлөх тохиолдолд түүнийг шилжүүлэн байрлуулах арга хэмжээ авна.” гэж заасан ч шилжүүлэн байрлуулах боломжгүй шав тэмдгийг гүн суваг шуудуу ухаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авалгүйгээр тавьж байгаагаас хүн, мал суваг, шуудуунд унаж осолдох, бэртэх явдал ихээр гарч байна.

Мөн өрөмдлөг хийгээд гарсан усыг гүн нүх ухаж, юулж орхих, өрөмдлөгийн дараа нөхөн сэргээлт хийдэггүйгээс хүн, мал осолдох болсон байна. Өмнеговь аймгийн Гурвантэс сумын нэг малчин айлын бага насны хоёр хүүхэд уурхайн өрөмдлөгөөс шавхаж тогтоосон усанд унаж амиа алдсан бол насанд хүрсэн бас нэг хүү нь овоолсон шороонд мотоцикльтайгоо онхолдож нас баржээ. Гэтэл энэ хэрэгтэй холбоотойгоор хэн ч хариуцлага хүлээгээгүй байна.



Ингэж уул уурхайн олборлолт, тээвэрлэлт, технологитой холбоотой нутгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах, амьд явах эрхэд эрсдэл учирсаар байна. Иргэд амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөөрөө хохирсоор байхад төрийн зүгээс иргэдээ хамгаалах, хохирлыг нь шударгаар нөхөн төлүүлэх, хууль тогтоомжийг чандлан мөрдүүлэх, уул уурхайг хариуцлагатай хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг бий болгох явдал туйлын хангалтгүй байна.

Иймд уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрсэдсэн, бие эрхтэн, сэтгэл санааны хохирол учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх механизмыг тусгайлан бий болгох, хохирол нэхэмжлэх эрхийг тодорхой болгох асуудлыг төр шийдвэрлэх хэрэгтэй байна.

Цаашид уурхайн олборлолтоос үүссэн талбай, нүх, суваг шуудуу, овоолго, хөрсний эвдрэлийн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн аж ахуйн нэгжээр заавал хийлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, нөхөн сэргээлтийн үйл явц, үр дүнгийн талаар санал өгөх боломжийг нутгийн иргэдэд олгох, хэрэв уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ үүргээ биелүүлээгүй бол аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгодог, дахин тусгай зөвшөөрөл олгодоггүй байх, ашигт малтмал хайх, ашиглах явцад байгаль орчинд хохирол учруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах зохицуулалтыг бий болгож, хяналтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад олгох асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.2 Уул уурхайн бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх

Байгаль орчин доройтож, орчны эрүүл, аюулгүй байдал алдагдах явцад хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх боллоо. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр хязгаарлагдахгүй бөгөөд иргэний эрүүл байх, эрүүл амьдрах үндсэн нөхцөл болох хоол хүнс, ундны ус, орон байр, ажлын байр, хүрээлэн буй орчин зэрэг нь эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй, хүнд ээлтэй байх шалгуурт нийцсэн байхыг мөн хамааруулан үздэг. Монгол Улсын нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх, өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцлийг бүгдэд бий болгох” үүргийг оролцогч улсуудад үүрэг болгосон билээ.

Гэвч уул уурхайн хайгуул, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрх



зөрчигдөж байгаа нь Комиссын болон мэргэжлийн зохих байгууллагуудын хийсэн хяналт шалгалт, судалгааны дүгнэлт, тайлангаар нотлогдож байна. Эдгээрийн үр дүнд үндэслэн хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөрчих дараах эрсдэл байгааг тодорхойлж байна.

Ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт болон бусад барилга, бүтээн байгуулалтын явцад хөрс хуулалт, өрөмдлөгө, тэсэлгээ, баяжуулалт, хаягдал чулуулгийн овоолго, том оврын тээврийн хэрэгсэл зэрэг олон эх үүсвэрээс тоосонцор болон бусад хорт бодис агаарт цацагдан тархаж байна. Агаарын болон орчны бохирдол, аюултай, хорт бодисын зохисгүй хэрэглээ зэргийн талаар илтгэлийн эхэн хэсэгт тоо баримттайгаар дурдсан билээ. Эдгээрээс гарч буй тоосонцорыг хүн амьсгалснаар мөгөөрсөн хоолой, уушигны гуурс, гуурсанцар бохирдох, битүүрэх, бронхит болох, элэг, бөөр зэрэг дотор эрхтэн өвчлөх, улмаар хорт хавдар үүсгэх зэрэг өвчлөлд хүргэж байна. Зөвхөн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд амьсгалын тогтолцооны өвчин нэг жилийн дотор 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн тус аймгийн хэмжээнд нас баралтын шалтгааны зонхилох хувийг амьсгалын замын өвчлөл эзэлж, бэртэл, хордлогоос үүдсэн нас баралт жил тутам нэмэгдэж байгааг тэмдэглэжээ.

Томоохон уурхайн харьяалагдах сумдын эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадал, хүртээмж болон техник хангамж, санхүүжилтийн асуудлууд туйлын муу байна. Уул уурхайн хөгжлийг дагасан төвлөрөл, явуулын хүн ам, ажилчид зэрэг механик өсөлт ихэсч байгаа ч ойролцоогоор 3000 орчим хүн амд үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай сумын эмнэлгийн орон тоо, төсөв санхүүжилт, үйлчилгээ нь энэхүү эрэлтийг хангаж хүрэлцэхгүй байна. Мөн сумын эмнэлгүүдийн тоног төхөөрөмж 1980-аад онд үйлдвэрлэгдсэн, ихээхэн хоцрогдож муудсан байдалтай байна. Иймд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад анхаарах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Жишээ дурдвал, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн хөндийд амьдарч, гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн хувьд Өлт баг нь сумын төвөөс зайтай учраас бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, ахмад настнуудад гэнэтийн, яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай болсон тохиолдолд цаг алдалгүй хүрч очих боломж хомс байна. Эрүүл мэндийн тусламж авахад гардаг гол бэрхшээлд алслагдмал байдал, тээврийн хэрэгсэл дутмаг, холбоо харилцаа байхгүй зэрэг нөхцлүүд орж байгааг анхаарч төсөв, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Комиссын 2012 онд хийсэн судалгааны дүнгээс үзвэл уул уурхайн бүсэд амьдарч байгаа иргэд, малчдын эрүүл мэндэд үзүүлэх



сөрөг үр дагавар ихэсч байгааг Засгийн газар, Эрүүл мэндийн яам, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд анхааралдаа авч уул уурхайн нөлөөгөөр эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, хор хохирлыг тогтоох, тандах судалгааг тогтмол, тодорхой давтамжтай хийж хэвших хэрэгтэй байна.

Уул уурхайн үйл ажиллагаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандартыг мөрдөөгүй, ажлын байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлээгүйгээс үүдсэн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тоо нэмэгдэж байна. Тухайлбал, машин тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянан шалгах, техникийн үзлэг, хэмжилтийг цаг тухайд нь хийдэггүй, шөнийн цагаар орчны гэрэлтүүлэггүй ажилладаг, цахилгааны холболт ил задгай, тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт байхгүй зэрэг аюулгүй ажиллагааны наад захын горим алдагдах явдал байсаар байна. Нөгөө талаас уурхайн ажилчдын хувьд тоос шороо, дуу чимээ, халуун хүйтэн зэрэг хүнд нөхцлийн зэрэгцээ ажлын ачааллаас болж ядаргаанд орох, болгоомж, сэрэмж алдах зэрэг байдал гарч байгааг судалгааны дүн харуулж байгаа юм. Зарим компанийн хувьд ажилчдыг хорь хүртэл хоног шөнө дараалан ээлжинд гаргадаг, уртасгасан цагаар ажиллуулах тохиолдол байсаар байна. Энэ бүгдээс шалтгаалан цусны даралт ихсэх, зүрх, цусан хангамжийн дутагдал өвчин ихсэх, сэтгэцийн өвчлөлд нэрвэгдэх, улмаар үйлдвэрлэлийн осолд орох, үүнээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй болох, амь насаа алдаж болзошгүй нөхцөл байдал үүсч байна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн 7.(b)-д “аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцлийг бүрдүүлэх;” нь Пактад оролцогч улсууд хүн бүрийн хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөхийн нэг хэлбэр мөн болохыг дурдсан билээ.

Хувиараа ашигт малтмал олборлогчдын хувьд газрын гүнд ус чийгтэй, агааргүй, хүйтэн нөхцөлд ажилладаг, шороогоо явган сууж угаадаг зэргээс үүдэлтэй ууц нуруу, үе мөчний өвчлөл, хөл, гарын судас бүдүүрэх зэрэг олон төрлийн өвчин эмгэг тусдаг болох нь эмнэлгийн байгууллагуудын тоо баримтаас харагдаж байна. Тэд мөнгөн усны хор уршиг, архидалтын дон, чанга дуу авианаас үүдэлтэй оюун ухаан самуурах, багтраа, бэлгийн замын өвчин тусах, нүд гэмтэх, дүлийрэх зэргээр эрүүл мэндийн хувьд маш эрсдэлтэй нөхцөлд ажиллаж, амьдарч байна.

Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар Чандмань суманд үзлэг хийхэд 71 хүний 68 нь нүдний өвчлөлтэй байсан ба энэ нь агаарын тоосжилт, хуурайшилт, бохирдолттой шууд холбоотой байна гэсэн дүгнэлтэд хүрснийг Комисс 2012 онд Говь-Алтай аймагт шалгалтаар ажиллах үед тухайн эмнэлгийн эмч нар тайлбарлаж байлаа.



Иймд иргэд, уул уурхайн салбарт ажиллагсдыг гэмтэл осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх механизмыг ажиллуулах, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, уул уурхайн салбарт ажиллагсдын ажлын аюулгүй байрыг бий болгох асуудлаарх Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Уул уурхайн үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох зэрэг ажлыг төрөөс зохион байгуулах шаардлагатай байна.

1.3 Уул уурхайн бүс нутагт амьдарч буй малчдын зан заншил, ахуй, соёлын эрх

Монголчууд эртний түүхтэй, нүүдлийн соёл, зан заншилтай ард түмэн бөгөөд бэлчээрийн мал аж ахуй бол бидний соёлын салшгүй нэг хэсэг билээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос гаргасан XXI дүгээр Ерөнхий зөвлөмжид “соёл”-ын асуудлыг амьдрах арга зам, хэл, шашин, зан үйл, хүнс, хувцас, орон байр болон соёл урлаг, уламжлал, ёс заншил зэргийг оролцуулан өргөн хүрээнд томъёолжээ. Гэвч өнөөдрийг хүртэл Монгол Улс соёлын эрхийн асуудлыг урлаг соёлын гэх өнцгөөс авч үзэж иржээ. Ингэж явцуу хүрээнд томъёолсны улмаас иргэдийн соёлын эрх зөрчигдөх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо шударгаар барагдуулах боломжийг хааж байна. Гэтэл аливаа улсын иргэдийн амьдрах уламжлалт арга зам бол яах аргагүй соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг билээ. Нүүдлийн өв соёлтой манай улсын хувьд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа иргэд бол энэхүү соёлыг тээгчид юм. Монгол Улс сүүлийн арав гаруй жил хөгжлийн бодлогодоо уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэхийг зорьж буй хэдий ч уламжлалт ахуй соёлоо хадгалж яваа малчдын асуудлыг энэхүү бодлогодоо анхаарч үзээгүйн улмаас Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан иргэдийнхээ соёлын амьдралд оролцох эрхийг зөрчихөд хүргэж байна.

Монгол Улс нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактад оролцогч улсын хувьд иргэдийнхээ соёлын амьдралд оролцох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргийг хүлээсэн хэдий ч соёлын эрхийг эрх зүйн хүрээнд бүрэн дүүрэн баталгаажуулаагүйгээс гуравдагч этгээдийн зүгээс тухайн эрхийг зөрчих, хохирлыг нь барагдуулахгүй байх нэг үндсэн шалтгаан болж байна.

Судалгаанаас үзэхэд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс суманд 2004 оны байдлаар малчдын тоо 3029 байсан бол 2011 онд малчдын тоо 1352 буюу даруй 56 хувиар цөөрчээ. Эндээс бусад малчид хаачсан, амьжиргаагаа хэрхэн залгуулж байгаа вэ? гэсэн асуулт урган гарч



байна. Комиссоос тус нутагт судалгаа хийх явцад аргагүйн эрхэнд мал аж ахуйгаа хэн нэгэнд даатгаад сумын төвд амьдарч байгаа малчид цөөнгүй дайралдсан билээ. Зарим малчдын тухайд аргагүй байдалд орсны улмаас өөр нутаг руу нүүсэн байх магадлалтай байна.

Үлдсэн малчдын тухайд ч бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэх боломж улам бүр хумигдаж байна. Жилд дөрвөөс доошгүй удаа отор нүүдэл хийдэг байсан малчид одоо 1-2 удаа нүүснийгээ олонд тооцож байна. Тэр ч байтугай газар нутаг шахагдсаны улмаас зарим малчид өвөлжөөн дээрээ зусах тохиолдол ч гарах болжээ.

Малчид бэлчээрээ сэлгэн нүүх боломж хэд дахин буурч, уламжлалт соёл алдагдахад хүрч байна. Нүүх боломж хомсдсоны улмаас малын тоо, малаас авах үр шим буурч байна. Өвс ургамал сийрэг, тачирхан ургадаг говь нутагт суурин мал аж ахуй, фермерийг хөгжүүлэхэд таатай биш тул энэ бүс нутагт нүүрлээд буй мал аж ахуйн салбарын бэрхшээлийг анхаарах цаг болжээ.

Малчдад тулгамдаж буй өөр нэг асуудал бол өвөг дээдсээсээ өвлөн авсан өвөлжөө, хаваржаа, намаржаагаа өөрсдийн өмч хэмээн үздэг хэдий ч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд өвөлжөөний газраа эзэмших эрхийн гэрчилгээтэй малчид түгээмэл таарч байлаа. Гэтэл эзэмшиж байгаа газар дээрх хашаа саравчаа өмчилж авах эрхтэй гэдгээ мэдэж байгаа малчин тун цөөн байгаа юм. Өмчлөх эрх нь хүнийг төрөхөд хамт бий болдог бөгөөд хуулиар зохицуулсан эсэхээс үл хамааран шууд хэрэгжих учиртай үндсэн эрх мөн. Гэвч уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн энэхүү үндсэн эрх зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлж, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргээ хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгааг төрөөс анхаарах хэрэгтэй байна.

Нөгөө талаас тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниуд бэлчээр нийтийн өмч болохыг овжноор ашиглаж малчдыг идээшиж дассан нутгаас нь шахан зайлуулах явдал түгээмэл тохиолдож байна. Адилхан эзэмших эрхийн гэрчилгээтэй боловч уул уурхайн компаниуд малчдаас давуу эрх эдэлж байна. Үүний зэрэгцээ уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим компанийн зүгээс нутгийн иргэдийн шашин шүтлэг, итгэл үнэмшлийг үл хүндэтгэж, сэтгэл зүйн дарамтад оруулах явдал ч гарч байна.



Шигтгээ:

“Хайгуулынхан тахилгатай уул хадыг тэгшилж овоон дээр машинтай явдаг. Нэг л сэрэхэд гэрийн хаяанд өрөмдөөд эхэлдэг. Хэлэхээр “Та нар дуугүй бай, бэлчээр нийтийн өмч, дээрээс зөвшөөрсөн” гээд тамгатай бичиг үзүүлдэг. Монголын газар нутаг дарга нарын тамгатай бичгээр зүйл дуусч байна даа.”

Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин Л-тэй хийсэн ярилцлагаас. 2012 он

Шигтгээ:

“Манай өвөлжөө хайгуулын лицензэд орсон. Өвөлжөөний хажууд хэлэхгүйгээр өрөм тавьдаг. Ногоо ургахаа байсан. 2 жилийн өмнө бэлчээрийн газарт хайгуулын өрөм тавиад машин тэргээрээ хайр найргүй явж сүйтгэсэн. Өрөмдсөн цооног гаргасан нүхээ булалгүй тэр хэвээр нь орхиод явдаг. Одоо манайх зун болчихоод байхад зусланд буухын аргагүй болсон тул өвөлжөөндөө сууж байна. Гол горхи модтой баянбүрд уул уурхайн балгаар байхгүй болсон. Хээрийн амьтан хулан зээр байхгүй болсон. Уул уурхайн компанийнхан худлаа сайхан амалдаг.”

Ганцаарчилсан ярилцлагаас. Өмнөговь аймгийн Гурвантэс сум Баясах багийн малчин. 2012 он

Малчдын амьдрал ахуйд аливаа байдлаар нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад иргэд ялгаварлан гадуурхагдахгүй, идэвхтэй, мэдээлэлтэй оролцоо эрхтэй. Гэвч өнөөгийн практикт нутгийн иргэдийн өөрсдийнх нь амьдралд нөлөөлж байгаа аливаа асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явц дахь оролцоо хангалтгүй байна.

Энэ бүх үйл явдал уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа нутагт өрнөөд удаж байгаа ч хүний эрхийг хангаж, хамгаалах үүрэг хүлээсэн төрийн зүгээс малчдын эрхийн чиглэлээр хариу үйлдэл хийсэнгүй өнөөдрийг хүрээд байхад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийг зорьж байгаа хувийн хэвшлийн зүгээс нүүлгэн шилжүүлэх, нөлөөллийн бүсийг тогтоох, нөхөн олговор олгох зэрэг зарим ажлыг санаачлан гүйцэтгэж байгаа нь сайшаалтай. Гэвч тухайн нутаг дэвсгэрт амьдарч байсан малчдын уламжлалт аж ахуйгаа эрхлэх сонголтыг үл хүндэтгэсэн бодлого хэрэгжиж байгаагийн улмаас малчид мэдээлэлгүй, мэдлэггүйгээр гэрээний нөгөө талд сууж, хохирлоо шударгаар барагдуулж, ашиг сонирхлоо хамгаалж чадахгүй үлдэж байна.



Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.” гэж заасан ч энэ заалт хэрэгжихгүй байна.

Комиссын захиалгаар хийсэн судалгаанаас үзэхэд Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтэций суманд малчин өрхөд олгож буй нөхөн олговрын хэмжээг тогтоохдоо иргэдийн саналыг харгалздаггүй гэж ихэнх малчид үзсэн байна. Судалгаанд оролцогчдын мэдээллээс харахад олгож байгаа нөхөн олговрын хэмжээ 1.5 саяаас 7 сая хүртэлх төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа юм.

Иймд нэн тэргүүнд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгоор “Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах тухай” Аархусын конвенцид нэгдэж орох, ашигт малтмал хайх, олборлох, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Тус конвенц нь хүн бүрийн эрүүл, сайн сайхан аж төрөхөд нийцэхүйц орчинд амьдрах эрх, түүнчлэн өнөө болон ирээдүй үеийнхний тусын тулд, дангаараа болон бусадтай хамтран байгаль орчныг хамгаалах, нөхцлийг нь сайжруулах үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрч, энэ эрхийг баталгаажуулах, үүргээ биелүүлэхийн тулд иргэд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах боломжтой байх ёстойг харгалзан үзсэний үндсэн дээр үүнтэй холбогдуулан эрхийг нь эдлүүлэхийн тулд иргэдэд туслалцаа үзүүлэх механизмыг бий болгох зорилготой. Одоогийн байдлаар дээрх конвенцид Европын бүх улс нэгдэн ороод байгаа ба Ази тивээс Казахстан, Киргизстан, Тажикстан, Азербайжан зэрэг улсууд нэгдэн ороод байна⁷.

Цаашлаад нутгийн захиргааны болон өөрийн удирдах ёсны байгууллагын зүгээс иргэдийн эрх, эрх чөлөөг дээдлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэн хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийн хүний эрхийн талаарх болон

⁷<http://www.unecce.org/fileadmin/DAM/env/pp/AarhusMap.html>

нутгийн захиргаа, бизнес эрхлэгчидтэй хэрхэн харилцах тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй юм.

Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, Үндсэн хуульд заасны дагуу хүрээлэн буй орчин, эдийн засгийн хөгжлийн бодлогыг томъёолохдоо иргэдийн, тэр дундаа эрх мэдлийн цөөнх, гадуурхагдсан, эмзэг бүлгийн эрх ашгийг онцгойлон анхаарах үүргийг төр хүлээсэн байдаг. Гэвч энэ үүргээ бодитой хэрэгжүүлж чадахгүй байгаагийн улмаас уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа орон нутгийн иргэд, тэр дундаа малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өв соёлоо баримтлах, хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэх, өмчтэй байх, аж ахуй эрхлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо шударгаар барагдуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхүүд ноцтой зөрчигдөж байгааг дээр дурдсан жишээ, тоо баримт нотлон харуулж байна.

Төр нь уул уурхайн салбарт гарч буй хүний эрхийн зөрчлөөс иргэдээ хамгаалж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь төр, иргэн, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцаа гэдгийг анхаарч төрөөс оновчтой бодлого, шийдвэр гаргаж хэрэгжүүлэх асуудал тулгамдаж байна.

Комисс “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” сэдэвт олон улсын бага хурлыг 2012 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Ази Номхон Далайн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулган болон Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй зохион байгуулж, уг хуралд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн аж ахуйн нэгж, хүний эрх, байгаль орчны чиглэлээр ажилладаг олон улсын болон үндэсний төрийн бус байгууллагууд, гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэд, малчид, бичил уурхай эрхлэгчид, Ази Номхон Далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагууд, элчин сайдын яамд, НҮБ-ын хүний эрхийн шинжээч зэрэг 200 орчим хүн оролцсон билээ.

Хуралд оролцогчид Монгол Улсын уул уурхайн бизнесийн бодлого, хууль эрх зүйн орчин хүний эрхэд суурилагагүй, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо дутмагаас шалтгаалж хүний эрх зөрчигдөж байгааг онцлон тэмдэглэсэн болно.

Нэн ялангуяа, НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчим⁸-ыг сайшаан дэмжиж, Удирдах зарчмын үндсэн 3 хүрээнд хамаарах хүний

⁸<http://www.business-humanrights.org/SpecialRepPortal/Home/Protect-Respect-Remedy-Framework/GuidingPrinciples>



эрхийг хүндэтгэх, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тус тусын үүргээ шударгаар сахин биелүүлэхийг төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудад уриалсан юм.

Тус бага хурлаас Монгол Улс дахь уул уурхайн салбарт хүний эрхийг хангаж, хамгаалахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, холбогдох төрийн байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллага, уул уурхайн бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагуудад хандан зөвлөмж гаргасан бөгөөд энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах нь уул уурхайн салбарт хүний эрх зөрчигдөх явдлыг багасгахад чухал нөлөө үзүүлнэ хэмээн Комисс үзэж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮҮХДИЙН ЗАРИМ ЭРХИЙН АСУУДАЛ

“Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно”

(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалт)

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн
Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалт)

“Бүх хүүхэд, өсвөр насныхны тухайд гэр бүлийн гарал буюу бусад үндэслэлээр алагчлахгүйгээр хамгаалах, тусламж үзүүлэх онцгой арга хэмжээг авч байх ёстой. Хүүхэд, өсвөр насныхныг эдийн засаг, нийгмийн дарлал, мөлжлөгөөс хамгаалж байх ёстой. Тэднийг ёс суртахуун, эрүүл мэндэд нь харш, амь насанд нь аюултай буюу хэвийн өсөлт хөгжилтөд хор болохуйц салбарт ажиллуулсан бол хуулийн дагуу шийтгэнэ. Үүнээс гадна төр хүүхдийг ажиллуулах насны хязгаарыг тогтоож, үүнээс доош насны хүүхдийг хөлслөн ажиллуулахыг хориглож, зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байна.”



(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлийн 3 дахь заалт)

Хүүхэд нь өөрийн эрхээ бие даан хамгаалах чадваргүй, онцгой халамж, хамгаалалт түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаарддаг субъект болохын хувьд төрийн зүгээс хүүхдийн эрхийн асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай байдаг. Иймээс манай улс олон улсын хүний эрхийн суурь гэрээ, конвенцуудын үзэл санаанд нийцүүлэн хүүхдэд хамаарах үндсэн стандартууд болон тэдгээрийг заавал дагаж мөрдөх олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжоороо хуульчлан баталгаажуулсан билээ.

Монгол Улсын төрийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр олон чухал арга хэмжээ авч байгаа хэдий ч, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, ажилгүйдэл, ядуурал зэрэг үзэгдэлтэй холбоотойгоор хүүхдийн эрх зөрчигдөж, анхаарал татсан асуудал гарсаар байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2002 онд хуралдсан Хүүхдийн асуудлаарх Тусгай чуулганаар дэлхийн улс орнууд XXI зуунд хүүхдэд ээлтэй дэлхий ертөнцийг бүтээн байгуулах зорилгыг өмнөө тавьж хүүхдийн төлөө дэлхий ертөнцийг өөрчлөх үүрэг амлалтыг авсан билээ.

Иймээс улс орнуудын төрийн зүгээс хүүхдэд боловсрол олгоход чухалчлан анхаарч, хүүхэд бүрийг хөгжүүлэх, ялангуяа нийгэмд өөрчлөлт бий болгох чадвартай, мэдлэгтэй болгоход анхаарах болжээ. Тодруулбал, хүүхэд бүр сурч боловсрох эрхээ эдэлснээр өөрийн нөөц бололцоог бүрэн дүүрэн нээх, бусад эрхээ ямар нэгэн хэлбэрээр зөрчүүлэхгүйгээр эдлэх боломжийг олгодог. Харин хүний эрхийн зөрчлийн хохирогч болохоос хүүхдийг урьдчилан сэргийлэхийн тулд төрийн зүгээс үндэсний хууль тогтоомжоор эрхийг нь баталгаажуулахын зэрэгцээ тухайн эрхийг эрүүл, аюулгүй, таатай орчинд эдлүүлэх ёстой. Гэхдээ үүнд төр дангаар хариуцлага хүлээхгүй бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүд, нийгмийн харилцаанд орж байгаа бусад хүмүүс ч мөн адил хамаатай юм.

Хүний эрхийн Үндэсний Комисс 2012 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сангийн туслалцаа дэмжлэгтэйгээр “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хүүхдийн эрхийн үндэсний төв, Монголын сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй хамтран Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашны боловсрол олгох сургууль, сүм, хийдэд суралцаж буй хүүхдийн сурч боловсрох, эрүүл, аюулгүй байх, хөгжих,



оролцох, хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт, судалгаа хийлээ.

Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын зургаан тусгай сургуульд⁹ суралцаж буй хүүхдийн эрх Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг үнэлж, хэрэгжилтийг тодорхойлох зорилгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Түүнчлэн, унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг авч үзэв.

2.1. Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүд

Манай улсад хүүхэд хуулийн дагуу ерөнхий боловсролын сургуульд хамрагдан суралцаж байгаагаас гадна хүүхдүүдийн нэг хэсэг нь шашны сүм хийдэд байнга шавилан сууж шашны ном үзэж байна. Сүм хийдэд шавилан сууж байгаа эдгээр хүүхдийн сурч боловсрох болон зарим эрх зөрчигдөж байгаа нь хяналт шалгалт, судалгаанаас харагдаж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс 2012 онд нийслэлийн найман дүүргийн 26, 12 аймгийн буддын 28 сүм хийд болон христийн шашны 7, исламын шашны 1 байгууллагад хяналт шалгалт, судалгаа хийлээ. Судалгаанд буддын сүм хийдэд шавилан суралцаж буй 290 хүүхдийг хамруулав.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, энэхүү эрхийг хангаж, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг 1993 онд баталсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж байна.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлд “Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газраас баталсан журмын дагуу үүнд шаардагдах зардлын тодорхой хэсгийг гаргаж, багшлах боловсон хүчнээр ханган, мэргэжлийн хяналт тавина”, Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т “Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна” гэж тус тус заажээ.

⁹Сүхбаатар дүүргийн 25, 29, 116, Хан-Уул дүүргийн 63, Баянгол дүүргийн 70, Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулиуд



Хүснэгт Шашны сургууль, дацанд суралцагчдын тоо¹⁰

Насны бүлэг	Шашны сургууль дацанд суралцагчдын тоо									
	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Бүгд	248	465	4999	5635	261	2251	1820	273	1564	1362
8 нас хүртэл	29	89	23	196	284	25	2	1	0	15
9-12 нас	152	287	292	345	632	159	93	117	260	74
13-15 нас	330	645	1173	1265	1051	435	450	593	363	372
16 наснаас дээш	737	3444	3511	3829	4294	1632	1275	562	941	901

Сүм хийдэд шавилан сууж, шашны сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд сүм хийд, дацангийн дэргэдэх шашны сургуулиар дамжуулж эсвэл албан бус боловсролын хөтөлбөрт хамруулах байдлаар ерөнхий боловсрол олгож байна. Үүнээс гадна ерөнхий боловсрол эзэмшиж чадалгүй завсардаж байгаа хэсэг ч бас байна.

Судалгаанд хамрагдсан буддын 54 сүм хийдийн 11-д нь шавилан сууж байгаа 30 хүүхэд ерөнхий боловсрол олгох сургалтад огт хамрагдалгүй сургууль завсардсан жишээ байна. Сургуульд элсэн орох 6 наснаасаа сүм хийдэд шууд шавилан сууж, сургуульд явж үзээгүй хүүхэд ч тэдний дунд байна. Лам багш нарын зүгээс суурь боловсрол шаардлагагүй, шашны сургаал номоо үзэж, амьдралаа залгуулах боломжтой гэж хандах байдал ажиглагдаж байлаа.

Шигтгээ:

Энгийн боловсрол хэнд ч хэрэггүй... Шал дэмий... Түүний оронд шашны боловсрол энэ хүүхдүүдийн амьдралд хэрэгтэй. Өөрийгөө өөрөө аваад явахад ч тустай. Ний нуугүй хэлэхэд би төрийн боловсролыг дэмждэггүй...

*Зорилтот бүлгийн ярилцлага “Лам багш нар”,
Дархан, Дархан-Уул аймаг*

¹⁰МУУСГ Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. УБ., 2005, 304 дэх тал; МУУСХ Монгол Улсын Статистикийн эмхэтгэл УБ., 2009, 345 дахь тал



Шигтгээ:

Бид энэ хэдэн хүүхдээ бусдын гар харахгүй, хар толгойгоо мэдэх хэмжээнд шашны боловсрол эзэмшээсэй гэж хүсдэг. Сургуульдаа явж байгаа эсэхэд бид хяналт тавьж чаддаггүй.

*Зорилтот бүлгийн ярилцлага “Сүм хийдийн удирдах ажилтнууд”,
Чингэлтэй, Улаанбаатар*

Шигтгээ:

Их дээд сургуульд орохын тулд арван жил төгсөх ёстой. Хүүхдүүд маань алсын зайн сургалтын төвд явдаг. Заримдаа хичээлээ гүйцэж чаддаггүй. Харин шалгалтаас хэд хоногийн өмнө тестийг нь авч оруулж, шалгалтад нь тэнцүүлдэг.

*Зорилтот бүлгийн ярилцлага “Сүм хийдийн удирдах ажилтнууд”,
Арвайхээр, Өвөрхангай*

Хяналт шалгалт, судалгаанд хамрагдсан нийт 56 байгууллагын хоёрынх нь барилга эдэлгээ даахгүйн улмаас мэргэжлийн хяналтын байцаагч акт тавьсан байна. Зарим сүм хийд, дацангийн дэргэдэх сургууль, дотуур байр орон сууцны подвальд байрлаж байгаагаас байгалийн гэрэлтүүлэг хангалтгүй байна.

Шигтгээ:

112 дугаар сургуулийн анги, танхим тохижилт муутай, гэрэлтүүлэг хангалтгүй, цонх маш жижиг байна. Сандал ширээний тоо хангалттай хэдий ч зарим сандал ширээ хуучирч муудсан, эвдэрхий, ахлах ангийн хүүхдүүдийн ширээ сандал жижиг хэмжээтэй байв. Гадаа бие засах газартай, гар угаах газар, биеийн тамырын заал байхгүй, зөөврийн ус ашигладаг ба сургуулийн барилгын чанар муудсан дүр зурагтай байв. Тус сургуулийн байрыг нураах тухай 2010 онд мэргэжлийн хяналтын байцаагч дүгнэлт гарсан хэдий ч 100 жил болж байгаа түүхийн дурсгалт газар гэсэн утгаараа өнөөг хүртэл тодорхой шийдэлд хүрээгүй байна.

*Зорилтот бүлгийн ярилцлага “Сургуулийн удирдах ажилтнууд”
Чингэлтэй, Улаанбаатар*

Сүм хийд, дацангийн дэргэдэх сургуулиудад мэргэжлийн 2-3 багш ажилладаг ба төрөөс олгодог нэг хүүхдэд ногдох хувьсах зардал болон



сүсэгтэн олны хандиваар хүүхдийн ном сурах бичиг, багш нарын цалинг шийддэг. Нийслэлийн 112 дугаар сургуулийн хувьд төсвөөс санхүүждэг хэдий ч энэ нь төдийлөн хангалттай байдаггүй талаар сургуулийн удирдлага хэлж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Албан бус боловсролын төвөөс ихэнхдээ 2-3 багш ирж лам хүүхдүүдэд хичээл заадаг ч сургах чин хүсэлгүйн улмаас хичээлийг урсгалаар явуулдаг нь ярилцлагын явцад ажиглагдав.

Судалгаанд хамрагдсан 62 байгууллагын 14 нь орчин үеийн ширээ сандал, 11 нь уламжлалт болон орчин үеийн холимог, 37 нь уламжлалт хэлбэрийн ширээ сандлыг хүүхдүүдэд зориулан ашиглаж байсан. Уламжлалт ширээ сандал ашиглаж хичээллэх нь хүүхдийн хэвийн өсөлтөд сөрөг нөлөөтэй байж болохыг анхаарах хэрэгтэй. 19 сүм хийд ерөнхий боловсролын сургалт явуулах боломжтой анги танхимтай самбар, үзүүлэн зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Бусад сүм хийдийн хувьд анги танхим хүрэлцээгүй, ширээ сандалгүй, сургалтын хэрэглэгдэхүүн, нөөц, боломжоор хомс байлаа.

Шавилан сууж байгаа хүүхдийн амьдардаг байр нь өнөөгийн шаардлагад нийцээгүй, зарим газарт 12 метр квадрат өрөөнд 7-10 хүүхдийг нэг дор байрлуулсан, түүнээс ч доогуур нөхцөлд хүүхдийг байлгадаг тохиолдол тааралдлаа. Амьдрах байрны хувьд ислам, христийн шашны байгууллагууд нь өөрийн байрандаа хүүхэд шавилан сургах хэлбэрийг ашиглахаас илүүтэй бямба, ням гарагт хурал, цуглаан, уншлага, ярилцлага зэрэг сүсэгтэн олонд зориулсан арга хэмжээ, мөн шашны сургаал номлолоо сурталчилах, ухуулан таниулах үйл ажиллагааг явуулдаг. Гэхдээ зарим шашны урсгал, чиглэлээс хамааран 18 насанд хүрсэн бол өөрийн гэрээс хол, сүм хийдэд сайн дурын, хүмүүнлэгийн шинжтэйгээр ажиллаж, амьдрах боломжтой бөгөөд түүний хичээл зүтгэлийг үнэлж, гадаад улсад байрлах шашны сургуульд суралцуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг байна. Буддын шашны байгууллагуудын тухайд хүүхдүүд гэрээсээ өглөө эрт хурал хурах цагт хийдэд ирэх буюу эсвэл ажлын өдрөөр хийддээ байрлах, амралтын өдрүүдэд гэртээ харих, мөн тухайн хийдийн дотуур байр, насанд хүрсэн лам нарын байранд хамт амьдрах зэргээр шавилан сууж байна.

Судалгаанд хамрагдсан шашны байгууллагуудад номын сан, биеийн тамирын заал, урлагийн танхим зэрэг соёл хүмүүжлийн ажилд зориулсан анги танхим хомс байхын зэрэгцээ хичээлийн дараа хүүхдүүд худаас ус зөөж, угаалга, цэвэрлэгээ хийдэг байна.

Буддын шашны байгууллагуудад суралцаж байгаа хүүхдүүдтэй хүндэтгэлтэй бус харьцаж зандрах, загнах явдал гаргадаг нь шалгалт, судалгаагаар тогтоогдов. Лам багш, удирдах албан хаагчаас гадна манаач, цэвэрлэгч, тогооч зэрэг хүмүүс өөрсдийн хийж гүйцэтгэх үүрэгт ажилдаа



суралцаж байгаа хүүхдүүдийг зарах, ширүүн харьцах, загнах, нэр хочоор дуудах, нудрах зэрэг байдал гаргадаг байна.

Ганцаарчилсан ярилцлагын үеэр хүүхдүүд ахмад хүний үгэнд орох ёстой, тэдний хэлснийг хийхгүй бол загнуулна, зодуулна, шийтгүүлнэ гэсэн бөгөөд өөрөөс ахмад хөвгүүд, багш, ажилтнуудын дэргэд ярихгүй байх, өөрийн санааг илэрхийлэхгүй чимээгүй өнгөрөх зэрэг үйл хөдлөл гаргасан нь хүүхдэд харилцааны таатай орчныг бүрдүүлээгүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Та нарт ямар шийтгэл голдуу хүлээлгэдэг вэ?	Хүүхэд	Хувь
а. Мөргүүлдэг	193	66.5
б. Сур, бүсээр шавхуурддаг	1	0.3
в. Цэвэрлэгээ хийлгэдэг	36	12.4
г. Хоол хийлгэдэг	0	0
д. Зоддог	3	1.0
е. Бусад	48	16.5

- Шийтгэдэггүй - 34
- Сануулж хэлдэг - 1
- Алдааг нь хэлж өгдөг - 1
- Хэлж ойлгуулдаг - 1
- Бургасаар ороолгодог - 1
- Загнадаг - 1
- Нясладаг - 2
- Эрхиддэг буюу эрхиэр ороолгодог - 4
- Хар хорхой авах буюу шилэн хүзүүнээс баздаг - 2
- Гар өргүүлдэг - 1

Шигтгээ:

...Бурхан шашинт Монгол эмзэгтэйчүүдийн Төгсбаясгалант хийдийн урилгаар Балбын Вант Улсын иргэн Намгяа Гомбо Боте (Дэнгээ лам гэх монгол нэршилтэй) нь 2006 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсад орж ирэн 2008 оны 02 дугаар сарын 21-ний өдөр хүртэл хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч байсан байна. Энэ хугацаанд 1999 онд төрсөн Монгол Улсын иргэн Т.М-г өөрийн багш Дандар Лхрамба Ринбүүчийн хойд дүрээр тодруулан 2010 оныг хүртэл Гандантэгчэнлин хийдийн хашаанд гэр барин шашны чиглэлээр сүсэгтэн олонд үйлчилгээ үзүүлж, түүнчлэн шавь сургалтаар Т.М-д шашны боловсрол олгож байжээ.

Тэрээр хүүг дөрвөн жилийн хугацаанд өөрийн дэргэдээ байлгаж байхдаа ном цээжилсэнгүй гэсэн шалтгаанаар 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зодож гэмтэл учруулсан байна. Т.М-ийн эцэг эх нь хүүгээ эргэж ирэхэд түүний нүүр толгой бие нь хөх няц болж хавдсан байсан зургийг нь авч энэ талаар ХЗДХЯ-д өргөдөл гаргасны дагуу ГИХАЭГ-аас холбогдох шалгалтыг хийжээ.

Шалгалтаар Балбын Вант Улсын иргэн Намгяа Гомбо Боте нь өөрийн багшийн хойд дүр хэмээн тодруулсан Т.М-ийн бие махбодод гэмтэл учруулсан болон Монгол Улсад байх хугацаандаа зөвшөөрөл авсан байгууллага дээрээ хөдөлмөр эрхлээгүйгээр зогсохгүй Монгол Улсад харьяалалгүй хүний статусаар оршин суух үнэмлэх авах гэж Балбын Вант Улсын иргэний харьяаллаас гарсан гэсэн хуурамч бичиг баримт бүрдүүлсэн болох нь тогтоогдсон байна. Түүнийг ард иргэдийн сүсэг бишрэлийг ашиглан хонжоо олох зорилгоор хууль бус үйл ажиллагаа явуулж байсан гэсэн үндэслэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 30 дугаар тушаалаар 10 жил Монгол Улсад орох эрхгүйгээр албадан гаргажээ...

Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газрын
2012 оны 1/1672 дугаар албан бичиг

Шигтгээ:

АНУ-д төвтэй “Алс Дорнодын элч” төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газар асран хамгаалж байгаа 29 хүүхэдтэй зүй бус харьцсан, дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсныг шүүхээс тогтоож үйл ажиллагааг нь зогсоожээ.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2010 оны 122 дугаар шийдвэр



Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн журам зохицуулалт байхгүйн зэрэгцээ насанд хүрэгчдэд зориулан гаргасан дотоод журмаа хүүхдүүдийг дагаж мөрдөхийг шаарддаг үзэгдэл нийтлэг байлаа. Лам багш, ажилтнуудын хувьд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар мэдлэг дутмаг байгаа нь ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үеэр хүүхдүүдийн хариултаас илэрхий байв.

Шашны сургууль, сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдийг лам багш, ажилтнуудаас гадна сүсэгтнүүд, үе тэнгийнхэн дарамтлах, дээрэлхэх, зодох, үг хэлээр доромжлох зэрэг үйлдэл гаргадаг байна. Мөн хүүхдийн эрх ашгийг хөндсөн ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд тэдний санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх талаар санаа тавьдаггүй байдал нийтлэг байна.

Шалгалтад хамрагдсан шашны байгууллагын 46 нь товч мэдээлэл төдий анкет бөглөснөөс цаашгүй байгаагаас харахад сүм хийдүүд суралцаж байгаа хүүхдийнхээ талаар дэлгэрэнгүй бүртгэл судалгаа хийдэггүй нь тодорхой байна. Түүнчлэн эцэг эхтэйгээ уулзаж, байнга холбоотой байж чадахгүй хүүхэд ч байна. Сүм хийдийн гэсгүй лам хүүхэдтэй холбоотой асуудлыг хариуцан ажилладаг боловч хүүхэд бүрийг тусгайлан анхаардаггүй, эцэг эх, ар гэртэй нь тогтмол холбоо барьдаггүй ажээ.

Эмнэлгийн үйлчилгээний хувьд тухайн орон нутгийн харьяа хэсгийн эмнэлэгт эсвэл сүм хийдийнхээ оточ, маарамбад үзүүлдэг байна. Зарим газарт мэргэжлийн зөвшөөрөлтэй эмчгүй, гадаадын сайн дурын ажилтан, эмчлэх эрхийн гэрчилгээгүй хүнийг эмчээр томилсон тохиолдол ч гарчээ. Мөн эм тарианы хангамжийн талаар анхан шатны ойлголцолгүй, эмчилгээ, үйлчилгээний наад захын тоног төхөөрөмжгүй байна.

Өвчин тусвал хэнд ханддаг вэ?	Хүүхэд	Хувь
а. Үе тэнгийнхэндээ	6	2.0
б. Ахлах ангийхандаа	2	0.6
в. Багшдаа	129	44.4
г. Эмчид	141	48.6
д. Ханддаггүй	6	2.0
Бөглөөгүй	6	2.0



Хэрвээ хүүхэд өвдвөл сүм хийдээс ямар арга хэмжээ авдаг вэ?	Хүүхэд	Хувь
а. Эм тан өгдөг	64	22.0
б. Эмчид үзүүлдэг	141	48.6
в. Эмнэлэгт очдог	97	33.4
г. Ямар нэгэн арга хэмжээ авдаггүй	8	2.7
д. Мэдэхгүй	21	7.2
е. Бусад	20	6.8
Бөглөөгүй	3	1.0

Манай улсад сүм хийдэд байнга шавилан сууж байгаа хүүхдийн тоо харьцангуй цөөн боловч энэ хүүхдүүд орчин цагийн хөгжил дэвшлээс ангид хоцорч, цаашид нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох мэдлэг, чадвар олж авч чадахгүйд хүрээд байна.

Сүм хийдэд шавилан суугаа хүүхдийн асуудал төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна үлдсэн хийгээд шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодгоос шалтгаалан эдгээр хүүхэд орчин цагийн шаардлагад нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүйн дээр тэдний зарим эрх зөрчигдөхөд хүрч байна. Сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй нь нэгэнт тодорхой байгаа учраас шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах шаардлагатай байна.

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

Монгол Улсын хууль тогтоомжийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн зохицуулалт нь Үндсэн хууль, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай зэрэг 35 хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр зэрэг үндэсний болон салбарын 20 хөтөлбөрөөс тус тус бүрдэж байна. Эдгээр зохицуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахад олон зүйлийг тусгажээ. Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн "...хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй,



...боловсрол эзэмшүүлэх арга хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлог, эрүүл мэнд... нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж нөхцөлөөр хангана” гэсэн зарчмын заалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон, тэдний эрхийг хангах боловсролын тогтолцоог хуульчилсан суурь зохицуулалт юм. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийн талаар дэлгэрэнгүй зохицуулалтыг тусгасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг хангахын тулд оролцогч улсуудын үүргийг тусгайлан тодорхойлсон байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг хангах талаар үндэсний хууль тогтоомжийн зарим заалтууд нь 2008 онд манай улсын соёрхон баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн үзэл баримтлалтай нийцэж байгаа ч конвенцийн үзэл баримтлалыг дордуулсан анхаарал хандуулах зохицуулалт байсаар байна. Тухайлбал, суралцагчийг зөвхөн эрүүл мэндээс хамааралт бие махбодын хүчин зүйлсээр үнэлж, эмнэлгийн загварыг ашигласан тул нийгмийн амьдралд оролцох оролцоогоор нь тодорхойлох нь зүйтэй¹¹.

Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлсон харьцуулалт

<p>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц</p>	<p>Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг</p>	<p>Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх хэсэг</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ.</p>

¹¹Хөгжлийн бэрхшээлийн талаарх эмнэлгийн загвар (Medical model of disability) гэдэгт аливаа өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүний өвчин, зовиурыг эмчлэх, түүнд эмнэлгийн үйлчилгээг сайтар үзүүлэхэд анхаарвал зохино гэж үздэг нийгэм-улс төрийн ойлголтыг илэрхийлнэ. Иймээс нийгмийн харилцаанд оролцох, татан оролцуулах тухай авч үздэггүй сул талтай болно.

Боловсролын тухай хуульд зааснаар иргэд суурь боловсролыг заавал үнэ төлбөргүйгээр эзэмших үүрэгтэй. 2011-2012 оны хичээлийн жилд нийт 752 ерөнхий боловсролын сургуульд 505,409 хүүхэд суралцаж байгаагийн сургуулийн өмнөх боловсролд 1,161, ерөнхий боловсролын сургуульд 18 гаруй мянга нь (харах эрхтний 7.5, сонсох эрхтний 2.8, хэл ярианы 2.6, оюун ухааны 1.5, бие эрхтний 2.1, хавсарсан хэлбэрийн 1.5 мянган хүүхэд) хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна¹². Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлийнх нь төрлөөс хамаарч боловсрол олгох зорилго бүхий тусгай сургуулиудад 2400 орчим хүүхэд суралцдаг талаар статистик тоо баримт байгаа¹³ бөгөөд эдгээр сургуулиудын үйл ажиллагааг Хүний эрхийн Үндэсний Комисс 2009 онд судлах явцад нийт 1218, 2012 онд 1618 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж байгаа мэдээ гарсан байна. Гэхдээ сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх улсын хэмжээний тоо тодорхойгүй байгааг анхаарч, ялангуяа хороод, багийн түвшинд хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрээр болон сургуулиас завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, мөн насанд хүрэгчдийн тоог нарийвчлан гаргах шаардлагатай байна.

2012 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын зургаан тусгай сургуульд¹⁴ хийсэн хяналт шалгалтаар эдгээр сургуулиудын барилга байгууламж хуучирсан, төрийн зүгээс иж бүрэн засвар хийх санхүүжилтийг олголгүй өдийг хүрч, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон амьдрах, суралцах хүртээмжтэй орчныг бүрдүүлж чадаагүй, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, нэг ангид суралцагчдын насны хэт зөрүүтэй (6-30 настай), сургалтын материал хүрэлцээгүй зэрэг дутагдал илэрлээ.

Сургуулиудын талаарх товч мэдээлэл (2012.12.03-ны өдрийн байдлаар)							
Тусгай сургуулийн дугаар	Байгуулсан он	Нийт суралцагчийн тоо (Үүнээс эмэгтэй)		Нийт багш, ажилтан	Нийт согог зүйч	Дотуур байртай эсэх	Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлтэй эсэх
25	1967	258	115	47	9	Байхгүй	Тийм. Зориулалтын бус 1 ширхэг
29	1964	325	153	115	-	Байгаа. 300 хүүхдийн багтаамжтай (162 суралцагч)	Үгүй

¹²Боловсрол, шинжлэх ухааны яам, Статистикийн үзүүлэлт 2011, УБ., 2012, 19 дэх тал.

¹³Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын гурав ба дөрөв дэх тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээх хөндлөнгийн илтгэл. УБ., 2008, 20 дахь тал.

¹⁴Сүхбаатар дүүргийн 25, 29, 116, Хан-Уул дүүргийн 63, Баянгол дүүргийн 70, Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулиуд



55	1976	530	-	58	4	Байхгүй	Үгүй
63	1975	215	100	44	3	Байхгүй	Тийм. Зориулалтын 24 хүний суудалтай 1 ширхэг
70	1977	208	-	29	8	Байхгүй	Үгүй
116	2004	83	45	53	3	Байгаа. 60 хүүхдийн багтаамжтай (59 суралцагч)	Үгүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэд заавал тусгай сургуульд суралцах шаардлагагүй, харин тухайн орны Засгийн газрын зүгээс тэднийг бусадтай хамт суралцах боломж бололцоог бүрдүүлэх үүрэг хүлээсний дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах чиглэлийг баримталж байгаа хэдий ч Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д "...хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно" гэж тухайлан зохицуулж, ердийн сургууль, цэцэрлэгт суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог багаар тогтоосон нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдарч буй орчиндоо суралцах талаар зохицуулсан конвенцийн заалттай зөрчилдөж, тэдний бусад хүүхдүүдтэй хэвийн харилцах боломжийг хязгаарлаж байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг дээрх сургуулиудыг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяаллаас гаргаж, дүүргийн харьяалалтай болгосноос санхүүжилтэд тавих улсын хэмжээний анхаарал суларч, бодлого алдагдсан байна.

Хяналт шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авах талаар Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам болон Эрүүл мэндийн яаманд Комиссын гишүүдийн 16 зүйл заалт бүхий шаардлагыг хүргүүлсэн (Хавсралт 2) ба шаардлагын мөрөөр холбогдох яамдаас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын (2012-2016) үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой асуудлууд тусгаж, биелэлтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор "Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох, тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журам"-ыг баталж, журамд "хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол

олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгохдоо нэг сурагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцох бөгөөд энэ заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарна; 3.4-т тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад гэр болон дотуур байрнаас суралцдаг хүүхдийг тээвэрлэх, дотуур байрны хоол, хүнсний бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дотуур байрны хүүхдийн эм тариа, ариутгал, халдваргүйжүүлэх зардлыг тухайн сургалтын байгууллагын тогтмол зардалд оруулж тооцон, жил бүрийн төсөвт тусган оруулна; 3.5-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш, арга зүйч, согог зүйч, нийгмийн ажилтан, сэргээн засалч зэрэг нарийн мэргэжлийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр тусгайлан сургаж, бэлтгэхтэй холбоотой зардлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухайн сургалтын байгууллагын жил бүрийн төсөвт тусган олгоно” гэж заасныг хэрэгжүүлж эхэлжээ. Түүнчлэн тусгай сургуулиудад ажиллаж байгаа боловсон хүчний хөдөлмөрийн нөхцөл байдлыг үнэлж, “Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-ыг шинэчлэн өөрчлөх боломжтой байна.

Боловсрол, шинжлэх ухааны яаманд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Боловсролын хүрээлэн болон Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтэд тусгай хэрэгцээт боловсролын асуудал хариуцсан эрдэм шинжилгээний ажилтныг тус тус бие даасан орон тоогоор ажиллуулахын зэрэгцээ согог зүйч багш нарыг дотооддоо бэлтгэх зорилгоор Монгол Улсын Боловсролын их сургуульд согог зүйч багшийн мэргэжлийн анги нээх, Нийслэлийн тусгай дунд сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тээвэрлэх зориулалтын тусгай автобустай болгох асуудлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлд тусган санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн, мөн тусгай хэрэгцээт боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, сурах бичгийг албан ёсоор зохион хэвлүүлэх зэрэг олон ажлыг эхлүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлийн 2-ийн с-д “хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах” хэмээн заасантай Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь ...хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэсэн нь нийцэж байна. Харин Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс хийсэн шалгалтын үеэр сургуулиудын барилгын гадна, доторхи байгууламж, зам, талбай,



шат зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцээгүй, хүртээмжгүй байна. Тухайлбал, тус сургуульд тэргэнцэртэй хүүхэд орох, нэвтрэх боломжгүй буюу тэдэнд зориулсан налуу зам, шат, цахилгаан өргүүр байхгүй байна.

Шигтгээ:

Дан ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаггүй. Харааны бэрхшээлтэй мөртлөө саажилттай хүүхэд байна. Эсвэл саажилттай, тэргэнцэр хэрэглэдэг хүүхэд ч бий. Манай сургуулийн хувьд зориулалтын шатгүй учраас хүүхдүүдээ багш нар, эсвэл хүүхдийнхээ хичээл гарахыг хүлээж суугаа эцэг эхчүүд нь гар дээрээ өргөн, хоёр давхарт гардаг.

*Зорилтот бүлгийн ярилцлага “Багш нар”,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар*

Цөөн тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг тусгай сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээ, суралцагчийн тоонд нийцсэн сургуулийн автобусгүй байна. Үндэсний хэмжээнд тусгай зориулалтын 24 хүний суудалтай нэг автобустай байгаа нь учир дутагдалтай байна. Өглөө хичээл эхлэхээс өмнө урьдчилан тогтоосон маршрутын дагуу хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авдаг боловч сургууль дээрээ ирэхдээ даарч хөрсөн, дагжиж бээрсэн байдалтай ирдэг талаар багш нар дурдаж байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хичээлдээ явах, хичээлийн дараа гэртээ харихад эцэг эх нь байнга хүргэж өгч авдаг. Зарим сурагчид ганцаараа сургуульдаа ирэх, гэртээ харих замдаа буудал андуурч буух, төөрөх, алга болох асуудал гардаг учраас сургуульдаа ирэх, гэртээ харихад үйлчлэх автобустай болгох шаардлагатай байна.

Урсгал засвар хийж, иж бүрэн нэгдсэн засвар хийгээгүй удсан тул зарим сургуулиудын дулааны шугам сүлжээ, ариун цэврийн байгууламж, агааржуулалт муудаж, суралцах орчинд сөргөөр нөлөөлж байна. Өвлийн цагт хүйтэн, цонх онгойлгон агааржуулах боломжгүй, бие засах өрөө хүртээмжгүй, зориулалтын бус байх зэрэг нийтлэг дутагдал шалгалтын үеэр ажиглагдсан юм. Хөгжлийн бэрхшээлээс хамаарч багш хүүхдүүдийг нэг нэгээр авч явж бие засуулахад бусад хүүхдийг хараа хяналтгүй үлдээх болдог нь хүндрэлтэй, бүх хүүхдүүдэд онцгой халамж шаардлагатай ажээ. Харин Хан-Уул дүүргийн 63 дугаар сургуулийн хувьд, маш хүйтэн, дулаан их алддаг, өвлийн цагт зузаан гутал хувцастайгаа хичээллэдэг байсан асуудлыг шийдвэрлэхийн тулд олон газар хандаж, төсөл бичиж, танилцуулсны үр дүнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Америкийн Нэгдсэн Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр (700 сая төгрөг) дулаан техникийн засварыг, дотоод заслыг



өөрсдийн нөөц бололцоо хамт олны хүчээр хийж 2012-2013 оны хичээлийн жилд бэлтгэн иж бүрэн засвар хийжээ. Үүнээс гадна нарны эрчим хүчээр усаа халааж, шүршүүрт орох боломжийг бүрдүүлэн халуун усны газартай болжээ. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулах, хүртээмжтэй орчныг бий болгоход чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөрийн санхүүжилт нь гадаад улсын хөгжлийн агентлаг, олон улсын байгууллагын байнгын бус эх үүсвэрээс хамаарч байгааг цаашид анхааран төрийн зүгээс төсөвт тодорхой санхүүжилт тусгах шаардлагатай.

Зарим сургуулийн ахлах ангийн хүүхдүүдэд хими, физик, биологийн хичээл ордог ч тусгайлан бэлдэж тохижуулсан өрөө тасалгаанд ордоггүй, өрөө тасалгаа хангалтгүй учраас дадлага хичээл ордоггүй гэсэн тайлбарыг багш нар өгч байлаа. Гол төлөв сургуулиуд суралцах орчныг тусгай хэрэгцээнд нийцүүлэн сайжруулахыг зорьдог ч дотуур байргүй, сургуулийн автобусгүй байхаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах онцлог, заах арга зүй, хүүхэд нэг бүртэй тулж ажиллах, үйлчлэх, сургууль дээрх аюулгүй байдлыг хангах зэргээс шалтгаалан туслах багш зайлшгүй байх шаардлагатай байдаг.

Шигтгээ:

Багш хүн оюуны бэрхшээлтэй нэг хүүхэдтэй ажиллах нь ердийн сургуулийн 5 хүүхэдтэй ажилласантай тэнцэх хэмжээний цаг хугацаа, ажиллагаа шаарддаг. Ердийн суруульд хүүхдүүд “Үсэглэлийн баяр” хийдэг бол манай сургуулийн хүүхдүүд “Нэрээ мэддэг болсны баяр” хийдэг юм шүү.

*Зорилтот бүлгийн ярилцлага “Багш нар”,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар*

Сургуулиудын удирдлага, багш нартай хийсэн ярилцлага, суралцагчдын дэлгэрэнгүй судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо нэмэгдсэн, нэг биш хавсарсан бэрхшээлтэй буюу сонсголын бэрхшээлтэйгээс гадна харааны болон хөнгөн, хүнд хэлбэрийн оюун ухааны хомсдолтой, хэл яриа, бие эрхтний согогтой хүүхдүүд суралцах болсон тул нэг багш 8-12 хүүхэдтэй ганцаарчлан ажиллахад хүндрэлтэй, ялангуяа бага ангийн багш нар их ачаалалтай ажиллаж байна. Зөвхөн сонсголын бэрхшээлтэй төдийгүй бусад олон төрлийн хавсарсан бэрхшээлтэй хүүхэд ирж суралцдаг тул анги дүүргэлтийг 6-10 хүүхэд байхаар бууруулах эсэхийг нарийвчлан тогтоох нь зүйтэй.



Дотуур байртай сургуулийн хувьд, суралцагч хүүхдүүд олноороо дотуур байранд амьдарч байгаагаас гадна харааны бэрхшээлээсээ, эсвэл санамсаргүй, болгоомжгүй үйлдлээс болж аливаа юмыг мөргөх, унах, гэмтэх, бэртэх нь их байдаг. Эдгээр хүүхдүүдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх техник, багаж хэрэгсэл байхгүй, жилд 108,900 төгрөгний эм төсөвлөдөг нь хэрэгцээг хангахгүй байх жишээтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бие эрхтний онцлогоос хамааран хурдан ядардаг, дархлаа султай, олон цагаар хичээллэхэд халуун хоол маш чухал байдаг тул Үдийн цай хөтөлбөрөөс Үдийн хоол хөтөлбөрийг ахлах ангийн суралцагчдад хүргэхэд төрийн зүгээс анхаарч ажиллаж байгааг сайшааж байна.

Мэргэжлийн согог зүйч багш боловсон хүчний нөөц дутмаг болж байна. Энэ нь багш нарын нийгмийн асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэдэггүй, зах зээлийн шаардлагад нийцсэн цалин, хөлсний зохицуулалтгүйгээс шалтгаалж байна. Мөн сургуулийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх жилийн зардал хүрэлдцдэггүй, тоног төхөөрөмж хангалтгүй байна.

Шигтгээ:

Согог заслын болон хүүхдийн хэл ярианы заслын хичээлийн үеэр нэг удаагийн амны зуулт хангалтгүй байдаг тул зуултаа дахин ашиглаж, спиртээр ариутган хэрэглэдэг...

Хүүхдийн шээсний үнэр, өтгөн шингэнээс илүүтэйгээр энэ хүүхдүүдийн талаарх олон нийтийн буруу хандлага, эцэг эхийн идэвх санаачлагагүй, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдал өөрчлөгдөж, сайжрах боломжийг олж харахгүй байх нь маш хэцүү байдаг...

*Зорилтот бүлгийн ярилцлага “Багш нар”,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар*

Шалгалтын үеэр тусгай сургуулиудад суралцаж байгаа суралцагч хүүхдүүдтэй зорилтот бүлгийн ярилцлага хийх үед багш, сургуулийн удирдлагын зүгээс ямар нэгэн харьцааны доголдолгүй, сургууль, хичээлдээ явах дуртай хэмээн ярьж байв. Эцэг эхчүүдийн зүгээс мөн адил багш, удирдлагын зүгээс ямар нэг зан харилцааны зөрчилтэй зүйл байхгүй, гаргасан санал хүсэлтийг нааштай хүлээж авч арга хэмжээ авдаг, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулж удирдлагад санал хүсэлтээ гаргадаг гэв. Ялангуяа хөгжлийн бэрхшээлийн төрлөөс үл хамааран тусгай сургуулиудад ажиллан хүүхдүүдэд боловсрол олгож байгаа багш нар чин сэтгэлээсээ өөрийн бие, амьдралыг үл хайхран ажилладаг нийтлэг дүр зураг харагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлийн 2-ийн d-д “ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах” гэж заасантай Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн “5.1.5-д “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардлыг сургалтын төрийн сан хариуцна” гэсэн нь бүрэн нийцэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлийн гол үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож буй боловсрол бусадтай харьцуулахад ижил түвшний чанартай байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг хангахад онцгойлон анхаарвал зохих асуудал бол бусадтай ижил чанарын боловсрол эзэмших явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу боловсрол эзэмшүүлнэ”¹⁵ гэж заасан байна. Гэтэл дээрх хуулийн холбогдох заалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чанартай боловсрол эзэмших хэрэгцээнд нь тулгуурласан биш, хөгжлийн бэрхшээлд нь тохирсон боловсрол эзэмшүүлэх гэсэн агуулгатай байна. Энэ нь хүний тэгш сурч боловсрох эрхийг зөрчиж байна. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс нь хамаарч ердийн сургуульд татан оруулах хэлбэрээр хүүхдийг сургахын зэрэгцээ хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуулиар боловсрол олгох явдлыг хөхиүлэн дэмжих нь зүйтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр зүйлийн 24.3-т “Брайль үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх...”, 24.3.b-д “дохионы хэл сургахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих” зэргээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа харааны болон

¹⁵Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг: “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.



сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн харилцааны хэлбэрийг дэмжих, дэлгэрүүлэх талаар зохицуулсан байна. Гэтэл Боловсролын багц хууль (Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль)-д уг асуудлыг хуульчлаагүйн улмаас дохионы хэл болон брайль үсгийг зөвхөн тусгай сургуулиудад зааж байна. Үүний улмаас харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн дунд бичиг үсэг тайлагдаагүй, бусадтай харилцах арга барил, дадал эзэмшээгүй хүн нилээд олон байна.

Тусгай сургуулиудын харааны, сонсголын бэрхшээл, оюуны хомсдолтой хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сурах бичиг дутмаг, хүрэхгүй байгаа төдийгүй ердийн сургуулийн сурах бичгийг анги бууруулж үзэх, өөрийн нөөц бололцоонд тулгуурлан сурах бичиг хийх байдлаар хичээлээ заадаг байна. Мөн сургуулийн гадна, дотор орчин, ойр хавийн хүртээмжийг бүрдүүлж чадаагүйгээс гадна сургуулийн эзэмшлийн газар хувийн аж ахуйн мэдэлд орсон, суралцагчдын сурах үйл явцыг дэмжих зорилготой талбайг өөр зорилгоор, тухайлбал машины зогсоол гэх мэтээр ашиглаж байгаад тусгайлан анхаарал хандуулах нь зүйтэй.

2.3. Хурдан морь унаач хүүхдүүд

Сүүлийн жилүүдэд хурдан морины уралдаан зөвхөн үндэсний их баяр наадмаар хязгаарлагдахаа больж бүх түвшинд зохиогдох болсон нь түүх, соёл, уламжлалаа түгээн дэлгэрүүлж буй сайн талтай ч хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирч, аюулгүй байдал нь хангагдахгүй байгаад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс санаа зовниж байна.

Комиссын зүгээс хурдан морь унаач хүүхдийн эрхийн талаар, ялангуяа хуулиар тогтоосон наснаас бага насны хүүхдээр хурдан морь унуулсан, даатгалд хамруулаагүй, хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсүүлээгүй бол буруутай этгээдэд захиргааны журмаар торгууль ногдуулдаг, дээрх шаардлагыг хангаагүйн улмаас хүүхдийн биед гэмтэл учруулсан, амь нас нь хохирсон бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт бий болгох талаар 2003, 2008, 2010 онд Улсын Их Хуралд илтгэсэн. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 2010 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1501 дүгээр хуралдаанаар Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс дорвитой арга хэмжээг өнөөдрийг хүртэл авч хэрэгжүүлээгүй байна.



НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дээрх зөвлөмжид "...Хурдан морь унаач хүүхдүүд гэмтэх, амиа алдах зэргээр гэнэтийн ослын хохирогч болсоор байгаа, мөн зам тээврийн осолд орох, морь болон бусад гаршуулсан амьтан унаж байгаад осолдох зэргээр хүүхдүүд хохирох нь нэмэгдсээр байгаад харамсаж байна."¹⁶ гээд хүүхэд бүрийн амьд явах эрхийг хамгаалахад бүх хүчин чармайлтаа дайчлах, ослоос сэргийлэхтэй холбоотой олон нийтийн дунд мэдээлэл түгээх, кампанит ажил өрнүүлэх зэргээр олон нийтийн мэдлэг нэмэгдүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэн сайжруулах, осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн эрүүл мэндийн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөж байсан болно.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд хүүхдийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчмыг тодорхойлохдоо төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэх ёстойг хуульчилсан хэдий ч бодит амьдрал дээр энэ нь хэрэгжихгүй байна. Иргэд, уяач, даатгалын байгууллага болон бусад этгээдийн зүгээс хүүхдийн аюулгүй байдлыг хангах тал дээр гаргаж буй санаачилга харилцан адилгүй байна. Тухайлбал, уралдаанд орох хүүхдийн нас, унах морьдын тоо, хамгаалах хэрэгсэл, ослын даатгал, нөхөн олговор, зайдан унах, хүүхдийг унагахгүйн тулд хөлийг бэхлэх, хүүхдийн хөгжилд нөлөөлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг гэр бүл, эцэг эх, уяачид сайн мэддэг ч эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлд санаачилга гаргахгүй байна.

Иймээс хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний эрхийг зөрчсөн, хохирол учруулсан бол хариуцлага тооцох эрх зүйн хэм хэмжээг цаг алдалгүй тогтоох шаардлагатай байна.

Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр"-ийн хүүхдийн эрхэд суурилах зарчимд нийцүүлэн хүүхдийн хөдөлмөрийг багасгах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгээр хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах үндэсний стандартыг боловсруулан баталгаажуулж мөрдүүлэх, хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах ажлыг зохион байгуулах асуудал багтаж энэ ажлын хүрээнд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолоор "Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас,

¹⁶Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл. 2 дугаар боть УБ., 2012. 355 дахь тал.



морины хэрэгсэлд тавих шаардлага¹⁷ (MNS 6264-2011) стандартыг баталж, 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлснээр тусгай хэрэгсэл хэрэглэх, аюулгүй байдлыг хангахад ахиц дэвшил гарсан хэдий ч уг стандартын хэрэгжилт нэн хангалтгүйн дээр хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах ажил зохион байгуулсангүй.

Түүнчлэн дээрх стандартын бүх шаардлагыг заавал мөрдөхөөр заасан ба Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон үндэсний стандартыг заавал мөрдөнө.” гэж зохицуулсан байна. Гэвч тус хуулийн 27.1.3-т зааснаар заавал дагаж мөрдөх стандартыг мөрдөөгүй иргэнийг 10000-20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50,000-100,000 төгрөгөөр торгох хариуцлага хүлээлгэхээр байгаа нь хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэндийг үнэгүйдүүлэх нэг шалтгаан болж байна.

Орчин цагт Монголын уламжлалт хурдан морины уралдааны зорилго, хамрах хүрээ ихээхэн өөрчлөгдөж, зах зээлийн шинж төрхтэйгээр баяр наадам, ой тэмдэглэх үйл ажиллагаа, бооцоот уралдааны тоо ихэсч, өвөл зунгүй хурдан морины уралдаан зохиогдох боллоо. Тойм байдлаар авч үзэхэд жилдээ тэмдэглэлт ойгоос хамааран 60-90 баяр наадам болж байна. Хэдийгээр өвлийн улиралд морь уралдуулахыг хориглосон ч орон нутгийн хэмжээнд зохион байгуулсаар байгааг сануулах нь зүйтэй.

Хурдан морь унаач хүүхдэд тулгамддаг өөр нэг чухал асуудал бол тэдний хөдөлмөрийн үнэлгээ юм. Анх Засгийн газрын 2005 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм”-д хурдан морины бай шагналын 20-оос дээш хувийг хурдан морь унаач хүүхдэд олгохоор заасан байна. Харин бодит амьдрал дээр уралдаанд оролцсон хэдэн зуун морьдын 30 хүртэлх хувьд нь бай шагнал олгож байгаа бөгөөд үлдсэн ихэнх морьдыг унасан хүүхдүүд ямар нэг урамшуулал, хөлсгүй үлдэж байна. Түүнчлэн энэхүү дүрмээр гагцхүү үндэсний их баяр наадам, Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдах уралдаанд хамаарахаар зохицуулсан тул хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчин үгүйлэгдэж байна.

Бага насны хүүхдүүд хурдан морь унах нь түүний амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэл учруулсаар байна. Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотой морь малаас унаж бэртэх зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол хөдөө, орон нутгийн иргэдийн дунд түгээмэл байна. Түүнчлэн, өвөл, зуны аль ч улиралд өргөнөөр зохион

¹⁷http://standard.gov.mn/index.php?module=menu&cmd=content&menu_id=114&id=330



байгуулагдах болсон хурдан морины уралдааны үеэр хүүхэд бэртэх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол ихэсч байна.

Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Баяр наадмын хурдан морийг 7-гоос дээш насны хүүхэд унах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байна.” гэж тодорхой заасан атал 2010 оны Үндэсний их баяр наадмын үеэр Хүүхдийн Төлөө Газар 21 аймагт болсон хурдан морины уралдаанд морь унасан хүүхдүүдийн дунд судалгаа хийхэд 5-7 настай хүүхэд хурдан морь унасан тохиолдол гарсан ба 2010 оны Үндэсний их баяр наадмын үеэр хөдөө, орон нутгийн уралдаанд нийт 14,180 хүүхэд хурдан морь унасны 9716 нь буюу 68,5 хувь нь гэнэтийн ослын даатгалд хамрагдаагүй байсан болно.¹⁸

2005 оны Засгийн газрын 119 дүгээр тогтоолоор “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм”-ийг баталсан ба уг дүрмийн 3.1.7-д “уяач нь унаач хүүхдийн төрсний гэрчилгээ болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг бүрдүүлсэн байх;” үүргийг хүлээсэн атал 2010 оны улсын баяр наадмын орон нутаг дахь морин уралдаанд бүртгүүлсэн нийт хүүхдийн 50.8 хувь нь уралдахаар бүртгүүлэхдээ төрсний гэрчилгээгүй, Хүй долоон худагт болсон Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд 1185 хүүхэд морь унасны ердөө 12 нь л төрсний гэрчилгээтэй байсан тоо баримт байна.¹⁹

Өвлийн улиралд морин уралдаан зохион байгуулахад аюул, эрсдэл өндөр байдаг ба зөвхөн 2013 оны хаврын эхэн сарын шинийн 3-наас хойш бүх бүсийн болон аймгийн уламжлалт 30 гаруй морин уралдаан зохиогдож, одоогийн байдлаар эдгээр уралдаанд оролцсон хурдан морь унаач хүүхдүүдээс 70 орчим нь мориноосоо унаж, 15 нь бие эрхтэндээ хүнд гэмтэл авч, 2 хүүхэд амь насаа алдсан гэсэн тоо мэдээ байна. Эдгээрээс хамгийн сүүлд 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Ховд аймгийн Жаргалант сумын нутагт зохион байгуулсан Зэвсэгт хүчний цэргийн 123 дугаар ангийн нэрэмжит хурдан азарганы уралдааны үед гарааны зайд нэг хүүхэд мориндоо чирэгдэж амь насаа алдсан эмгэнэлтэй хэрэг гарлаа.

“Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм” нь үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааныг бүх түвшинд болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулах шигшмэл, бүсийн хэмжээний уралдааныг зохион байгуулахад нэгэн адил мөрдөгддөг бөгөөд уг дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5.1-т хурдан морины уралдааныг зохион

¹⁸Хүүхдийн Төлөө Газар “Үндэсний баяр наадмын хурдан морины уралдаанд хийсэн мониторинг” УБ, 2010.

¹⁹Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэл, УБ, 2010.



байгуулах үүрэгтэй Хурдан морины уралдааны салбар хороонд баяр наадам эхлэхээс 10 хоногийн өмнө морины бэлчээр, худаг ус, морь шүдлэх цэг, уралдах замыг (замын дагуух бартаа, гуу жалга гэх мэт) үзэж засан сайжруулах, цэвэрлэх болон холбогдох бусад арга хэмжээг авахыг үүрэг болгосон хэдий ч өвлийн цагт болж буй морин уралдаануудад гол төлөв цас, мөсөн дээр хурдан морь хальтрах, тэнцвэрээ алдсанаас болж хурдан морь унаач хүүхэд бэртэх гэмтэх, амь насаа алдах шалтгаан болж байгааг анхаарч цаашид үндэсний, бүсийн, орон нутгийн шинжтэй уралдааныг өвлийн улиралд зохион байгуулахыг хатуу хориглох шаардлагатай байна.

Иймд Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасны дагуу хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай байдгийг цохон тэмдэглэж, хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь чухлаас гадна өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангалтгүйгээс шалтгаалж, хурдан морь унаач хүүхэд амь насаа алдах, бие эрхтэн, эрүүл мэндээрээ хохирч, эрх нь ноцтойгоор зөрчигдөж байгаад анхаарал хандуулан ажиллах шаардлага тулгамдаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ЛГБТ ХҮМҮҮСИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалт)

“Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь заалт)

“Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1 дэх заалт)

Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйл)

Орчин үед “бэлгийн цөөнх” гэж нэрлэгдэх лесбиян²⁰, гей²¹, бисексуал²², трансжендэр²³ болон интерсекс²⁴ (цаашид ЛГБТ²⁵ хүн гэх)

²⁰Эмэгтэй хүн эмэгтэй хүндээ сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар юм.

²¹Эрэгтэй хүн эрэгтэй хүндээ сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар юм.

²²Аль аль хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх гүн гүнзгий мөн чанар, чадвар юм.

²³Өөрийнхөө хүйсийг төрсөн хүйсээсээ өөрөөр буюу эсрэгээр гүн гүнзгий мэдэрч, тодорхойлж, тэр тодорхойлсноороо амьдардаг хүн. Бэлгийн чиг баримжааны хувьд трансжендэр хүмүүс стрэйт, лесбиян, гей, бисексуал байж болдог.

²⁴Аль аль хүйсийн анхдагч болон хоёрдогч бэлгийн шинж чанарыг буюу хромосом, гонад болон бэлэг эрхтэний хувьд эр, эм аль хүйст хамаарахыг нь хэлэх боломжгүй хүмүүс. ХҮ хромосомт эр, ХХ хромосомт эм гэдгээс хальсан бүх бусад хромосомын генотип, бэлгийн фенотип байдлыг интерсекс гэнэ. Монголчууд эртнээс интерсекс хүмүүсийг “манин” хэмээн нэрийдсээр ирсэн ч энэхүү нэр томъёо нь орчин цагт ихэвчлэн ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийг буруугаар нэрлэх сөрөг нэр томъёо болсон тул олон улсын нэр томъёо болох интерсекс хэмээх нэр томъёог ашиглах нь зүйтэй.

²⁵Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс зэрэг бэлгийн цөөнхийг нэрлэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо, товчлол. Энэ нь ижил хүйсийн бэлгийн зан үйл, харилцаа, хүйсийн онцлог шинжийг илэрхийлнэ. ХЭҮК, “ЛГБТ Төв” ТББ, “Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа., 2012.



хүмүүс аль ч улс оронд амьдардаг. Тухайн улсын нийт хүн амын 10 гаруй хувийг лесбиян, гей, бисексуал, трансжендер хүмүүс эзэлдэг гэсэн судалгааны дүн байдаг боловч, улс тус бүрээр нь авч үзвэл энэ тоо харилцан адилгүй байдаг ажээ²⁶.

Бэлгийн чиг баримжаа²⁷, хүйсийн баримжаа илэрхийлэл²⁸ нь төрөлхийн бөгөөд өөрчлөгддөггүй гэдгийг дэлхийн олон эрдэмтэн судлаачид тогтоосон байна. Улмаар 1973 онд АНУ-ын Сэтгэл судлаачдын холбоо бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний жагсаалтаас²⁹, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 1990 онд тус тус хасчээ³⁰. Ингэснээр “сэтгэцийн өвчин, гаж үзэгдэл биш” гэдгийг нотолж, эдгээр хүмүүсийн эрх, эрх чөлөөг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна.

Өнөөдөр ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн төлөв байдал, тэдний улс төрийн оролцоо, ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа бүхий хосуудын гэрлэлт, трансжендер иргэдийн хүйсийн шилжилт, эрүүл мэндтэй холбоотой асуудлууд нь НҮБ-ын хүний эрхийн механизмд ч, бүс нутгийн түвшинд ч анхаарлын төвд байсаар байна³¹.

Улс орнуудад ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд олон байдаг. Түүнчлэн эдгээр хүмүүсийн эрх, эрх чөлөөний асуудлаар олон улсын түвшинд ажилладаг байгууллагууд ч хүрээгээ тэлж НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын түвшинд яригдах болжээ.

“Хүмүүс зөвхөн ЛГБТ байсныхаа төлөө хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөж буй явдлыг бид харж байна. Ажлын байр ч, сургууль дээр ч, эмнэлэгт ч энэ хандлага түгээмэл байхын зэрэгцээ сэтгэл сэрдхийм халдлага, түүний дотор бэлгийн хүчирхийлэл тохиолдож байна. Хүмүүсийг шоронд хорьж, эрүүдэн шүүж, бүр үхүүлж байна. Энэ бол үүнд өртөж буй хүмүүст гашуун эмгэнэл, бидний хамтын ухамсарт

²⁶<http://www.gallup.com/poll/6961/what-percentage-population-gay.aspx>

²⁷“Бэлгийн чиг баримжаа” нь эсрэг, ижил эсвэл нэгээс илүү хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харьцаа үүсгэх хүн бүрийн гүн гүнзгий мөн чанар, чадвар юм. Жогжакартын зарчмууд., 2006.

²⁸“Хүйсийн баримжаа илэрхийлэл” нь хүн бүр хувь хүнийхээ үүднээс төрөхөд өгөгдсөн хүйстэйгээ адлаар эсвэл өөрөөр өөрийн хүйсээ гүн гүнзгий мэдрэх мэдрэмж ба өөрийн биеийн тухай мэдрэмж (үүнд чөлөөг сонголтгоор биеийнхээ үзэгдэх байдлыг эм, хагалгаа болон бусад замаар өөрчлөх өөрчлөлт багтана), хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөн гэх мэт хүйсийн бусад илэрхийлэл багтана. Жогжакартын зарчмууд., 2006.

²⁹Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны анагаах ухааны тодорхойлолтын хувьсал, Корнеллын их сургууль: <https://confluence.cornell.edu/display/WWC/The+Evolution+of+the+Medical+Definition+of+Homosexuality>

³⁰Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа ба сэтгэл санааны эрүүл мэндийн тухай баримтууд: http://psychology.ucdavis.edu/rainbow/html/facts_mental_health.html

³¹Бидний асуудлууд, Гей, лесбиян олон улсын хүний эрхийн комисс: <http://www.ighrc.org/cgi-bin/iowa/content/globalissues/index.html>



үлдэж буй хар толбо юм. Энэ бол олон улсын хуулийг зөрчиж байгаа хэрэг. ЛГБТ хүнд хандаж хэлэхэд та нар ганцаараа биш. Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг эцэс болгохын төлөөх та бүхний тэмцэл бол хамтын тэмцэл. Та бүхэнд ирж байгаа халдлага дайралт бол НҮБ-ын болон миний биеийн хамгаалан босч, сахиулан мөрдүүлэхээр тангараг өргөсөн түгээмэл үнэт зүйлст халдаж байгаа хэрэг мөн. Би өнөөдөр та нартай хамт байна. Би манай гарагийн орон бүхэн, ард түмнийг та нартай хамт байхыг мөн уриалж байна”

*НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн
Хүний эрхийн зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 7-ны
өдрийн хурал дээр тавьсан илтгэлээс*

Монгол Улсад ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн чиглэлээр дагнан ажилладаг “ЛГБТ Төв”, ХДХВ/ДОХ/БЗХӨ-ний урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг “Залуус эрүүл мэнд Төв”, Хамтдаа Төв”, “Дэмжих Төв” гэсэн төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн “МОНФЕМНЕТ” Үндэсний сүлжээ, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Нээлттэй нийгэм форум”, “Хүний эрх хөгжил төв”, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, “Эмнести интернэшнл”, “Глоб интернэшнл” зэрэг хүний эрхийн байгууллагууд ЛГБТ хүний эрхийн асуудалд анхааран ажиллаж байна.

Монголчуудын уламжлал, зан заншил болон нийгмийн сэтгэлгээнд тохирохгүй гэсэн хандлагыг өөрчилж эдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлж, эрх, эрх чөлөөг нь бодитойгоор эдлүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай боллоо.

НҮБ-ын тогтолцооны байгууллага, олон улсын байгууллага, монголын төрийн бус байгууллагуудаас Хүний эрхийн Үндэсний Комисст хандаж, удаа дараа асуудал тавьж байсан учраас 2012 онд НҮБХХ-ийн “Монгол Улсад хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгааг “ЛГБТ Төв” ТББ-тай хамтран хийсэн билээ. Мөн сүүлийн жилүүдэд Комисс эдгээр хүмүүсийн эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр “ЛГБТ Төв” ТББ-ыг албан ёсоор бүртгүүлэх, ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн зөрчлийг баримтжуулах, Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Ази Номхон Далайн бүс нутгийн чуулганы санхүүгийн дэмжлэгтэйгээр цагдаа, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна.



НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 17/19 дүгээр тогтоолоор Хүний эрхийн Дээд Комиссарт хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн улмаас хүчирхийлэл, хүний эрхийн зөрчилд хүргэж байгаа улс орнуудын ялгаварлан гадуурхалтын хууль, практикийг баримтжуулах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл дээр үндэслэсэн хүчирхийллийг таслан зогсооход олон улсын хүний эрхийн хуулиудыг хэрхэн хэрэглэх талаар судалж илтгэхийг үүрэг болгожээ. Үүний дагуу 2011 оны 12 дугаар сард НҮБ-ын түүхэнд анх удаа ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчлийн талаар хийсэн тайланг НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссар Хатагтай Нави Пиллай танилцуулсан байна.

Манай улсад 2010 онд “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл “ЛГБТ Төв”-тэй хамтарч “Бэлгийн цөөнхийн хүүхэд, залуусын сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ?” кейс цуглуулга ба дүн шинжилгээг, мөн Жонс Хопкинсын их сургууль, Монгол Улс дахь НҮБ-ын ДОХ-той тэмцэх Үндэсний хөтөлбөртэй (ЮНЕЙДС) хамтарч 2010 онд “Монгол Улсад Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн (ЭБЭ) дунд ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэл, тусламж үйлчилгээний хүртээмж, хүний эрхийн асуудлыг судалсан нэг агшны судалгаа”-г тус тус хийсэн байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн судалгаа нь ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхаж буй шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, ЛГБТ хүмүүсийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг тодорхойлоход чиглэсэн юм.

Судалгаанд Улаанбаатар хот, Дархан-уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сумын давхардсан тоогоор нийт 138 иргэн хамрагдсаны 78 нь төрийн албан хаагч (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, багш, эмч, нийгмийн ажилтан), 60 нь ЛГБТ хүмүүс оролцсон. ЛГБТ хүмүүсийн 76.7% нь Улаанбаатар хот, 20% нь хөдөө орон нутагт, 3.4% нь гадаадад амьдарч буй монгол хүмүүс хамрагдав. Хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд авч үзвэл эрэгтэй 50%, эмэгтэй 31.7%, транс эмэгтэй 11.7%, транс эрэгтэй 6.7% байсан ба 18-23 насны хүмүүс 28.3%, 24-29 насны хүмүүс 26.7%, 30-35 насны хүмүүс 26.7%, 36 ба түүнээс дээш насныхан ойролцоогоор 18.3% байв. Бэлгийн чиг баримжааны хувьд оролцогчдын 35% нь өөрсдийгөө гей (1.7%-ийг эзлэх трансгей багтсан), 25% өөрсдийгөө лесбиян (3.3%-ийг эзлэх транслесбиян багтсан), 35% өөрсдийгөө бисексуал, 5% өөрсдийгөө гетеросексуал хэмээн тодорхойлсон. Оролцогчдыг боловсролын түвшингээр авч үзвэл 65% нь дээд, 26.7% нь бүрэн дунд, 5% нь бага, 3.3% нь тусгай дунд боловсролтой хүмүүс байв.



3.1. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн асуудал

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлдээ үндэслэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүгээр хүн бүр хүний бүх эрхээ эдлэх эрхтэй.³²

2011 оны 3 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжинд “нийгмийн зүгээс ЛГБТ хүмүүсийг ялгаварлаж байгаа асуудал дээр Монгол Улс яаралтай арга хэмжээ авах”-ыг үүрэг болгосон байдаг ч энэ талаар дорвитой ажил хийгдээгүй нийгэм, гэр бүл, хамт олны зүгээс тэднийг хүлээн зөвшөөрөхгүйгээс ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна.

Шигтгээ:

Нэгэн гей залуу 1999 оны 3-р сард ижил хүйстэн эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах зорилгоор байгуулагдаж байсан Тавилан ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэг ба 1999 оны 4-р сард гей хүмүүсийн эрх зөрчигдөж буй талаар “Сэрүүлэг” сонинд ярилцлага өгснөөсөө болж “Ингээд гомотож яв” хэмээн төрсөн ахдаа хөлөө хугалуулж байсан.

О.Г. нь лесбиян ба 1994 оны 9-р сард лесбиян гэдгээсээ болж төрсөн ахдаа хэвтэрт ортлоо зодуулж байсан. Үүнээс болж олон жил гэрийнхэнтэйгээ холбоогүй явсан. Тэрээр 19 насандаа хүүхэдтэй болохын тулд эрэгтэй хүнтэй хамтран амьдарсан ба түүнд өөрийнхөө бэлгийн чиг баримжааны тухай хэлж байгаагүй. Нөхөр байсан хүн нь 2005 онд Монголд ирээд түүнийг лесбиян гэдгийг нь хүнээс олж мэдээд О.Г.-г ална хэмээн сүрдүүлж байсан.

МИЛК Төвийн баримтжуулалт, 2006 он хувийн архиваас

Судалгаанд “ЛГБТ хүмүүсийг манай нийгэм хэр хүлээн зөвшөөрдөг бэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогч нийт 60 ЛГБТ хүмүүсийн 95% нь “огт хүлээн зөвшөөрдөггүй” гэж хариулсан байна.

Энэ талаар судалгаанд оролцогч төрийн албан хаагчдаас тодруулахад 45% нь “мэдэхгүй”, 36.7% нь “үгүй”, 18.3% нь “тийм” гэж хариулсан байна.

Нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байдал нь дарамт шахалт байдлаар ихэвчлэн илэрдэг байна. Фокус бүлгийн ярилцлагаар ямар хэлбэрийн дарамт, шахалт байдаг талаар тодруулахад: гутаан доромжлох, өөрийн үзэл бодлоо тулгах, хэл амаар доромжлох, зодох, хүч хэрэглэх байдлаар илэрч байна гэжээ.

³²Жогжакартын зарчим 2, Жогжакартын зарчмууд., УБ., 2012.



Шигтгээ:

“Багаасаа л охин шиг, дандаа охидтой тоглодог байсан болохоор байрныхан нь янз бүр хэлдэг. Гэртээ харьж явахдаа хаанаас хэн гарч ирээд зодчих бол гэж байнга айдаг байсан.”

“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, Трансжендер эрэгтэйтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он

Шигтгээ:

“Гэрлэх нас болж буй тухай сануулга аймаар санагддаг, учир нь “гэрлэх нас боллоо, нөхөрт гарах болоогүй юу, нөхөрт гараач” гэх хүмүүс олон байдаг.”

“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, Трансжендер эмэгтэйтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он

Судалгаанд оролцогчдын 73.3% цагаачлах талаар урьд өмнө нь бодож байсан бөгөөд энэ тухайгаа тэд нийгмийн зүгээс ойлгохгүй байгаатай холбон тайлбарласнаас үзэхэд ЛГБТ хүмүүсийн өртдөг энэхүү дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт нь тэднийг эх орноосоо дайжин явах алхамд хүргэж байна.

Шигтгээ:

“Монголын нийгэм нээлттэй сайхан бол хэн ч эх орноосоо явахыг хүсэхгүй, гэхдээ нөхцөл байдал хүнд л байна. ЛГБТ байдлаасаа болоод ямар ч шударга ёсыг олж мэдрэхгүй байгаа тохиолдолд цагаачлах ч биш, бүр дүрвээд явмаар санагддаг.”

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
Гей залуутай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

Судалгаанд оролцсон 60 ЛГБТ хүний 71.7% нь бэлгийн цөөнхөд хамаарагддаг болохоо гэр орон, анги болон ажлын хамт олноосоо нуудаг гэжээ. Нуудаг гол шалтгаан нь “ойлгохгүй доог тохуу хийхээс нь эмээдэг, гэр бүлийн нь нэр хүнд унахаас айдаг, нийгэмд эзлэх байр суурьгүй болохоос эмээдэг, эрх зүйн орчин бүрдээгүй байгаа тул өөрийнхөө аюулгүй байдлыг хангах үүднээс нуух шаардлага гардаг” гэжээ.

Судалгаанд оролцогч төрийн 78 албан хаагчдаас авсан санал асуулгаар “Танд ЛГБТ хүнтэй тулж харьцахад ямар санагдах вэ?” гэсэн асуултанд 55% нь “энгийн”, 35% нь “ерөнхийдөө тухгүй”, 8.3% нь “маш тухгүй”, 1.7% нь “ерөнхийдөө тухтай” гэжээ.



Мөн судалгаанаас харахад ЛГБТ хүмүүс нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөхөөс гадна тэдний хамгийн ойр дотны хүмүүс болох гэр бүлийнхэн нь энэ байдлыг ойлгохгүй хүлээн зөвшөөрдөггүйгээс айдас, хүчирхийлэл, дарамт дор амьдарч байна.

“Гэр орны нөхцөлд ялгаварлан гадуурхалтад өртөж байсан уу?” гэдгийг тодруулахад судалгаанд оролцогчдын 86.7% нь гэр орныхондоо хэлээгүй, хэлэхээс эмээдэг гэсэн байна.

Шигтгээ:

“Намайг ингээд л төрчихсөн гэдгийг ойлгохгүй байгаа гэр бүлийнхэнтэйгээ ярихыг хүсдэггүй ч тэднээс санхүүгийн хувьд хараат, бие даан амьдрах боломжгүйгээс өдөр болгон гэртээ орохдоо хөндий хүйтэн, намайг үзэн ядсан мэт хүмүүсийн дунд ордог. Амиа хорлочихвол эд нар уйлах болов уу, намайг алсан гэж бодох болов уу ч гэж хааяа боддог. Жаахан л юм болвол “Гаж донтон” гээд орилоод “Уруу татсан хүнийхээ нэрийг хэл” гэдэг. Гэтэл би ингээд л төрчихсөн, ухаан орохоосоо л ийм байсан гэж хэлээд ойлгодоггүй. “Чамайг төрүүлсэндээ харамсдаг” гэж ээж, ааваасаа сонсох шиг аймаар зүйл байхгүй. “Муу амьд явснаас үхчихээсэй” гэж хоорондоо ярьж байхыг нь ч сонссон. Хааяа дэндүү аймаар санагддаг, амиа ч хорломоор үе зөндөө байсан.”

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

Шигтгээ:

Б.П. нь гей залуу ба 2005 оны 4-р сард цагдаагийн газар ажилладаг нагац ах нь түүнийг Бээжинд гадаад эртэй хамт амьдардгийг нь сонсоод гэртээ дуудан авч ирж байгаад бороохойгоор зоджээ. Түүний их бие болон гуя, өгзөг хэсгээр маш их бяцралт үүссэн байна. Тэрээр маргааш нь “Хамаатан садангаа, дээрээс нь цагдаад ажилладаг хүнийг яаж цагдаад өгөх вэ” гээд Монголоос явсан байна.

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

ЛГБТ хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртөж буй гол шалтгааны нэг нь эдгээр хүмүүсийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг ойлголт хангалтгүй, ЛГБТ төв зэрэг төрийн бус байгууллагаас өөр энэ чиглэлээр ойлголт, мэдээлэл өгдөг байгууллага хомс байна.

Судалгаанд оролцогч төрийн албан хаагчдаас авсан санал асуулгаар “ЛГБТ хүмүүсийн талаар олон нийтийн мэдлэг, мэдээлэл



хангалттай байдаг уу?” гэсэн асуултанд 78.4% “бага зэрэг”, 16.6% нь “огт үгүй”, 5% нь “хангалттай гэж хариулжээ.

Түүнчлэн “ЛГБТ хүмүүс өөрийн дур зоргоор бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээ сонгодог гэж боддог уу?” гэсэн асуултанд 46.7% нь “үгүй”, 45% нь “мэдэхгүй”, 8.3% нь “тийм” гэжээ.

Үүнээс үзэхэд, ЛГБТ хүмүүсийн талаар олон нийтийн мэдлэг ойлголт хангалтгүйгээс ЛГБТ хүний талаарх нийгэмд сөрөг ойлголт, хандлага давамгайлж улмаар ялгаварлан гадуурхалтыг бий болгож байна. Ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй ЛГБТ хүний халдашгүй дархан байх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, гэр бүл болох, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, хөдөлмөрлөх зэрэг эрхүүд нь зөрчигдөж байна.

3.2. Гэр бүл үүсгэх эрхийн асуудал

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээ үл хамааран хүн бүр гэр бүл үүсгэх, гэр бүл болох эрхтэй. Гэр бүлийн олон хэлбэр бий. Гэр бүлийн аль ч гишүүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн ямар ч гэр бүлийг ялгаварлан гадуурхах ёсгүй.³³

Монгол Улсын 1991 онд нэгдэн орсон “Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц”-ийн албан ёсны англи хэл дээрх текстийн 2 дугаар зүйлд: Marriage shall be entered into only with the free and full consent of the intending spouses³⁴, гэдгийг “эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй бүрэн харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрлэж болно” гэж анхдагч текстэд байхгүй хүйс болон тоо заан алдаатай орчуулсан байна гэж “Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгааны баг дүгнэжээ.

Өөрөөр хэлбэл, “Intending spouses” гэдэг нь монгол хэлнээ “гэрлэхийг хүсч буй хамтын амьдрал бүхий хүмүүс” хэмээх утгатай ажээ.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн “Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалт нь Монгол Улсын иргэд болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр албан ёсоор амьдарч буй хүмүүс бэлгийн чиг баримжаагаар хоёр ангилагдах, ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүс болон

³³Жогжакартын зарчим 24. Жогжакартын зарчмууд., УБ., 2012.

³⁴“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, ХЭҮК, ЛГБТ Төв ТББ, УБ., 2012.

тэдний де факто³⁵ гэр бүл, тэдний үр хүүхдүүд төрийн зүгээс ялгаварлан гадуурхалтад өртөх үндэслэл болдог гэж энэ бүлгийн хүмүүс шүүмжлэн, уг заалтыг “Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц”-тэй нийцүүлэн өөрчлөх саналыг байнга гаргадаг юм.

Шигтгээ:

Монгол Улсын нутаг дэвсгэрт албан ажлаар оршин сууж байсан Б.Д. хэмээх гадаад эрэгтэйн ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрч, гэрлэлтийнх нь үндсэн дээр түүний нөхөрт Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгодог байсан ч Р.Г. хэмээх гадаад эмэгтэйн монгол хүнтэй ижил хүйсийн албан ёсоор батлуулсан гэрлэлтийг нь үл хүлээн зөвшөөрч, оршин суух зөвшөөрлийг зөвхөн хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр сунгадаг байсан нь эдгээр ижил статус бүхий гэрлэлтийг ялгаварлан гадуурхсан явдал болсон юм.

Н.А.-ийн хувийн тэмдэглэл

Монгол Улс ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй орны тоонд ордог. Өнөөдөр Аргентин, Бельги, Канад, Дани, Ирланд, Нидерланд, Норвеги, Португал, Өмнөд Африк, Испани, Швед зэрэг улс ижил хүйсийн гэрлэлтийг үндэснийхээ хэмжээнд хүлээн зөвшөөрөөд байна.

3.3. ЛГБТ хүмүүсийн хүүхдийн эрхийн асуудал

Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-дэх хэсэгт “Хүүхдийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, төрсөн газар, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах...” гэсэн нэгэн үндсэн зарчмыг баримтална гэсэн боловч бодит байдалд ЛГБТ хүний хүүхдүүд ялгаварлан гадуурхалтад давхар өртөж байна.

³⁵De Facto-Латинаар “үнэн хэрэгтээ” гэсэн утгатай үг. Аливаа зүйл хуулиас хамааралгүйгээр амьдралд тохиолдох. Х.Виктор Кондэ., Хүний эрхийн олон улсын нэр томьёоны гарын авлага, 2002.

**Шигтгээ:**

О.Г. нь 38 настай лесбиян. Хамтран амьдрагч эмэгтэйтэйгээ өөрийн ба хамтрагчийнхаа төрүүлсэн 2 хүүхдээ өсгөдөг. 17 настай том охин нь сургууль дээрээ хоёр ээжтэйгээсээ болж ангийнхандаа гадуурхагддаг, ангийнхан нь байнга “Танай ээж чинь гомо биз дээ? Хамт яваад байдаг тэр эгч нь чиний юу юм бэ?” гэх мэтээр янз бүрийн сөрөг хандлага бүхий зүйл түүнээс асууж эвгүй байдалд оруулдаг. “Охиныг минь надаас, миний амьдралаас болж хүмүүс яах бол гэж маш их санаа зовдог. Хамтрагчийн маань төрүүлсэн хүүхэд удахгүй сургуульд орохоор мөн ялгаварлагдана, хүнд байдалд орно гэхээс маш их санаа зовдог” хэмээн ярьж байсан юм.

ЛГБТ Төвийн баримтжуулалт, 2011 оны 2 дугаар сар

Үүнээс харахад ЛГБТ хүний хүүхдийг анги, сургуулийн хамт олны зүгээс хэл амаар доромжлох зэргээр хүүхдийн эрх давхар зөрчигдөж байна.

Гей, лесби эсвэл хүйсийн байдалдаа эргэлзэж буй хүүхдүүдэд тусгай анхаарал тавих шаардлагатайг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос онцлон тэмдэглэж байна. Ийм хүүхдүүд мэдээлэл байхгүйгээс өөрөө өөрийгөө хүлээн зөвшөөрөхгүй байх, бусдаас ялгаатай гэдгээ мэдэж өөрийгөө буруутгах, сэтгэл гутралд орох, сурах хүсэл сонирхолгүй болох зэрэг олон сөрөг үр дагавар гардаг тул энэ байдлаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байх шаардлагатай юм.

3.4. Ажил хөдөлмөр эрхлэх эрхийн асуудал

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр боломжийн, үр бүтээлтэй ажил хөдөлмөр эрхлэх, шударга таатай ажлын нөхцлөөр хангагдах, түүнчлэн ажилгүйдлээс хамгаалагдах эрхтэй.³⁶

Ажил хөдөлмөр эрхлэх нь ЛГБТ хүний хувьд огт хангагдахгүй байгаа хэмээн үзэх үндэслэлтэй байна. Учир нь ЛГБТ гэдгээ мэдэгдвэл ажилд авдаггүйгээс ЛГБТ байдлаа нуух шаардлага тулгардаг, нуугаад эсвэл ямар нэгэн байдлаар ЛГБТ байдлаа мэдэгдлээ гэхэд ажлын байрандаа ялгаварлан гадуурхалтад өртдөг байна.

³⁶Жогжакартын зарчим 12. Жогжакартын зарчмууд., УБ., 2012.



Судалгаанд оролцогч ЛГБТ хүнээс “Та бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн ажлын байрандаа ялгаварлан гадуурхалтад өртөж байсан уу?” гэсэн асуултанд 81.7% нь бодит байдлаа нуун дарагдуулдаг гэсэн бол, 11.7% нь тийм, 3.3% ажил хийж үзээгүй, зөвхөн 3.3% ЛГБТ байдалд нь үндэслэн ажлын байранд ялгаварлан гадуурхалтад өртөж байгаагүй гэж хариулжээ.

Төрийн албан хаагчдаас авсан санал асуулгаас үзэхэд “Таны бодлоор ЛГБТ хүн монголын нийгмийн нөхцөлд хангалттай аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөл бүрдсэн гэж боддог уу?” гэсэн асуултанд 78.3% нь “үгүй”, 15% нь “тийм”, 5% нь “мэдэхгүй”, 1.7% нь энэ асуултад хариулаагүй байна.

Мөн судалгаанд оролцогч төрийн албан хаагчдаас авсан асуулгаар “Таны ажлын хамт олны дунд ЛГБТ хүн байвал та хэрхэн хүлээж авах вэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогч 2 хүн тутмын 1 нь “ерөнхийдөө тухгүй” гэж хариулсан байна.

Судалгаанаас үзэхэд хэрэв ажлын байрандаа бодит байдлаа нуун дарагдуулахгүй бол ялгаварлан гадуурхалтад өртөх магадлал өндөр байх бөгөөд энэ нь дараах фокус бүлгийн ярилцлагаас давхар батлагдаж байна.

Шигтгээ:

“Монгол жижигхэн учир нэг ажил олгогчид ЛГБТ гэдгээ хэлэхэд бусад нь мэдээд намайг ажилд авахгүй тохиолдол зөндөө гарч байсан. Нарийн мэргэжлээр сураагүй хүний хажууд би сурчихаад ирсэн байхад тэр хүнийг мэргэжилтнээр ажилд авч байх жишээтэй.

“Ажлын байран дээр асуудал их гардаг. “Найз охинтой юм уу? Найз охин чинь эрэгтэй байхаа, эр хүн шиг байгаач, яаж яваад байгаа юм, хүүхэн шиг. Г-ийн дүү юм уу” гэх мэтээр үг хэлээр доромжилдог.

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
Гей залуутай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

Төрийн албан хаагчдаас авсан асуулгаар “Таны танилын хүрээ (ажлын хамт олон, сургуулийн хамт олон, найз нөхөд болон гэр бүлийнхэн) ЛГБТ хүнд хэрхэн ханддаг вэ?” гэсэн асуултанд 51.7% нь “ерөнхийдөө муу”, 13.3% нь “маш муу”, 33.3% нь “энгийн”, 1.7% нь “маш сайн” гэж хариулжээ. Үүнээс үзэхэд төрийн албан хаагчдын 65% нь ЛГБТ хүмүүсийн тухай сөрөг хандлагатай байгааг харуулж байна.



3.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн асуудал

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр бие махбод ба оюун санааны эрүүл мэндийн дээд жишгийн үйлчилгээг хүртэх эрхтэй. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нь энэ эрхийн салшгүй хэсэг мөн.³⁷

Монгол Улсад ХДХВ-ийн халдвартай амьдарч буй нийт 116³⁸ хүний 80% нь эрэгтэйчүүд буюу эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд байна.

ХДХВ-ийн халдвартай холбоотойгоор дүүрэг, хороо, хувийн эмнэлгүүд эмчилгээ үзүүлэхээс татгалзсан тохиолдлууд цөөнгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Оролцогчдын мэдээлснээр ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн бүхий л эрүүл мэнд болон бусад асуудлуудыг ХӨСҮТ хариуцдаг. ХДХВ-ийн халдвартай хүмүүст шинжилгээ, эмчилгээ, хагалгаа хийхээс Сонгдо эмнэлэг, Улсын Клиникийн төв эмнэлэг, Шастины нэрэмжит 3-р эмнэлгүүд татгалзсан тохиолдол гарсан байна.

Шигтгээ:

Шулуун гэдэсний хагалгаанд Улсын Клиникийн төв эмнэлэг дээр орох хүсэлт гаргаад ХДХВ-ийн халдвартайгаа хэлэхэд тус эмнэлэг хагалгаанд орох боломжгүй гээд татгалзсан. Тус эмнэлгийн эмч ХӨСҮТ дээр ирж хагалгаа хийсэн. ХӨСҮТ-ийн зориулалтын бус өрөөнд хагалгаа хийлгэхэд ямар ч мэдээ алдуулах тариа, эм байгаагүй их хэцүү байсан. 1-р эмнэлгийн хувьд эмнэлэг дээрээ хагалгаанд оруулахыг хориглосон ч эмчийн хувьд үүрэг хариуцлагаа ухамсарлан ХӨСҮТ дээр ирж хагалгаа хийж өгсөн.

ХДХВ-ийн халдвартай Гей залуугийн ярилцлагаас, 2012 он

Гей хүмүүсийн бэлгийн зан үйлийн онцлог бол ихэнхдээ шулуун гэдсээр бэлгийн хавьталд орох явдал юм. Гэтэл шулуун гэдэсний арьс эмзэг, нимгэн учир ийм бэлгийн хавьталд орж буй хүмүүс бэлгийн замын халдвар авах нь их байдаг. Харамсалтай нь өөрсдийгөө хүлээн зөвшөөрөөгүй ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эсвэл зан үйлтэй хүмүүс ихэнхдээ тохиолдлын бэлгийн хавьталд ордог, орохдоо ихэвчлэн архи уусан согтуу үедээ ордог, мөн тэр тоолондоо бэлгэвч эсвэл чийгшүүлэгч хэрэглэдэггүй учир илүү эрсдэлтэй байдаг ажээ.

³⁷Жогжакартын зарчим 17. Жогжакартын зарчмууд., УБ., 2012.

³⁸ХӨСҮТ-өөс ирүүлсэн мэдээлэл, 2012 оны 10 дугаар сарын байдлаар

Харин лесбиян эмэгтэйчүүд бэлгийн замын халдварын хувьд эрсдэлгүй бэлгийн зан үйлтэй байдаг ч эмч, эмнэлгийн ажилтнуудын зүгээс үзүүлж буй сөрөг хандлагаас улбаалан эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэхийг хүсдэггүй, эмэгтэйчүүдийн хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт ордоггүй байна³⁹.

Шигтгээ:

“Эрүүл мэнд гэхээр өвчин зовлон боддог. Гэтэл сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал маш их орхигдсон асуудал.”

“Трансжендэр хүмүүс эрүүл мэндээ хамгаалуулах, хувийн нууцаа хадгалах ямар ч боломжгүй байгаа. Наад зах нь хүйсийн шилжилтийн дааврын эмчилгээний тухай мэдлэгтэй эмч нар байхгүйгээс болж транс эрчүүдийн хувьд ирээдүйд хорт хавдар, транс эмэгтэйчүүдийн хувьд зүрх судасны өвчин, ясны өвчин гээд өчнөөн олон асуудал үүсэхүйц байгаа. Яахав, өөрсдөө мэдээд дэлхийн жишигт нийцсэн дааврыг нь олоод хэрэглэе гэж бодоход үнэ нь дийлдэхгүй.

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

Лесбиян болон бисексуал эмэгтэйчүүдийн дунд хөх, умай, өндгөвчний хортой болон хоргүй хавдрын тохиолдол гетеросексуал⁴⁰ эмэгтэйчүүдийнхээс хамаагүй илүү их хувьтай байдгийг судалсан гадаад орнуудын судалгаанууд байдаг⁴¹. Тэр ч утгаараа Монголын лесбиян, бисексуал эмэгтэйчүүд ч мөн ийм төрлийн хоргүй, хортой хавдраар өвчлөх боломж их байхыг үгүйсгэхгүй. Энэ талаар судалсан судалгаа манай улсад алга байна.

Судалгаанд эрүүл мэндээ хамгаалуулах асуудлаар эмч, эмнэлгийн байгууллагад хандахад ямар нэгэн бэрхшээл байдаг эсэх асуудлыг

³⁹“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, ХЭҮК, ЛГБТ Төв ТББ, УБ., 2012.

⁴⁰“Гетеросексуал” буюу эсрэг хүйсийнхээ хүнд татагддаг хүн.

⁴¹Боуэн, Д. Ж., Боэмэр, У., & Рүссо, М. (2003) “Хавдар ба бэлгийн цөөнхийн эмэгтэйчүүд” И. Х. Мээр ба М. И. Нортридж (Eds.), Бэлгийн цөөнхийн эрүүл мэнд. Вашингтон хот; АНУ-ын Сэтгэлзүйчдийн холбооны Лесбиян ба бисексуал эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тухай баримтууд: <http://womenshealth.gov/publications/our-publications/fact-sheet/lesbian-bisexual-health.cfm>; Ранкоү И. Ж, Тессаро И. (1998) “Умайн хүзүүний хорт хавдрын эрсдэл ба Лесбиян ба бисексуал эмэгтэйчүүдээс сорьц авч Папаниколаугийн шинжилгээ хийх нь”, Гэр бүлийн дадлын тухай сэтгүүл, 47-р боть, iss.2, 139-143 тал; Стивенз ПИ, Хоол ЖМ (1988) “Лесбиян эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн халамжтай холбоотой ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолт, эрүүл мэндийн итгэл үнэмшил ба туршлагауд”, Сувилахуйн сургуулийн сэтгүүл, 20-р боть, iss.2, 69-73 тал; Феррисе ДЖ, Батигш С, Райт ТС, Күшинг С, Скот ИХ (1996) “Орхигдсон лесбиян эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлууд: умайн хүзүүн хавдрын эд эсийн өсөлт”, Гэр бүлийн дадлын сэтгүүл, 43-р боть, iss.6, 581-584 тал; Кэрролл НМ (1999) “Лесбиян эмэгтэйчүүдэд зориулсан эмэгтэйчүүдийн ба эх барих эмчилгээ үйлчилгээ”, 93-р боть, iss.4, 611-613 тал.



тодруулахад оролцогчдын 70% нь “ЛГБТ гэдгээ мэдэгдвэл бэрхшээл тулгарна гээд хэлдэггүй”, 10% нь “бэрхшээл байдаг, 20% нь “бэрхшээл байдаггүй” гэж хариулсан.

Үүнээс үзэхэд эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх ЛГБТ хүний хувьд хаалттай байна.

3.6. Сурч боловсрох эрхийн асуудал

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн, эсвэл эдгээрт хамаатай учир шалтгаанаар ялгаварлан гадуурхалтад өртөлгүй сурч боловсрох эрхтэй.⁴²

2002 оноос ерөнхий боловсролын сургуулийн 8-9 дүгээр ангийн хөтөлбөрт “Эрүүл мэнд хичээл” ордог болсон. Энэ хичээлийн хөтөлбөрийн нэг бүлэгт “Бэлгийн боловсрол”-ын талаар заадаг боловч бэлгийн чиг баримжааны тухай асуудлыг зөвхөн бэлгийн асуудалтай буюу “секс”-тэй холбоотойгоор оруулж өгсөн байна. Харин хүйсийн баримжаа илэрхийллийн талаар огт тусгагдаагүй байна.

ЛГБТ хүмүүсийн тухай мэдлэг өгч буй талаар тодруулах зорилгоор сургууль болон боловсролын орчинд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаар мэдээлэл авч байсан эсэх тухай асуултад зөвхөн 10% нь “авч байсан”, 1.7% нь “ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа бол сэтгэцийн өвчин гэсэн мэдээлэл авч байсан” бусад нь “бага зэрэг”, “үгүй” гэж хариулжээ.

Шигтгээ:

Сургуулийнхан “Хөөе охин, хүүхээн, гомо энээ тэрээ гэж дуудах бол энгийн л үзэгдэл, бүр барьж аваад алгадаж унагаагаад, элэгдчихгүй л бол юу ч биш. “Энэ юун охин шиг юм” гэж багшийг хэлэхээр ангийнхан пэр хийтэл инээлдээд хамт олных нь дунд эвгүй байдалд оруулж, таагүй орчин үүсгэж байна гэдгээ багш өөрөө мэддэггүй л юм байх даа.” “Шоолуулдгаасаа болоод хичээлээ маш их тасалдаг байсан, бусад гей хүүхдүүд ч сургуулиасаа гарсан зөндөө л тохиолдол байдаг.”

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

Хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанд төрөлхийн хүчин зүйл нэн давамгай үүрэг гүйцэтгэдэг гэдгийг шинжлэх ухааны олон судалгаагаар⁴³ олж тогтоосон ч ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай

⁴²Жогжакартын зарчмууд 16. Жогжакартын зарчмууд., УБ., 2012.

⁴³ЛеВэй, Симон (1991) “Гомосексуал ба гетеросексуал эрэгтэйчүүдийн өнчин тархины бүтцийн ялгаа”, Шинжлэх ухаан, 253-р боть, iss.5023, 1034-1037 тал; ЛеВэй, Симон (1993) Бэлгийн уураг

эсвэл трансгендэр хүүхдүүд өөрсдийн тухай үнэн, бодит мэдээлэл олж авч чадахгүй байгаа нь тэдгээрийн бие, сэтгэхүйн онцлогийг бүрэн хангасан боловсрол олгогдохгүй байна гэж үзэхээр байна⁴⁴.

Судалгаанд оролцогчдоос сургууль болон боловсролын орчинд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үүдэн ялгаварлан гадуурхалтад өртөж байсан эсэх тухай асуултад 25% нь тийм, 75% нь үгүй гэж хариулсан ба сургууль боловсролын орчинд ЛГБТ байдлаасаа үүдэн халдлагад өртөж байсан эсэх тухай асуултад 6.7% бие махбодын халдлагад өртөж байсан гэж хариулжээ.

Шигтгээ:

Х нь 16 настай транс эмэгтэй. Тэрээр багаасаа л зөвхөн охидтой тоглодог байсан. Сургуульд ороод ч байнга “охин”, “хүүхэн” гэх мэтээр шоолуулж, 5, 6, 7-р ангиуддаа транс байдлаасаа болж сургууль, байрныхандаа зодуулж, хоёр удаа сургууль шилжиж, нэг удаа нүүж байсан ч хамгийн сүүлд 7-р ангидаа зодуулаад сургуулиа орхисон. Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөгүй.

ЛГБТ Төвийн 2010 оны 3 дугаар сарын баримтжуулалт

тархи, Кэмбриж: Массачусетийн технологийн их сургуулийн Хэвлэл; ЛеВэй, Симон (1996) Күйр шинжлэх ухаан: Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны тухай судалгааны хэрэглээ болон урвуулан ашиглалт. Кэмбриж: Массачусетийн технологийн их сургуулийн Хэвлэл; ЛеВэй, Симон (2010) Гей, стрейт ба яагаад гэсэн шалтгаанууд: Бэлгийн чиг баримжааны шинжлэх ухаан. Нью Йорк: Оксфордын их сургуулийн хэвлэл; Дайамонт, Лүийз ба Ричард Д. Мк Анулти (eds.) (1995) Бэлгийн чиг баримжаа, зан үйл болон айдангитигийн сэтгэл зүй: Гарын авлага, Грийнвүүд хэвлэлийн групп; Эллис, Лий ба М. Ашли Эймз (1987) “Мэдрэлийн дааврын ажиллагаа ба бэлгийн чиг баримжаа: Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны онол - гетеросексуал бэлгийн чиг баримжаа”, Сэтгэл зүйн самбар, 101(2)-р боть, 233-258 тал; Вайнбэрг, Томас С. (1985) “Биологи, үзэл суртал ба Бэлгийн ижил хүйсийн чиг баримжаа илэрхийллийн судалгаан дахь хөгжлийн үе шат”, Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа сэтгүүл, 10-р боть, iss.3-4, 77-84 тал; Соммер, Волкер ба Васи, Поол Л. (eds.) Амьтдын ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны зан үйл: Хувьслын үзэл санаа, Нью Йорк: Кэмбрижийн их сургуулийн хэвлэл; Банкрофт, Жоон (1994) “Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа: Биологийн үндэслэлийг эрэлхийлэх нь”, Их Британы Сэтгэл судлалын сэтгүүл, 164-р боть, 437-440 тал; Корселло, С.М., Донна В.Ди, Сийнз П., Лүотто В., Ричиато, М.П., Паралинола, Р.М., Понтэкорви А (2006) “Жендрийн эмгэг дахь биологийн асуудлууд”, Минерва Эндокринологика, 36-р боть, 325-339 тал; Сийгал, Нэнси Л. (2006) “Нэг эсийн хоёр ихэр хос эмэгтэйтэй эрэгтэй транссексуал байдалтай ижил биш”, Бэлгийн зан үйлийн архив, 26-р боть, iss.3, 346-357 тал; Круивер, Фрэнк П.М., Зоу, Жианг-Нинг, Пүүл, Крис В., Хофман, Майкл А., Гүүрэн, Лүийз Ж. ба Дик Ф. Свааб (2000) “Эрэгтэйтэй эмэгтэй транссексуал хүмүүсийн дөрвөн мөчний цөмд эмэгтэй мэдрэлийн эс байдаг”, Эмнэлгийн эндокринологи ба бодисын солилцооны сэтгүүл, 85-р боть, iss.5, 2034-2041 тал; Гарсиа-Фалгэраз, Алисиа ба Фрэнк Ф. Свааб (2008) “Өнчин тархины дэгээт цөм дахь хүний бэлгийн амьдралын ялгаа: хүйсийн баримжааны харилцаа”, Уураг тархи, 131-р боть, iss.12, 3132-3146 тал; Крокот, Г. ба И-М. Фаргхэрнэр (1988) “Эрэгтэйтэй эмэгтэй транссексуал хүмүүс ба эмэгтэйтэй эрэгтэй транссексуал хүмүүс: харьцуулалт”, Бэлгийн зан үйлийн архив, 17-р боть, iss.6, 539-546 тал; Лентини, И., Касахара, М., Арвер, С., ба И. Савич (2012) “Хүний уураг тархин дахь бэлгийн ялгаа болон бэлгийн хромосом ба дааврын үр нөлөө”, Тархины гадарга, 10-р боть; Хийг, Рейчэл (2006) Транссексуал байдлын тухай Прэгерийн гарын авлага: Үзэл сурталд нийцүүлэхээр хүйсээ өөрчлөх нь, Прэгерийн хэвлэл.

⁴⁴“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, ХЭҮК, ЛГБТ Төв ТББ, УБ., 2012.



3.7. Халдашгүй байх эрхийн асуудал

*Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран бүх хүн халдашгүй байх эрхтэй ба төрийн албан хаагч эсвэл бусад аливаа хүн, бүлэглэлийн хүчирхийлэл, бие махбодын гэмтлээс төрөөс хамгаалуулах эрхтэй.*⁴⁵

ЛГБТ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ болж үзэн ядагдах, гэмт халдлагад өртөх, гэмт хэргийн хохирогч болох явдал өндөр байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2010 оны 11 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дэргэдэх Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжид үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг тусгай зүйл анги болгон Эрүүгийн хуульд тусгах, зөрчигдсөн эрхийг нь хамгаалах, ийм төрлийн гэмт хэрэгтэй хатуу тэмцэх ёстой талаар тодорхой заасан.

Шигтгээ:

Иргэн Э.Г гэгч нь транс эрэгтэй Н.А.-г 2012 оны 2 дугаар сарын 25-ны шөнө транс байдлыг нь үзэн ядсанаас үүдэн түүнд ноцтойгоор халдаж, нүдний ухархайг нь цуулж, хөнгөн гэмтэл учруулсан. Энэ хэргийг Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн 99.1-р зүйлээр яллаж, 2012 оны 9 дүгээр сарын 5-нд болсон шүүх хуралдаанаар Э.Г-г гэм буруутайд тооцсон. Гэсэн хэдий ч хэрэг гарснаас хойш 6 сарын дараа хөнгөн гэмт хэрэг хэмээн ямарваа шийтгэл оногдуулалгүй өнгөрсөн. Хохирогч энэ халдлагыг үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг мөн болох талаар хэд хэдэн удаа Чингэлтэй дүүргийн прокурорын газарт албан ёсоор бичгээр тайлбар тавьж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу энэхүү гэмт хэргийг зүйлчлээгүй байгаа ч ийм төрлийн гэмт хэргийг таслан зогсоох ёстой талаар олон улсын зөвлөмж буйг прокурор болон шүүх хуралдааны үйл явцад сануулж байсан ч хохирогчийг үл тоон, яллагдагчид ял шийтгэл хүлээлгээгүй.

ЛГБТ Төвийн 2012 оны баримтжуулалт

2009 оноос Э, Х, Б нэрээр олон нийтэд ил гарч ирсэн транс охидыг 2009 оны 9 дүгээр сарын сүүлээр Даяар Монгол хөдөлгөөний 9 гишүүн

⁴⁵Жогжакартын зарчмууд 5в. Жогжакартын зарчмууд, УБ., 2012.

70 давхар оршуулгын газар руу аваачиж, онц ноцтойгоор бие эрхтэнд нь халдаж, тамлаж, хүчээр бэлэг эрхтнээ хөхүүлж, мөн охидыг бие биенийхээ бэлэг эрхтнийг хөхөхийг шаардаж, нэгнийх нь шулуун гэдсэнд ууттай чулуу чихэж хүчиндсэн бусармаг явдал гарсан. Энэ талаар ЛГБТ Төвийн “Эрх чөлөөний худал хуурмаг” баримтат кинонд ярьснаас нь болж тэднийг харсан газраа ална хэмээн заналхийлж улмаар ЛГБТ Төв ТББ-ынхны тусламжтайгаар Э, Х нар эх орноо орхин дүрвэн гарсан. Тэднийг транс байдлаар нь улам цааш доромжилно гэсэн айдас, хүйдэс, сэтгэл зүйн гүн цочролд орсон байснаас энэ ноцтой халдлагын талаар цагдаад мэдэгдээгүй юм. Мөн Х өмнө нь Даяар Монгол хөдөлгөөний гишүүн байсан тул цагдаа нарын дунд ч энэ хөдөлгөөний гишүүд байдаг гэдгийг мэддэг байснаас хуулийн байгууллагад хандаагүй. Одоо эдгээр транс охид гадаадад дүрвэгчийн статустай амьдардаг.

ЛГБТ Төвийн 2012 оны баримтжуулалт

2001 оны намар Туул голын орчмоос олон удаа хутгалсан, хоолой нь хөх няц болсон Б. гэх лесбиян бүсгүйн цогцос олдсон. Б. нь лесбиян гэдгээсээ болж багаасаа гэрээсээ хөөгдсөн, амьдрахын эрхээр биеэ үнэлдэг байсан ба гэмт хэрэгтэн өнөөг хүртэл оллоогүй байна.

ЛГБТ Төвийн 2012 оны баримтжуулалт

А. гэх гей залууг найз залуугийнх нь гэр орныхон байнга зоддог байсан. Хамгийн сүүлд хоёр шүд, хавиргыг нь хугалж, хутгалсан. Хохирогч цагдаад хандаагүй, учир нь түүний найз залуугийн гэрийнхэн цагдаад ажилладаг, танил тал ихтэй гэж үзсэн. Одоо АНУ-д дүрвэгчийн статустай амьдардаг.

Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн талаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ аль хэдийн үүссэн ба олон оронд үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт тооцож ял оноодог⁴⁶. Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг 1990-ээд оноос хойш АНУ, Канад, Европын холбооны ихэнх улсуудад нарийн тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Энэхүү гэмт хэрэг нь аливаа нэг шинж чанараараа ижил бүлэг хүмүүсийн эсрэг үйлдэгддэгээрээ онцлог ба тухайн бүлэг хүмүүсийн хувьд урт хугацаагаар сөрөг нөлөө үзүүлж байдаг. Ялангуяа гэмт үйлдлийн сэдэл

⁴⁶Punishment For Hate Crimes, <http://www.crimemuseum.org/library/hateCrime/punishmentForHateCrimes.html> What is a hate crime? <http://www.cbc.ca/news/canada/story/2011/06/15/f-hate-crimes.html>, Tougher penalty for hate crimes <http://www.guardian.co.uk/politics/2003/oct/31/ukcrime.gayrights>



нь тухайн бүлэг хүмүүсийн төрөлхийн мөн чанар, өөрчилж болшгүй зүйл дээр үндэслэгдсэн байна.⁴⁷

“ЛГБТ Төв” ТББ-ын баримтжуулснаар ижил хүйсийн хосуудын хоорондын гэр бүлийн хүчирхийллийн олон жишээ баримтууд байдаг бөгөөд тэдэнд ээлтэй хууль эрх зүйн орчин бүрдээгүй, нийгэм сэтгэл зүй тэднийг хүлээн зөвшөөрдөггүй, хуулийн байгууллагын ажилтнуудын мэдлэг ойлголт хангалтгүйгээс асуудлаа шийдвэрлүүлж чаддаггүй байна.

Шигтгээ:

А.Б. нь гей ба өөрийн эрэгтэй хамтран амьдрагчтай хамт амьдарсаар зургаан жил гаруй болж байгаа. Энэ хосын харилцаанд архидалт болон архидалтаас үүдсэн дотны харилцааны хүчирхийлэл байсаар ирсэн ба хүчирхийллээс үүдэн аль аль талд эрүүл мэндийн маш ноцтой нөхцөл байдал үүсч байсан. Цагдаад нэг удаа энэ асуудлаараа хандаж байсан ч “хоёр эр зодолдоход юундаа гоншигносон юм” гэсэн хандлагатай асуудлыг нь хүлээж авч байсан. А.Б.-ийн найз залуу нь “Би энгийн л хүн байсан, тэгээд А.Б.-д дурлаад ийм амьдралд орсон. Гэтэл А.Б. намайг бүрэн ойлгодоггүй” хэмээн ярьдаг.

ЛГБТ төвийн баримтжуулалт, 2012 оны 11 дүгээр сар

Судалгаанаас харахад “ЛГБТ байдлаасаа үүдэн гэмт хэргийн халдлагад өртсөнийг цагдаа үл хайхрах асуудал гаргаж байсан уу?” гэсэн асуултад оролцогчдын 26.7% “заавал өөрийнхөө ЛГБТ байдлыг илчлэх шаардлагагүй гэж боддог”, 11.7% “гарч байсан”, 46.7% “өөрийгөө илчилбэл үл тоомсорлох байх гэж боддог”, 15% “тийм нөхцөлд орж байгаагүй” гэжээ.

Шигтгээ:

“Би гэртээ харьж явахад манай найз залуугийн ах намайг ирж мөргөчихөөд зугтаад гүйсэн. Тэгээд би найз залуугийнхаа гэрт амьдардаг болохоор гэртээ ороод “Тэр ах чинь намайг мөргөж, хамар хугаллаа” гэж уурлахад ээж нь цагдаа дуудсан. Тэгсэн хохирогч болсон намайг цагдаа нар ирж бариад, “Чи муу гомо минь зүгээр байгаарай” гэж хэл амаар доромжлоод намайг цохьсон.”

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
Гей залуутай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

⁴⁷“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа, ХЭҮК, ЛГБТ Төв, УБ., 2012.



“2009 оны турш би эмэгтэй хувцас өмсч хэдэн транс найзуудтайгаа гадуур явсан. Тэгэхэд хүмүүс чулуу, угаадас зэргээ бидэн рүү шиднэ, нэг удаа бүр шээсээр зуурсан шавхай ч бидэн рүү шидэж байсан. За яахав гэж бодоод усанд орчихно, хувцсаа солиод гарна. Гэтэл хэд хэдэн удаа биднийг зүв зүгээр юм яриад гадаа зогсч байхад хэдэн залуучууд ирээд зодсон. Тэгээд цагдаа дуудаад, хамт цагдаагийн хэсэг рүү очиход “Та нар чинь эр юм байж яах гэж эмэгтэй хувцас өмссөн юм? Хохь чинь, битгий цаг үрээд бай” гээд гаргаж байсан. Гэтэл би транс эмэгтэй, яах ёстой юм?”

*“Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт” судалгаа,
Фокус бүлгийн ярилцлагаас, 2012 он*

ЛГБТ хүний төрөлхийн байдлыг нь хүлээн зөвшөөрдөггүйгээс нийгмийн бүхий л салбарт ялгаварлан гадуурхагдах, бие махбод, нэр төр, хувийн нууцад нь халдах, гутаан доромжлох, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх явдал их байна.

Нийгмийн сэтгэл зүй бүхэлдээ бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаар мэдлэг, мэдээлэл маш бага, ихэнх нь ЛГБТ хүний талаар сөрөг хандлагатай байдгаас аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгэм, соёлын амьдралд оролцох, түүний үр шимийг хүртэх боломж хомс байна.

Судалгаанаас үзэхэд ЛГБТ хүмүүсийн хувьд хамгийн ойр дотны хүмүүс болох гэр бүлийн гишүүд нь тэдний бэлгийн чиг баримжаа хүйсийн баримжаа илэрхийллийг нь хүлээн зөвшөөрөхгүй дарамт шахалт, хүчирхийллийг үйлдэж байгаа өнөөгийн нөхцөлд нийгмийн уур амьсгалыг зөв тал руу нь чиглүүлэхгүйгээр ЛГБТ хүмүүсийн асуудлыг ил болгох нь тэднийг илүү их хохиролд хүргэж болзошгүйг харуулж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

НҮБ-ын гэрээний хороодод болон НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд гишүүн орны Засгийн газрын хүний эрхийн төлөв байдлын илтгэлийг хэлэлцэх замаар хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхээр гишүүн улс орнуудын авсан үүрэг амлалтын биелэлтийг хянадаг байна.



НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан хүний эрхийн гэрээг хүлээн зөвшөөрч, нэгдэн орж, соёрхон баталсан улс орнууд тухайн гэрээнд заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангаж буй талаараа тайлан бичиж, Гэрээний хороонд тогтмол хугацаанд хүргүүлэх үүрэгтэй. Гэрээнд нэгдэн орсон улс орнуудын тайланг хүлээн авч хэлэлцээд дүгнэлт, зөвлөмж гаргадаг НҮБ-ын гэрээний 10 хороо үйл ажиллагаа явуулдаг. Гишүүн улс орнууд нь Гэрээний хороодын дүгнэлт, зөвлөмжийг үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөртөө тусгах, өмнөх тайланг хэлэлцсэнээс хойш гарсан өөрчлөлтүүдийн талаарх шинэ мэдээллийг сүүлийн тайландаа оруулах үүрэг хүлээдэг. Гэрээний зарим хороод нь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай хувь хүний гомдлыг хүлээн авч хянан үзэж, дүгнэлтээ тухайн улсын Засгийн газарт илгээх эрхтэй байдаг.

Энэ удаа НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос 2010 онд, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 2011 онд Монгол Улсын илтгэлийг хэлэлцээд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Засгийн газрын холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг илтгэлдээ тусгаж байна. Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хянадаг. Монгол Улс анхдугаар илтгэлээ 2009 онд тус Хороонд хүргүүлж, 2010 оны 11 дүгээр сард НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 963, 964 дэх хурлаар хэлэлцэн 976 дахь хурлаар 28 заалт бүхий зөвлөмжийг баталсныг хүлээн авсан.

Хүний эрхийн хороо нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг гишүүн улсууд хэрхэн хэрэгжүүлж байгааг буюу пактын хэрэгжилтийг хянадаг байгууллага юм. Монгол Улс хамгийн сүүлд 2008 онд 5 дахь илтгэлээ тус Хороонд хүргүүлж, 2011 онд Хорооны 2797 дахь хэлэлцүүлгээс гарсан 24 заалт бүхий зөвлөмж хүлээн авчээ.

Улс орнууд өөрийн сонголтоор нэгдэн ордог хүний эрхийн гэрээ, конвенциос гадна НҮБ-ын дүрмийн дагуу байгуулагдсан хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага бол Хүний эрхийн Зөвлөл юм. Энэ Зөвлөл нь НҮБ-ын бүх гишүүн улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг 4 жил тутам давтан хэлэлцэж Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээрээ тухайн улсын Засгийн газарт зөвлөмж өгдөг.

Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 47 гишүүнээс бүрдсэн Ажлын Хэсгийн 2010 он 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 129 зүйл бүхий дүгнэлт, зөвлөмжийг 2011 оны 3 дугаар сард баталсан байдаг. Монгол Улсын Засгийн газар эдгээр зөвлөмжийн 126 зүйлийг нь хүлээн авч, биелүүлэх үүрэг амлалтаа өгсөн билээ.



Харин “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай” 1951 оны конвенц, түүний 1967 оны Протоколд нэгдэж орох, “Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн бүх гишүүдийг хамгаалах” тухай Конвенцид нэгдэж орох болон Үндсэн хуулиар баталгаажуулсан хувь хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн асуудлыг Үндсэн Хуулийн Цэц шийдвэрлэдэг болох гэсэн 3 зөвлөмжийг хүлээн авах боломжгүйгээ илэрхийлжээ.

НҮБ-ын гэрээний хороодын үйл ажиллагаа, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг нь тухайн улс орныг чичлэн шүүмжлэхийг чухалчлах бус харин хүний эрхийн нөхцөл байдлыг нь үнэлж, анхаарал хандуулах, зөрчил, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх чадавхийг бэхжүүлэх, улс орнуудад нэг нэгнийхээ шилдэг туршлагаас суралцах боломж олгох зорилготой байдаг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь хуульд заасан эрх хэмжээнийхээ дагуу олон улсын гэрээнд нэгдэх, илтгэлд санал өгөх, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 12 дахь илтгэлээрээ НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүний эрхийн хороо, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хүний эрхийн тодорхой асуудлын хүрээнд багцлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар харьяалах яамд болон Засгийн газрын бусад байгууллагаас ирүүлсэн мэдээллийг УИХ-д танилцуулахаар шийдвэрлэсэн юм. Учир нь эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил урсгалаар явагдаж байгаад сэтгэл зовниж байна.

4.1. Цаазаар авах ялын талаар

Зөвлөмж:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II Протокол зэрэг холбогдох олон улсын баримт бичгүүдийг соёрхон батлах, Монгол Улсын эрх зүйн тогтолцооноос цаазаар авах ялыг халахад шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх

*НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 9, 10, 11, 12 дугаар зөвлөмж
Хүний эрхийн төлөв байдлын үндэсний хэлэлцүүлгийн Ажлын хэсгийн
2010 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн V хуралдаан*



Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын II нэмэлт протоколд нэгдэн орох тухай хуулийг Улсын Их Хурал 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр баталсан. Ингэснээр Монгол Улс цаазаар авах ялгүй орон болсон билээ. Энэхүү нэмэлт протоколд нэгдэн орсноор Монгол Улс цаазын ялыг бүрмөсөн халах үүрэг хүлээсэн боловч өнөө хүртэл энэ төрлийн ял Монгол Улсын Эрүүгийн хуульд хүчин төгөлдөр үйлчилсээр байна. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн дагуу шүүгч цаазаар авах ялыг оноож байгаа хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтнуудад уучлал үзүүлсний үр дүнд цаазаар авах ялыг өөр төрлийн ялаар сольж, ял эдлүүлж байгаа билээ.

Олон улсын гэрээг соёрхон батлагдмагц эсхүл түүнтэй хамт дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авах ёстой. Гэтэл өнөөдөр Улсын Их Хурал энэ үүргээ биелүүлээгүйгээс Монгол Улсын олон улсын гэрээ Эрүүгийн хууль хоорондоо зөрчилтэйгээр хэрэгжиж байна.

Зөвлөмж:

Оролцогч улс цаазаар авах ялтай холбоотой статистик тоо баримтыг нийтэд нээлттэй болгож, цаазаар авах ялаар шийтгүүлсэн 44 хүний талаарх мэдээллийг Хороонд өгч, цаазаар авах ялыг арай хөнгөн ялаар солих, цаазаар авахуулсан хүний гэр бүлийг холбогдох мэдээллээр хангах хэрэгтэй. Мөн цаазаар авах ялыг төрийн нууцад хамруулахаа больж, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протоколд нэгдэн орох зэрэг цаазаар авах ялыг устгахад чиглэсэн хүч чармайлтаа үргэлжлүүлэхийг Оролцогч улсаас хүсч байна. Цаазаар авах ялтай этгээдтэй олон улсын стандартад нийцүүлэн харилцаж байгаа эсэхэд Оролцогч улс хяналт тавих хэрэгтэй.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 19 дүгээр зөвлөмж

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр цаазаар авах ялд хориг тавьсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орсонтой холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлэн цааз гүйцэтгэсэн тохиолдол 2012-2013 оны байдлаар байхгүй бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цаазаар авах ял уучлагдсан 33 ялтныг гянданд хорих ялыг нь эдлүүлж байна⁴⁸.

2013 оны байдлаар дээрх ялтнууд 1-17 жилээр хоригдож байгаа ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115 дугаар зүйлд заасны дагуу

⁴⁸ХЭҮК-т ШШГЕГ-аас цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл, 2012.03.14-ний өдөр



эргэлт уулзалт авах, өмгөөлөгч, мөрдөн байцаагчтай уулзах, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний болон бусад зүйлээр хангагдах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах зэрэг ялтны эрхийг хангах ажил хууль журмын дагуу явагдаж байна⁴⁹.

4.2. Мэдээллийн эрх чөлөөний талаар

Зөвлөмж:

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад бүрэн нийцүүлэхэд Оролцогч улс анхаарч, хуулийг батлах хэрэгтэй байна. Нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг эрүүгийн гэмт хэргээс хасаж, сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг, заналхийллээс хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авахыг зөвлөж байна. Түүнчлэн сүрдүүлсэн, заналхийлсэн аливаа мэдээллийг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд Оролцогч улс анхаарна уу.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 25 дугаар зөвлөмж

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2012 оны намрын чуулганд өргөн барьсан боловч хууль санаачлагч төслөө буцаан авсан байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үзэл санааг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйл доромжлох, 111 дүгээр зүйл гүтгэх гэмт хэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хамтад нь өргөн барьсан боловч мөн буцаан авсан.

Мөн 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр УИХ-аас баталсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль нь нийгэмд томоохон бэрхшээл, асуудал болоод байгаа төрийн албаны мэдээллийн хаалттай байдал, түүнийг дагасан төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах маш том хөшүүрэг болж буйг Авлигатай тэмцэх газраас мэдэгдэж байсан⁵⁰. Энэхүү хуулийг боловсруулахдаа олон улсын жишиг стандартад нийцүүлэн, эрдэмтэн судлаачдын саналыг тусгажээ. Харин хуулийг иргэдэд сурталчлах, хуулийн хэрэгжилтийн байдлыг тандан судалж, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

⁴⁹ХЭҮК-т ШШГЕГ-аас цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл, 2012.03.14-ний өдөр

⁵⁰Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга Б.Батзоригтой хийсэн ярилцлага, 2011.11.11.



4.3. Иргэний харьяаллын талаар

Зөвлөмж:

Харьяаллаа алдахтай холбоотой хууль тогтоомжоо эргэн харж, нарийвчилсан анализ хийсний дараа тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчлэн өөрчлөхийг Оролцогч улсад зөвлөж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр харьяалалгүй эцэг эхээс төрсөн харьяалалгүй хүүхдийн харьяалалтай байх эрхийг хангана уу. Харьяат болох хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх хуульд заасан 6 сарын хугацааг чанд баримтална уу.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 26 дугаар зөвлөмж

Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Харьяатын тухай хуулиар Монгол Улсын харьяат байх, харьяат болох, харьяатаа сэргээн тогтоолгох, харьяатаас гаргах, харьяатаа алдахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд хууль батлагдсанаас хойш нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2001-2011 онд Монгол Улсын 34 532 иргэн (үүнээс 17 699 иргэн хялбаршуулсан байдлаар) тус улсын харьяатаас гарч, 713 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгож, гадаадын 121 иргэн Монгол Улсын харьяат болсон тоон үзүүлэлт⁵¹ байна.

4.4. Шашин шүтэх, эс шүтэх эрхийн талаар

Зөвлөмж:

Шашны байгууллага бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулахад нь саад болж байгаа захиргааны болон бусад шат дамжлагуудад анализ хийж, 1993 оны Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг хэрэгжүүлэх механизмд холбогдох өөрчлөлт оруулахыг оролцогч улсад зөвлөж байна.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 24 дүгээр зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас зөвлөмжийг хүлээж авснаас хойш эрх зүйн болоод зохион байгуулалтын ямар нэг арга хэмжээ аваагүй байна.

⁵¹ГИХАЭГ-аас авсан мэдээлэл, 2013.03.18.



4.5. Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар

Зөвлөмж:

Оролцогч улс олон улсын стандартад нийцүүлэн эрүүдэн шүүхийн талаарх ойлголтоо өөрчлөх шаардлагатай байна. Түүнчлэн гэмт үйлдлийн хүнд, хөнгөнөөс хамаарч хариуцлага хүлээлгэдэг байх, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, харгис хэрцгий, доромжилж гутаасан үйлдэл бүрт /тушаал захирамжийн дагуу үйлдсэнээс үл хамааран/ хариуцлага хүлээлгэдэг байхаар тус тус өөрчлөх нь зүйтэй.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 13 дахь заалт

Зөвлөмж:

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцид нийцүүлэх, эрүү шүүлт тулгасан хүнийг ял завшуулахгүй байх.

*НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийн 7,
НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн зөвлөмжийн 19, 20, 21, 22, 97 дахь заалт*

Зөвлөмж:

Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг нэн даруй хүчингүй болгох шаардлагатай. Дээд шатны албан тушаалтны тушаал эрүүдэн шүүх аливаа үйлдлийг зөвтгөх шалтаг болохгүй гэсэн агуулгаар Оролцогч улс хууль тогтоомжоо өөрчлөх нь зүйтэй.

*НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны
зөвлөмжийн 9 дэх заалт*

Монгол Улс Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг тодорхойлохдоо Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлээгүй бөгөөд харин ч эрүү шүүлт тулгасан албан тушаалтнуудад ял завших боломж олгосоор байгаад НҮБ-ын гэрээний байгууллагууд болон тусгай илтгэгчийн зүгээс ихэд харамсч дээрх зөвлөмжүүдийг удаа дараа өгч байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд иргэдээс ирүүлж буй эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 60 гаруй хувь нь эрүүгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч, хорих ангийн



төлөөлөгч, тагнуулын ажилтан зэрэг гүйцэтгэх ажилтантай холбоотой байдаг. Харин практикт хуулийн байгууллага тэдгээрийг шалгаад хэргийг эцэслэн шийдвэрлэхдээ эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект биш гэх үндэслэлээр өөр хөнгөн зүйл ангиар зүйлчлэх, эсхүл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байгаа нь ял завших үндсэн шалтгаан болж байна.

Зөвлөмжийг хүлээн авснаас хойш уг заалтыг өөрчлөх ажил хийгээгүй, энэ талаар хууль боловсруулах ажил төслийн шатанд байна.

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм
бий болгох талаар**

Зөвлөмж:

Оролцогч улс цагдан хорих байр, хорих ангид хяналт тавих бие даасан механизм байгуулах шаардлагатай байна. Мөн хорих ангиудын даацыг хэтрүүлэхгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авах, НҮБ-ын хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийг баримтлах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орох шаардлагатай байна.

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 16 дугаар зөвлөмж, НҮБ-ын
Хүний эрхийн Зөвлөлийн 2, 3, 4, 79 дүгээр зөвлөмж, НҮБ-ын
Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 9 дүгээр зөвлөмж*

Зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” НҮБ-ын конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орсон тухай хуулийн төсөл болон Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай саналыг 2013 онд Хууль зүйн сайдад дахин хүргүүлээд байна.

Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орох хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар оруулахаар тусгасан нь НҮБ-ын Хүний эрхийн Хороо, Хүний эрхийн Зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооноос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх алхам болсон гэж Комисс дүгнэж байна.



Сургалт, хүний нөөцийн бодлогын талаар

Зөвлөмж:

Эрүү шүүлт тулгах, харгис хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжилсон харилцаа, шийтгэлээс урьдчилан сэргийлэх, ийм төрлийн үйлдлийг мөрдөн байцаах асуудлаар шат дараалсан сургалтад хууль хяналт, хорих байгууллагын бие бүрэлдэхүүн болон шүүхийн ажилтнуудыг заавал оролцуулах шаардлагатай.

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 15, НҮБ-ын
Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийн 14 дэх заалт*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд хуулийн байгууллагын ажилтнуудад, тэр дундаа цагдаа, шүүгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч, өмгөөлөгчдөд хүний эрхийн сургалтуудыг зохион байгуулсаар ирсэн.

Хуулийн байгууллагын зүгээс дотоодын сургалтын хөтөлбөртөө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийн ойлголтын талаар сургалт явуулаагүй байна.

Зөвлөмж:

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд цагдаагийн ажилтны үйлдсэн бүх гэмт үйлдлийг мөрдөн шалгах бүрэн эрх, хараат бус байдал, хангалттай хөрөнгө хүч олгоход Оролцогч улс анхаарна уу. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдлыг шуурхай, хараат бус, үр нөлөөтэй мөрдөн шалгах механизмыг бүрдүүлэх

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 13, НҮБ-ын
Хүний эрхийн зөвлөлийн 95, Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны
зөвлөмжийн 11 дэх заалт*

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны шуурхай байдлыг хангах, ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр 2010-2012 онд хэд хэдэн арга хэмжээ авсан байна.⁵² Үүнд:

1. Тус албанд харьяалах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 24 цагийн турш хүлээн авч, хойшлуулшгүй ажиллагаа явуулах жижүүрийн мөрдөн байцаагчийн орон тоог 4-өөр нэмэгдүүлсэн.

⁵²УЕПГ-аас ГХЯ-нд 2013.03.13-ны өдөр хүргүүлсэн мэдээлэл



2. Нийслэл, орон нутагт шуурхай үүрэг гүйцэтгэх машин техникийг шинэчилж, 20 мөрдөн байцаагчийг ажил үүргээ хэвийн явуулахад шаардлагатай компьютерээр хангаж, ажлын байрны нөхцлийг сайжруулсан.
3. Гэмт хэрэг, гомдол, мэдээллийн бүртгэлийн сүлжээг Улсын Ерөнхий Прокурорын Газрын нэгдсэн сүлжээнд холбосон.

Эрүү шүүлтийн нөхөн олговрын талаар

Зөвлөмж:

Оролцогч улс эрүүдэн шүүх үйлдлийн хохирогчдод нөхөн олговор авах боломжоор хангах, тэдэнд шударга, хангалттай нөхөн олговор авах эрх олгох хэрэгтэй. Түүнчлэн эрүүдэн шүүх, зүй бус аливаа үйлдлийн хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн үндсийг тогтоосон хууль тогтоомж батлах нь зүйтэй.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийн 17 дахь заалт

Эрүү шүүлт тулгах үйлдлийг хязгаарлагдмал хэдий ч гэмт хэрэгт тооцон хуульчилсан байх тул гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах журмаар эрүү шүүлтийн хохирлыг тооцож болохоор байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “хохирогч гэж нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ” гэж заасан боловч нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирлыг хэрхэн тооцох эсэх нь тодорхойгүй байдгаас практикт ихээхэн хүндрэл учруулж байна. Эдийн бус хохирлын хэмжээг хэрхэн тооцож, барагдуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлж чадахгүй байна.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний болон оршуулгын, мөн тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн Үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэр гаргаж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9-д заасны дагуу хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүйг илтгэж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг хэрэглэхээр байна.

Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан. Эдийн бус хохирол нь материаллаг бус бүх хохирлыг багтааж байдаг. Иргэний хуулийн тайлбарт “Бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна”⁵³ гэжээ.

Гэхдээ Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэсэн нь хохирол барагдуулах үйл ажиллагааг явцууруулж байна. Үүнийг Улсын дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 6.2.4-т тайлбарлахдаа “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж заасан нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэсэн 14 дэх заалтыг ноцтойгоор зөрчиж шууд хохирлыг төр төлнө, шууд бус хохирлыг төлөхгүй гэж заасан байна.

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэсэн ба үүнд дурдсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах зохицуулалт хийгдсэн байна. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.3 дахь хэсэгт “Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэж заасны дагуу мөнгөөр нэхэмжлэх боломжтой, бусад тохиолдолд сэтгэл санааны хохирлыг арилгуулах, нэхэмжлэх эрхгүй байна.

⁵³Ё.Каюг, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2010 он, 458-р тал



Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд түүнийг оршуулахтай холбоотой зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар тогтоож байна. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт “Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй” гэж заасан ч Улсын дээд шүүхийн өмнөх тайлбарт дурдсанаар эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй хэвээр байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нотлогдоогүй хэсгийг барагдуулахаар иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг шүүхийн тогтоолд дурддаг ч иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргахад санаа сэтгэл, бие эрхтний хохирлыг мөнгөөр үнэлэх аргачлал, эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас хохирлоо нэхэмжлэх эрхгүй, нэхэмжилсэн хохирлоо бүрэн барагдуулж чадахгүйд хүрдэг.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой харилцааг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт зохицуулсан байгаа нь эрүү шүүлтийн зарим хэлбэрийг хамааруулан учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж заасан байна.

Тус зүйлийг Улсын дээд шүүхийн тайлбар⁵⁴-аар энэ зүйлийн 388.1 дэх хэсэгт заасан “Хууль зөрчсөн ажиллагаа” гэдэгт мөн зүйлийн 389.2 дахь хэсэгт заасан тохиолдлуудаас гадна байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамааруулж үзнэ гэж тайлбарласан нь эрүү шүүлтийн хохирогч нөхөн олговор авах боломжийг олгосон байна.

Тиймээс тус заалтыг үндэслэн эрүү шүүлтийн хохирогч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийг удирдлага болгон

⁵⁴Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны □дрийн 45 дугаар тогтоол

иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гарган, төрөөс хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байгаа юм.

Гэвч одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хувьд гэм хор, хохирол гэсэн ойлголтыг ялгаж зааглаагүй харилцан адилгүй байдлаар авч үзсэн, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг хэрхэн яаж тооцох талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлоо хохирогч бодитойгоор барагдуулж авч чадахгүй байна. Гэм хор, хохирол нь хоорондоо ялгаатай ойлголтууд бөгөөд гэм хор нь аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүссэн сөрөг үр дагавар байдаг тул хохирлоос илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл, учирсан хохирлоос үүдэн гарах бүхий л сөрөг үр дагаврыг гэм хор гэх ойлголтод хамааруулан ойлгоно. Жишээ нь: хохирогч нас барсан бол гэр бүлийнхэнд нь үүссэн шаналал зовлон, амьжиргааны доройтол зэрэг нь гэм хор болно.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй байна. Гэтэл Монгол Улсын төр эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг хариуцан арилгах үүрэг хүлээсэн хуулийн зохицуулалт огт байхгүйг дээрх жишээ харуулж байна. Харин хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх үүднээс Улсын дээд шүүхээс тогтоосон тайлбарын хүрээнд энэ харилцааг зохицуулж байгаа нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар

Зөвлөмж:

Пактын 4.2-т заасан халдашгүй эрхүүдийг цаашид хөндөхгүй байх үүднээс Оролцогч улс Үндсэн хуулийнхаа 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон онц байдлын тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Түүнчлэн дээрх эрхүүдийг хөндөхгүй байхад анхаарч шаардлагатай бүх арга хэмжээг авч байхыг зөвлөж байна.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 11 дэх заалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт одоогоор өөрчлөлт ороогүй. Мөн 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Онц байдлын тухай хуульд өнөөдрийг хүртэл ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна. Тиймээс тус зөвлөмж хэрэгжээгүй.

**Зөвлөмж:**

Оролцогч улс эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг нотлох баримтаар ашиглахгүй байх, мөрдөн байцаалтыг заавал хальсжуулах үүргийг холбогдох этгээдэд оногдуулсан эрх зүйн хэм хэмжээ бий болгох шаардлагатай байна. Үүний тулд шаардлагатай санхүү, эд материал, хүний нөөцийг татан оролцуулах хэрэгтэй. Түүнчлэн хальс хадгалах, түүнийг дараа дараагийн мөрдөн байцаалтад дахин ашиглахад баримтлах журам баталж, мөрдөхийг Оролцогч улсаас хүсч байна.

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 14,
НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийн 18 дахь заалт*

Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ талаар бодитой заалт оруулсан боловч хэрэгжээгүй.

Сургалт, хүний нөөцийн бодлогын талаар**Зөвлөмж:**

Эрүү шүүлт тулгах, харгис хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа, шийтгэлээс урьдчилан сэргийлэх, ийм төрлийн үйлдлийг мөрдөн байцаах асуудлаарх шат дараатай сургалтад хууль хяналт, хорих байгууллагын бие бүрэлдэхүүн болон шүүхийн ажилтнуудыг заавал оролцуулах шаардлагатай.

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 15 дугаар зөвлөмж,
НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 14 дүгээр зөвлөмж*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд хуулийн байгууллагын ажилтнууд тэр дундаа шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулсаар ирсэн.

Гэтэл хуулийн байгууллагын зүгээс эрүү шүүлтийн ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавал сургалт зохион байгуулах үүргийг бий болгоогүй байна. Харин НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн Хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооноос хууль сахиулах байгууллагын ажилтан, прокурор, шүүгч нарыг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор заавал сургалтад хамруулж байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл Үндэсний хууль тогтоомж, дүрэм журмаар үүрэг болгосон байх ёстой гэж үзэж байна.

Монгол Улсын хууль тогтоомжоор хуульчдын давтан сургалтыг өөр хоорондоо уялдаа холбоогүй өөр өөр байгууллагууд хэрэгжүүлэхээр



байна. Хуульчийн үргэлжилсэн сургалтын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс сургалт зохион байгуулж багц цагийг тооцож байгаа хэдий ч хүний эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явагдахгүй байна. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд тус үргэлжилсэн сургалтад хамрагддаггүй бөгөөд тухайн байгууллагууд дотооддоо сургалтаа зохион байгуулж байна. Тус байгууллагуудын хууль тогтоомж, дотоод дүрэм, журмаар хууль сахиулагч болон бусад ажилтнуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн мэдлэг ойлголт олгох сургалтыг заавал зохион байгуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Нөхөх олговрын талаар

Зөвлөмж:

2008 оны онц байдлын үед хүний эрхийг зөрчсөн хэрэг, гомдол бүрийг Оролцогч улс нарийн шалгах хэрэгтэй. Үүнд хохирогсдын гэр бүлийн гишүүдэд нөхөн олговор олгосон хэргийг мөн хамруулна уу. Мөн хэрэгт холбогдогсдыг яллах, буруутай нь тотгоогдвол тохирсон шийтгэл оногдуулах, хохирогчдод хангалттай нөхөн олговор олгоход анхаарах шаардлагатай байна.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны зөвлөмжийн 12 дахь заалт

2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр УИХ-аас “Хохирогчид нөхөх олговор олгох тухай” хуулийг баталсан бөгөөд тус хуулиар 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагч, хуулийн этгээдэд нөхөх олговор олгохтой холбоотой харилцааг зохицуулсан. Тус хуульд зааснаар амь насаа алдсан иргэний ар гэрт тус бүр 50 сая төгрөгийн, албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон төрийн тусгай албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын нэг сарын цалинг хүнд гэмтэл авсан бол 36, хүндэвтэр гэмтэл авсан бол 12 дахин өсгөж, эрүүл мэндээрээ хохирсон иргэнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хүнд гэмтэл авсан бол 112, хүндэвтэр гэмтэл авсан бол 37, хөнгөн гэмтэл авсан бол 9 дахин өсгөж улсын төсвөөс нөхөн олговор олгохоор хуульчилсан байна.



4.6. Баривчлах, цагдан хорих ажиллагааны талаар

Зөвлөмж:

Цагдан хоригдож эхэлсэн анхны өдрөөс эхлэн цагдан хоригдогчийг эрх зүйн бүхий л хамгаалалтаар хангахад Оролцогч улс түргэн шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авах хэрэгтэй. Тухайлбал цагдан хоригдох болсон шалтгаанаа мэдэх, шаардлагатай үедээ өмгөөллийн үйлчилгээ болон хууль зүйн туслалцаа цаг алдалгүй авах зэрэг цагдан хоригдогчийн эрхийг хамгаалах шаардлагатай. Мөн цагдан хоригдогчийн өөрийн сонгосон эмчдээ ганцаарчлан үзүүлэх, гэр бүлийнхэнтэйгээ холбогдох, хэргээ шүүхээр түргэн шийдвэрлүүлэх, хууль ёсоор цагдан хоригдсон эсэхээ шүүхээр шалгуулах зэрэг эрхийг олон улсын стандартын дагуу эдлүүлэх шаардлагатай байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны зөвлөмжийн 8 дахь заалт

Энэ талаар мэдээлэл ирүүлээгүй байна.

4.7. Жендэрийн эрх тэгш байдлын талаар

Зөвлөмж:

Жендэрийн тэгш байдлын тухай хуулийг нэн даруй баталж, Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонд холбогдох эрх хэмжээг олгох, эмэгтэйчүүдэд тэгш боломж олгоход чиглэсэн бодлого, цогц стратеги боловсруулах, олон улсын баримт бичгүүдэд нийцүүлэх мөн УИХ болон төр, хувийн хэвшлийн шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийг, ялангуяа орон нутаг дахь эмэгтэйчүүд, нийгмийн эмзэг бүлгийг хүйсээр алагчлах явдлыг арилгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

*НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 8 дугаар зөвлөмж,
НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 45-50, 102 дугаар зөвлөмж*

УИХ-аас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталж, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлсэн нь хүний эрхийг хангах, мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн нэн чухал ач холбогдол бүхий шийдвэр болсон. Хуулийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, салбарын болон орон нутгийн чадавхийг бүрдүүлэх, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого үйл явцад нэвтрүүлэх, хуулийн хэрэгжилтэд иргэний



нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн олон талт оролцоог хангах, нөөц бололцоо, санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 34 тоот тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Монгол Улсын Засгийн газраас энэхүү баримт бичгийг баталсан нь уг хуулийн бодит хэрэгжилтийг хангах, жендэрийн асуудал хариуцсан үндэсний тогтолцоо болон төрийн дээд, орон нутгийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх техникийн болон хүний нөөц, санхүүгийн нөхцлийг бүрдүүлэхэд дэвшилтэт алхам болсон байна.

4.8. Гэр бүлийн хүчирхийллийн талаар

Зөвлөмж:

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тууштай тэмцэх ялангуяа хүчин, гэр бүл дэх хүчирхийлэл болон бэлгийн халдлагыг гэмт хэрэгт тооцох, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг устгах, мэдээллээр хангах бодлого хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрийг мэддэг, зөв хандах чадвартай төрийн албан хаагчдыг бэлтгэх, хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдэд нөхөн олговор олгох тэднийг хамгаалалт /хамгаалалтад авах шүүхийн шийдвэр, эмнэлгийн шинжилгээ, нөхөн сэргээх эмчилгээ/-д нэн даруй авах шаардлагатай. Хүчирхийлэгч этгээдийг яллах, хэрэв буруутай нь тогтоогдвол түүнд таарах шийтгэлийг нь хүлээлгэж байх хэрэгтэй.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 18 дугаар зөвлөмж, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 54 дүгээр зөвлөмж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 20 дугаар зөвлөмж

Цагдаагийн байгууллагын гаргасан судалгаанаас харахад 2010 онд 284, 2011 онд 420, 2012 онд 534 эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж цагдаагийн байгууллагад хандсан байгаа юм. Далд хэлбэртэй энэ төрлийн гэмт хэрэг нийгмийн бүхий л давхаргын гэр бүлд гардаг ч хохирогчид тэр бүр цагдаагийн байгууллагад ханддаггүй байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандан үйлчилгээ хүсэгчид болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс амь нас, эрүүл мэндэд нь ноцтой аюул тулгарсан үед хамгаалах байрыг зорьдог, тус байраар үйлчлүүлэгчдийн тоо жил тутам өсч байна. 2012 оны байдлаар хамгаалах



байраар үйлчлүүлэгчдийн 64.2 орчим хувийг хүүхэд эзэлж байсан бөгөөд өнөөдөр тус төвийн ганцхан байр иргэдэд үйлчилж байна⁵⁵.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах байранд хүлээн авч, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг зөвхөн төрийн бус ганц, хоёрхон байгууллага л хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, энэ асуудал өнөөдөр гагцхүү төрийн бус байгууллагын нуруун дээр байсаар байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмнэлэг түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээнд хандан үйлчилгээ авсан хохирогчдын тоо сар тутам өсөн нэмэгдэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүчирхийлэл үйлдэгчийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл өссөөр байгаа боловч гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах асуудлыг зохицуулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хууль хэрэгжихгүй байхад нөлөөлж буй гол хүчин зүйл нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин цогцоор бүрдээгүйтэй холбоотой. Хэдийгээр хууль батлагдсан ч шаардлагатай зарим зохицуулалт нь хасагдсан, батлагдсантай нь холбогдуулан бусад хуульд оруулбал зохих нэмэлт, өөрчлөлт одоог хүртэл батлагдан гараагүй. Тухайлбал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах 41 шийдвэрийг шүүх гаргасан ч тэдгээр шийдвэрүүдийн нэг нь ч биелсэнгүй⁵⁶.

4.9. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар

Зөвлөмж:

Хүн худалдаалах гэмт хэрэг бүрийг мөрдөн байцаах, яллах, гэм буруутай нь тогтоогдвол тохирох шийтгэл оногдуулахад бүхий л арга хэмжээ авах шаардлагатай байгаагаас гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд гэрч, хохирогчийг хамгаалах дотоодын хууль тогтоомжийг сайжруулах, механизм бий болгох, хохирогчдод зориулж хамгаалах байр байгуулж ажиллуулахад бүхий л төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, хүний наймааны эсрэг хууль батлах, Палермогийн Протоколын хэрэгжилтийг хангах зорилгыг харгалзан Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу “Хүн худалдах ялангуяа хүүхэд,

⁵⁵ХЭҮК-т ХЭҮТ-өөс 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдөр өгсөн мэдээлэл

⁵⁶Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2009.



эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх,

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч, гэрчийг хамгаалах асуудлыг зохицуулсан хууль тогтоомж батлах, хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг бодлого хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой ял завших явдлаас сэргийлэхийн тулд хууль хэрэгжүүлэх болон шүүх тогтолцоог бэхжүүлэн сайжруулах ба бүх хохирогчдод нөхөн олговор олгож, боломжийн хэрээр нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах, институцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй.

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд, мөрдөн байцаагч, прокурор нарыг хүний наймаатай холбоотой хууль тогтоомж, практик сургалтад хамруулж, хүнийг наймаалсан гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр зүйлчлэх нь зүйтэй. Хүн хүч болон санхүүгийн хангалттай эх үүсвэр бүхий хүний наймаатай тэмцэх арга хэмжээний хэрэгжилтэд мониторинг хийдэг хараат бус механизмыг байгуулах, хүн наймаалахтай холбоотой аливаа гомдол, мэдээлэл /хууль сахиулах байгууллагын ажилтантай холбоотой мэдээлэл үүнд бас хамаарна/-ийг хөндлөнгийн оролцоогүй, нарийн чанд, үр дүнтэй байдлаар мөрдөн шалгах, энэ асуудлаар олон улсын, бүс нутгийн болон хоёр талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 21 дүгээр зөвлөмж, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 23, 24, 25, 43, 80, 81, 82, 83, 85, 86, 87, 94 дүгээр зөвлөмж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 21 дүгээр зөвлөмж

Монгол Улс “Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай” НҮБ-ын конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орж, хүний наймааны гэмт хэргийн шалтгаан нөхцлийг илрүүлж, хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр боловсруулсан Хүн худалдаалах гэмт гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-аар баталсан.

Зөвлөмж:

Бэлгийн мөлжлөгийн хохирогч болон бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, шуурхай мөрдөн шалгаж, хэрэгтэнг шийтгэл хүлээлгэхэд тулгарч буй саад тотгорыг арилгах шаардлагатай.

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 88-91 дүгээр зөвлөмж



Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан найман хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд хэргийг шалгаж шийдвэрлэхтэй холбоотой цагдаа, тагнуулын байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлжээ. Мөн хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн ял шийтгэл, хариуцлагыг чангатгасан байна. Өмнө нь торгууль төлөх хүртэл арга хэмжээ авдаг байсан бол шинэ хуулийн дагуу торгуулийн ялыг хасч, хүн худалдаалсан нь шүүхээр тогтоогдвол тухайн гэмт хэрэгтэнд хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцлийг нь харгалзан үзээд 3-15 жилийн хорих ял оногдуулж, эд хөрөнгө хураах ялыг давхар оногдуулахаар болжээ.

“Хүн худалдаалах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газраас 3 үе шаттайгаар (нэгдүгээр үе шат 2006-2008, хоёрдугаар үе шат 2008-2011, гуравдугаар үе шат 2011-2014) хэрэгжүүлж байна.

2012 оны байдлаар хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээг 2, хууль зүйн зөвлөгөөг 5, сэтгэл зүйн зөвлөгөөг 4 байгууллага тус тус өгч, 10 орчим байгууллага сургалт явуулах, чадавхжуулах үйлчилгээ явуулан хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажиллаж байна⁵⁷.

Гэвч гэрч, хохирогчийг хамгаалах дотоодын хууль тогтоомжийг сайжруулах, механизм бий болгох, хохирогчдод зориулж хамгаалах байр байгуулж ажиллуулахад бүхий л талаар төрөөс дэмжлэг үзүүлж, эх үүсвэрийг төвлөрүүлэх, хохирогчдод нөхөн олговор олгож, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах зэргээр НҮБ-ын хүний эрхийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.10. Нийгмийн халамжийн тухай

Зөвлөмж:

Нийгмийн эмзэг бүлгийн ялангуяа өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 38, 53, 59 дүгээр зөвлөмж

Нийгмийн халамжийн тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталж, дагаж мөрдөж байна. Дээрх шинэчлэн найруулсан хууль болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нийгмийн халамжийн тогтолцооны ерөнхий

⁵⁷ХЭҮК-Т ХАХНХЯ -наас пахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл, 2012.03.12-ны өдөр.



үзэл баримтлал нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн хэвээр байгаа бөгөөд гагцхүү халамжид хамруулах шалгуур, нөхцөл зэргийг өөрчилжээ.

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2012 оны 1 дүгээр сард УИХ-аас баталсан. Эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах Засгийн газрын 6 тогтоол, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын нийт 14 тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд болон бусад холбогдох яамдын сайдын хамтарсан 3 тушаал, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 3 тушаалаар батлагдах нийт 24 журам, дүрмийн төслийг боловсруулж, батлуулсан байна.

Зөвлөмж:

Шинээр 10 жилийн хугацаатай Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах механизмыг бэхжүүлэх Үндэсний хөтөлбөр батлах, сургуулийн боловсролын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах, сургуулиас завсардах (ялангуяа эрэгтэй хүүхдүүд)-ын эсрэг шаардлагатай арга хэмжээ авах

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 111, 112, 26, 27 дугаар зөвлөмж

Монгол Улсын Засгийн газар 2002 оноос 2010 он хүртэл “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, 2011 оноос 2016 он хүртэл “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги, төлөвлөгөө” батлан хэрэгжүүлж байна.

2011-2012 оны хичээлийн жилийн байдлаар 12025 суралцагч боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн хүрээнд боловсрол эзэмшсэнээс 1545 сурагч 9 дүгээр анги, 1119 суралцагч 11 дүгээр анги төгсч, суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх авсан байна. Мөн 9000 хүнийг бичиг үсгийн анхан, дунд, гүнзгий шат дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулсны дотор хийдэд шавилан суудаг 120, алслагдсан багт амьдардаг 78 хүүхдийг хамруулсан байна. 2013 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн сургалтын зардалд нийт 1,2 тэрбум төгрөгийг төсөвт тусгажээ.

Сургууль завсардсан хүүхдийн тоо 2009-2010 оны хичээлийн жилд 706, 2010-2011 оны хичээлийн жилд 543, 2011-2012 оны хичээлийн жилд 502 болж буурсан байна.



4.11. Эхийн эндэгдлийг бууруулах талаар

Зөвлөмж:

Эхийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг нэн яаралтай авах, улсын хэмжээнд түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах төсөл хэрэгжүүлж, орон нутагт шинэ эмнэлэг барьж ашиглалтад оруулах замаар эхийн эндэгдлийг бууруулах нь зүйтэй. Түүнчлэн хүндрэлтэй төрөлтийн үед эмнэлгийн тусламж нэн даруй авах нөхцлийг орон даяар бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 20 дугаар зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлсон билээ.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгох зорилгоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрвөн удаагийн хөтөлбөр⁵⁸, “Эхийн эндэгдлийг бууруулах” хоёр удаагийн стратеги⁵⁹-ийг хэрэгжүүлж, мөн “Эх нярайн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах нь” зөвлөгөөнийг 2012 онд зохион байгуулж, амаржих газрын дарга, эмэгтэйчүүд, эх нярайн эмч, эх баригч бага эмч, өрхийн эмч, сумдын эмч нарыг хэд хэдэн удаа сургалтад хамруулсан зэргээс үзэхэд эхийн эндэгдлийг бууруулахад ахицтай алхам болсон гэж үзэхээр байна.

Түүнчлэн энэхүү зөвлөмжид тусгагдсаны дагуу эхийн эндэгдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах, орон нутагт шинэ эмнэлэг барьж ашиглалтад оруулахад Эрүүл мэндийн яамнаас тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үндэсний түргэн тусламжийн сүлжээ байгуулах хөтөлбөрийг боловсруулан нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт түргэн тусламжийн салбар, Клиникийн I дүгээр амаржих газрын 150 ортой өргөтгөл, Баянхонгор, Хөвсгөл, Увс, Ховд аймгуудад 50 ортой, Говь-Сүмбэр аймагт 15 ортой төрөх тасгууд ашиглалтад оруулсан байна.

Мөн Эрүүл мэндийн яамнаас авсан мэдээллээс үзэхэд Эх нялхасын эрүүл мэндийн үндэсний төвийн /300 ортой/, Гуравдугаар амаржих газрын /150 ортой/, Булган, Завхан, Говь-Алтай, Дорноговь,

⁵⁸“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2012-2016 он, үндэсний хөтөлөр, Засгийн газрын 2012 оны 61 тоот тогтоол

⁵⁹Эх нярайн эрүүл мэнд, 2011-2015 он, стратеги, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 456-р тушаал



Сүхбаатар, Дорнод аймгуудад /50 ортой/ барилга шинээр баригдаж байгаа болон Өмнөговь аймгийн Ханбогд, Цогц-Цэций сумдад 50 ортой сумын эрүүл мэндийн төвийг 2013 онд барихаар төсвийг баталжээ.

Өмнөх жилүүдэд эхийн эндэгдэлд малчин эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр, 2004 онд гэхэд л 49%-тай байсан бол малчин эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд хүрч үйлчлэх тусламжийг сайжруулснаар 2010 онд 37%, 2012 онд 13% болж буурсан байна.⁶⁰ Улсын хэмжээнд эхийн амрах байр 339 ажиллаж, нийт амарвал зохих эхчүүдийн 77,9 хувь нь эхийн амрах байраар дамжин амаржиж байгаа нь төв суурингаас алслагдсан, малчин эхчүүдийг эмнэлгийн тусламжид ойртуулж, эхийн эндэгдлийг бууруулахад эерэгээр нөлөөлж байгаа болно.

Хөдөө орон нутагт өвөлжилтийн байдал хүндрэх байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, жирэмслэлт, төрөлтийн үед гарч болзошгүй хүндрэлээс сэргийлэх зорилгоор төрөх дөхсөн эхчүүдийг эхийн амрах байранд урьдчилан авчирч, амаржуулах талаар аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, удирдлагуудад зөвлөмж өгч ажилласнаар эмнэлгийн тусламж хожимдсон хүчин зүйл нөлөөлсөн эндэгдэл гараагүй гэж Эрүүл мэндийн яамнаас мэдээлж байна.

Гэтэл сүүлийн жилүүдэд эх, нялхасын эндэгдэл, төрөх явцад эмчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас эрүүл мэндээрээ хохирсон тухай мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг бус удаа гарсан билээ. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагаас энэ талаар бодитой судалгаа хийх, эмч, эмнэлгийн ажилтнуудын хариуцлага, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, төрөх эмнэлгийн орчин нөхцлийг сайжруулах талаар үйл ажиллагаагаа улам бэхжүүлэх хэрэгтэй байна.

4.12. Албадан хөдөлмөрийн бүх хэлбэртэй тэмцэх талаар

Зөвлөмж:

Албадан хөдөлмөрийн бүх хэлбэртэй тэмцэх, хүүхэд болон гар аргаар ашигт малтмал олборлогчдыг аюултай нөхцөлд хөдөлмөр эрхлэхийг нь зогсоох бүхий л шаардлагатай арга хэмжээ авах, ийм нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй томчуудын ажиллах нөхцлийг олон улсын хөдөлмөрийн стандарт болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан, Оролцогч улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид нийцүүлэн сайжруулах шаардлагатай. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжигчдийг эрүүгийн



хариуцлагад татах замаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх, хянах арга хэмжээ авах, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан туслалцаа эрэлхийлэх хэрэгтэй байна. Түүнчлэн Оролцогч улс гудамжны хүүхдийн нөхцлийг сайжруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай.

*НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны 22 дугаар зөвлөмж,
НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 92, 93, 117 дугаар зөвлөмж*

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн явцад нийгмийн сөрөг үзэгдлүүд олонтаа гарсны нэг нь хүүхдийн хөдөлмөрийн асуудал юм. Эдийн засгийн болон улс төрийн шинэчлэл нь гэнэтийн, таагүй үр дагаврыг авчирсан бөгөөд ядуурал, ажилгүйдэл, нийгмийн үйлчилгээний жигд бус хүртээмж, шилжилт хөдөлгөөн, хямд хүч ажиллуулах бизнесийн сонирхол, эмзэг бүлгийн хүмүүсийн гэр бүлийн орчин, тэдний өөртөө итгэх итгэл алдарсан байдал, эцэг эхийн хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголт хандлага буруу зэргээс үүдэн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх, ялангуяа эрүүл мэнд, бие бялдар, оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлсээр байна.

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар Монгол Улсад 2011-2012 оны байдлаар 5-17 насны 93,9 мянган хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 0,3% нь уул уурхайд, 81,7% нь хөдөө аж ахуйд, 3% нь боловсруулах үйлдвэрт, 11,8% нь худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тэдгээр хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дэлхийн хэмжээнд дэвшүүлэн тавьсан зорилтуудыг⁶¹ хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар 2011 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай” үндэсний хөтөлбөрийг 303 тоот тогтоолоор батлан 2012-2016 онд 2 үе шаттай хэрэгжүүлэхээр эхлүүлээд байна.

Шинэчилсэн Засгийн газрын бүтцийн хүрээнд Хүүхдийн төлөө Үндэсний газрыг шинэчлэн зохион байгуулж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт хамааруулсан нь хүн амын хөгжлийн бодлого, түүний дотор хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн үндсэн эрхийг хамгаалах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг дээшлүүлсэн.⁶²

⁶¹ Гааг хотноо болсон Дэлхийн бага хурал, 2010 оны 5 дугаар сар.

⁶² ХЭҮК-т Хөдөлмөрийн яамнаас 2013.03.18-ны өдөр ирүүлсэн мэдээллэл

Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн өсөлт уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт түлхүү байгааг дагалдан албан бус хэвшлийн хүрээ ч эдгээр салбарт өргөжиж, үүний улмаас улсын хэмжээнд албан бусаар уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа 70 гаруй мянган хүн байгаагийн дотор, олон мянган хүүхэд уг үйл ажиллагаанд туслах хэлбэрээр оролцож байгааг анхаарах хэрэгтэй.⁶³

4.13. Хүүхдийг тарчлаах шийтгэлийг бүхий л орчинд таслан зогсоох талаар

Зөвлөмж:

Тарчлаах шийтгэлийг бүхий л орчинд /сургууль, хүүхдийн байгууллага, гэр ялангуяа хөдөө орон нутагт/ таслан зогсоох арга хэмжээ авах, Боловсролын хуулиар тарчлаах шийтгэл, хүчирхийлэл хэрэглэхгүйгээр сурган хүмүүжүүлэх бусад хэлбэрийн хүмүүжлийн аргыг дэмжиж, тарчлаах шийтгэлийн хор уршгийн талаар олон нийтэд кампанит ажил зохион байгуулах замаар ухуулах шаардлагатай.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 23, 24 дүгээр зөвлөмж

Монгол Улсын хүн амын 37 хувийг хүүхэд, өсвөр үеийнхэн эзэлж байгаа, гэтэл манай орны 3 хүүхэд тутмын нэг нь аливаа төрлийн хүчирхийлэлд өртөж байдаг байна. Үүнээс 42.3% гэр бүлд, 53.2% нь сургуульд, 5% нь олон нийтийн газарт үйлдэгддэг байна. Мөн 71.1% нь бие махбодын, 41.9% нь сэтгэл санааны шийтгэлд өртдөг байна⁶⁴.

2007-2010 онд гэмт хэргийн халдлагад 4 342 хүүхэд өртөж, тэдгээрийн 434 буюу 10% нь нас барж, 2 473 буюу 57% нь гэмтсэн бол зөвхөн 2010 онд гэмт хэргийн халдлагад 1 066 хүүхэд өртөж хохирсны 86 буюу 8.1% нь нас барж, 568 буюу 53.3% нь гэмтсэн байна⁶⁵.

Бие махбодын шийтгэл хүний нэр төр, бие махбодын халдашгүй байдлыг хүндлэх суурь эрхийг зөрчдөг. Эцэг эх, багш, халамжлагч нарын хүчирхийллийг өршөөсөн, тусгайлан хамгаалсан зүйл заалтыг хууль тогтоомжид тусгаж өгснөөр хуулийн өмнө эрх тэгш хамгаалагдах эрхийг зөрчиж байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 19 дүгээр зүйлд зааснаар эцэг, эх, бусад этгээдийн халамжинд байх хугацаанд “бие махбодын, эсвэл

⁶³Эх сурвалжийг Хөдөлмөрийн яамнаас авсан болно. Ашигт малтмалын газрын 2011 оны мэдээг тусгав.

⁶⁴Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол” хүүхдэд үйлчилдэг зарим байгууллагад хийсэн судалгаа. Зохистой хөгжлийн жендэр төв, Их Британий ХИС, 2009

⁶⁵Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн шалтгаан нөхцөл” судалгаа ЦЕГ, 2011 он



оюун санааны хүчирхийллийн бүх хэлбэрээс” хүүхдийг хамгаалахыг гишүүн улс орноос шаарддаг. Бие махбодын бүх шийтгэлийг арилгах явдал нь эрх зүйн шинэчлэл болон олон нийтийн боловсролын хослол буюу хамтын ажиллагаа байдаг.

Хүүхдийн эрхийн конвенцид дотоодын хууль тогтоомжийг уялдуулах чиглэлээр Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2013 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцооны шинэчлэлийн асуудлыг тусгаад байна.

4.14. Үндэстний цөөнхийн эрхийн талаар

Зөвлөмж:

Уугуул иргэд болон омог, отгоор амьдардаг хүмүүст зохих хамгаалалт үзүүлэх

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 113 дугаар зөвлөмж

Үндэсний ээлжит хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон цөөнхийг төлөөлж буй байгууллагуудын оролцоог хангах

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 35 дугаар зөвлөмж

Казах иргэдийг сурч боловсрох боломжоор хангахад тодорхой арга хэмжээ авч байгаад Хороо талархаж байгаа ч казах хэлээрээ сурч боловсрох боломжгүй байгаад харамсаж байна. Оролцогч улс казах иргэддээ эх хэлээрээ сурч боловсрох боломжоор хангахыг Хороо зөвлөж байна.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 27 дугаар зөвлөмж

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2010 оны илтгэлд үндэстний цөөнх болох тува, казах иргэдийн эрхийг хангах талаар “...тэдний нийгмийн асуудлыг нэн даруй шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг боловсруулах, амьжиргааны эх үүсвэртэй болгох, аймаг, орон нутагт төрийн зүгээс хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг цөөнхийн төлөөллийг оролцуулах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах, ядуурлыг бууруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний нарийвчилсан болон иргэний бүртгэлийн судалгаа гаргах, үндэстний цөөнхийн хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх



асуудалд бодлогын чанартай өөрчлөлт хийх, тэдний эх хэлээрээ ярих, унших, мэдээлэл авах эрхийг хангах..." зэрэг асуудлаар санал, зөвлөмжийг өгч байсан билээ. Тухайн үед Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас сурах бичгийг казах хэл рүү орчуулах ажлыг 2008 оноос хойш ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой уялдуулан үе шаттайгаар хийж, тухайлбал 2010 онд бага ангийн зарим сурах бичгийг монгол хэлнээс казах хэл рүү орчуулж хэвлүүлсэн байна⁶⁶.

Мөн Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас казах сургуулиудын сурах бичгийн агуулгад судалгаа хийж, дүгнэлт гарган "Казах сургуулийн сургалтын агуулга" төслийн хүрээнд сурах бичгийн талаар аймгаас баримтлах бодлогын төслийг гаргаж, БСШУЯ-д танилцуулсан⁶⁷ тухай мэдээллийг ХЭҮК-ын 2010 оны илтгэлд оруулсан билээ. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сурах бичгээс "Математик" II, III, "Хүн орчин" II, III, "Дүрслэх урлаг технологи" II, III, "Дуу хөгжим" II, III зэрэг сурах бичгүүдийг казах хэл дээр Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас⁶⁸ тус тус гаргасан байна.

Түүнчлэн казах хэлнээс гадна тува хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлж, дунд сургуулиудад ашигладаг хэлний сурах бичгийг зохиох, хэвлэх болон монгол хэлнээс тува хэл рүү орчуулах ажлыг зохион байгуулаагүй нь харамсалтай байна.

Засгийн газраас цаатан иргэдийн амьжиргааны гол эх сурвалж болох цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай ч цаачдын нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж буй байдал, цаатан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл ирүүлээгүй байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагад үндэстний цөөнхийн төлөөлөл одоо хэр нь хангалтгүй байна. Тухайлбал Хөвсгөл аймгийн Цагааннуур сум, Баян-Өлгий аймгийн болон сумдын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад тухайн орон нутагт оршин сууж буй үндэстэн, ястнуудын төлөөллийг оруулах талаар төрөөс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн хууль тогтоомжийг үндэстний цөөнхийн эх хэл дээр орчуулж, хүртээмжтэй болгох нь туйлын хангалтгүй байгаагаас ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд иргэдийн хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх эрх зөрчигдөхөд хүрч байгааг анхаарах цаг нь болсон.

⁶⁶ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэл, 153 дахь тал, УБ., 2011.

⁶⁷ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэл, 154 дэх тал, УБ., 2011.

⁶⁸<http://www.meds.gov.mn/> Сурах-бичиг



Үндэстний цөөнхийн эрх зөрчигдсөн тохиолдлын хувьд дараах хоёр асуудлыг онцолмоор байна.

Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэнд олгодог мөнгөнтэтгэмжийг авах зорилгоор Баян-Өлгий аймагт оршин суудаг казах иргэдийн иргэний бүртгэл, мэдээллийг нь тодорхой бүлэг этгээдүүд хууль бусаар ашиглан хуурамч бичиг баримт бүрдүүлж, өөрсдөд нь мэдэгдэлгүй тэднийг Монгол Улсын иргэн харьяатаас хасуулан Казахстан Улсын иргэн болгож хохироох явдал цөөнгүй гарчээ. Төрийн албан хаагчийн оролцоотой үйлдэгдсэн энэхүү гэмт хэргийн улмаас нийгмийн халамж, үйлчилгээ хүртэх бүх боломж нь хаагдсан казах иргэдийн иргэншлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх, учирсан бодит хохирлыг барагдуулах талаар Казахстан Улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Мөн төвөөс алслагдмал хөдөө орон нутагт амьдардаг үндэстний цөөнх иргэдтэй холбоотой бүртгэл, архивын мэдээлэл устаж үгүй болсноос тэдний төрөөс олгож буй нийгмийн халамж, үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмж авах эрх нь хэрэгжихгүйд хүрсэн. Тодруулбал, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургууль 2000 онд шатсаны улмаас тэнд хадгалагдаж байсан архивын бүх материал устаж, тува иргэд хохирч үлдээд байна. Гэтэл холбогдох яам, газарт удаа дараа энэ талаар хандсан боловч өнөөг хүртэл асуудлыг шийдвэрлэж өгөхгүй хойрго хандаж байна.

4.15. Хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийн асуудлаар:

Зөвлөмж:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс /сэтгэцийн өвчтэй ч мөн адил/-ийн эрхийг баталгаажуулсан эрх зүйн хэм хэмжээг нэн түрүүнд батлах шаардлагатай байна. Эмнэлгийн үйл ажиллагаанд мониторинг хийх, хараа хяналт тавих механизмыг нэн яаралтай бий болгоно уу. Мөн сэтгэцийн өвчтэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмчлэх, асрах шинэ шинэ аргуудыг амьдралд нэвтрүүлж, сэтгэл зүй болон сэтгэл зүйн эмгэг судлалаар мэргэшсэн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны 26 дугаар зөвлөмж

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсныг 2009 онд УИХ соёрхон баталжээ. Тус конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл /2011/-ийн 25 дугаар зүйлд заасанчлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн



чиглэлээр, гэрийн сэргээн засалтын үйлчилгээг багаар үзүүлэх ажлыг шинээр нэвтрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахаар сэргээн засалтын эмч, гэмтлийн эмч, мэс заслын эмч зэрэг нарийн мэргэжлийн эмч нарт клиникийн сэргээн засалтын сургалтыг Сэргээн засахын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтарч 2008 оноос хойш зохион байгуулж байгаа талаар мэдээлэл ирүүлжээ⁶⁹.

Үүнээс үзэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийн хүрээнд нарийн мэргэжлийн эмч нарт сургалт явуулж байгаа нь сайшаалтай ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн үйл ажиллагаанд мониторинг хийх, хяналт тавих механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах асуудлаар ЭМЯ-наас ирүүлсэн мэдээнээс үзэхэд УИХ-ын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад, сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг түлхүү хуваарилах, нийгмийн халамжийн болон боловсролын тусгайлсан үйлчилгээг бий болгох, сэтгэцийн эмгэгтэй хүний нийгмийн асуудлыг дэмжих төв болон орон гэргүй асран хамгаалах хүнгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд зориулсан “Асрамжийн газар”-ыг аймаг, дүүрэгт байгуулах зэрэг зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгаж, мөн эмчилгээ хийлгэх талаар зөвшөөрөл өгөх, эмчилгээ, шинжилгээнээс татгалзах, эрүүл мэндийн үйлчилгээний талаар эрх бүхий этгээдэд санал, гомдол гаргах, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, сэтгэцийн эмгэгтэй хүний онош, эмчилгээний нууцыг хамгаалах зэрэг тэдний эрхийг хамгаалахад чиглэсэн заалтыг илүү тодорхой болгожээ⁷⁰.

Манай улсын хэмжээнд хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Эрүүл мэндийн тухай хууль (2011 он), Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль (2000 он), Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 210 дугаар тушаалаар баталсан “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай журам” болон Засгийн газраас баталсан Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөр (2010-2019 он)-ийг батлан гаргаж, үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа хэдий ч сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг эмчлэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах асуудал анхаарал татсаар байна⁷¹. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл

⁶⁹ГХЯ-наас ХЭҮК-г цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл, 2012.03.05-ны өдөр

⁷⁰ЭМЯ-наас ХЭҮК-т 2013.03.14-ний өдөр ирүүлсэн 16/952 албан тоот бичиг.

⁷¹ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, 4 дүгээр бүлэг, 93- 94 дэх тал, 2012 он.



ажиллагааны төлөвлөгөөний 4.1.6-д “эрх зүйн чадамжгүй, асран хамгаалагч шаардлагатай боловч асран хамгаалагчгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтнүүдэд зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх” тухай заасан⁷². Энэ ажлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хариуцан Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 2011-2012 онд хэрэгжүүлэхээр тусгажээ.

Үүний дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны дэргэд Эрүүл мэндийн яам, Хүний эрхийн Үндэсний Комисс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төлөө газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрыг оролцуулан хамтарсан ажлыг хэсэг байгуулж, зөвхөн сэтгэцийн эмгэгтэй асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бүтэн өнчин хүүхдүүдэд зориулсан төрөлжсөн асрамжийн газар байгуулахаар болсон ч харамсалтай нь одоо болтол хийсэн зүйлгүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах асуудлаар хэд хэдэн эрх зүйн зохицуулалт хийсэн нь сайшаалтай ч төрөлжсөн асрамжийн газруудыг аймаг, дүүрэгт барих асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

4.16. Хүний эрхийн үндэсний байгууллагын талаар

Зөвлөмж:

“А” үнэлгээтэйгээр магадлан итгэмжлэгдсэн Хүний эрхийн Үндэсний Комисс нь Жендэрийн тэгш байдлын тухай хууль боловсруулах, цаашлаад түүнийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэвэл зохино.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 6 дугаар зөвлөмж

2011 оны 2 дугаар сард УИХ-аас баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 23, 24, 26 дахь заалтуудад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гүйцэтгэх чиг үүргийг тусгасан. Тус хуулийн дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн тухай гомдол хүлээн авч шийдвэрлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаар УИХ-д хоёр жил тутам илтгэж байх үүрэг хүлээж байна.

⁷²ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл, 4 дүгээр бүлэг, 93- 94 дэх тал, 2012 он.



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийт, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудад сурталчлан таниулах, жендэрийн эрх тэгш байдлыг хөндсөн хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч шалгах, шийдвэрлэхтэй холбоотой бий болсон нэмэлт чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүн хүч, хөрөнгө нөөцийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөвт тусгаж өгөөгүй байна.

Зөвлөмж:

Хангалттай төсөв, хүн хүчээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг хангах замаар энэ байгууллагын хараат бус байдлыг хамгаална уу. Түүнчлэн томилгооны процессыг өөрчлөх арга хэмжээ авна уу.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 5 дугаар зөвлөмж

Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагыг томилох ажиллагааг олонд нээлттэй байлгах аас гадна томилгооны үед иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдийн оролцоог нэмэгдүүлэх зэргээр ил тод байдлыг хангах шаардлагатай байгааг анхаарна уу.

Оролцогч улс нь Үндэсний Комиссын бие даасан байдал, бүрэн эрхийг нь тус тус бэхжүүлэхээс гадна элдэв янзаар үйл ажиллагааг нь хязгаарлахгүй байх хэрэгтэй. Түүнчлэн үйл ажиллагаагаа явуулахад нь шаардагдах хангалттай хэмжээний хүн хүч, хөрөнгө мөнгө, эд материалаар Комиссыг хангана уу.

Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа баривчлах байруудад системтэй, гэнэтийн шалгалт хийх, эрүүдэн шүүхтэй холбоотой өргөдөл гомдлыг авч үзэх, хохирогчдод нөхөн олговор олгосон эсэх, нөхөн сэргээлтэд хамруулсан эсэхийг шалгах зэрэг эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст олгох шаардлагатай байна. Эрүүдэн шүүхийн асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулахдаа Хүний эрхийн Үндэсний Комисстой заавал хамтрах хэрэгтэй. Түүнчлэн хүний эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулахдаа Комиссыг оролцуулж байна уу.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 12 дугаар зөвлөмж

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь “НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1993 онд баталсан Хүний эрхийн Үндэсний



Байгууллагуудын талаарх Парисын зарчмуудад бүрэн нийцсэн хараат бус, бие даасан, үндэсний байгууллага билээ. Үүнийг илэрхийлж Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон улсын Зохицуулах Хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст 2003, 2008 онуудад “А” статус олгож байв. Комисс 2013 онд Олон улсын Зохицуулах Хорооны магадлалан итгэмжлэлд дахин орох ёстой юм. “А” статус бүхий үндэсний байгууллага нь НҮБ-ын байгууллагууд болон гэрээний хороодын хуралдаанд үг хэлэх эрхтэй байдаг бөгөөд энэ нь Монгол Улсын олон улсын нэр хүндэд чухал ач холбогдолтой.

Комисс нь хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих өргөн чиг үүргийн хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Харин бүтэц, орон тооны хувьд цомхон, одоогоор 3 гишүүн, 25 албан хаагчтай, орон нутагт салбар, нэгжгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь Комиссын төсвийн асуудалтай шууд холбоотой юм. Өнгөрсөн хоёр жилд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв, ялангуяа үйл ажиллагааны зардлыг нэмүүлэх талаар Комиссын удирдлагын зүгээс хүчин чармайлт гаргасны үр дүнд байгууллагын төсөв 2010 оныхтой харьцуулахад 56 хувиар нэмэгдлээ. Мөн НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Ази Номхон далайн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы санаачилга, дэмжлэгтэйгээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс өөрийн чадавхийн үнэлгээг хийсэн бөгөөд үүний үр дүнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 3 жилийн хугацаатай “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг дээшлүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Хэдийгээр төсөв нэмэгдэж, олон улсын байгууллагын дэмжлэг авч байгаа боловч үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах буюу орон нутагт байнга ажиллаж, хүний эрхийн талаар мэдээлэл цуглуулах, нөхцөл байдалд мониторинг хийх, орон нутгийн, ялангуяа алслагдсан аймаг, сумдын иргэдэд зөвлөгөө өгөх, хүний эрхийн мэдээлэл, мэдлэг олгоход хүндрэл, бэрхшээл тулгарсан хэвээр байна.

4.17. Өмгөөлөгчдийн холбооны талаар

Зөвлөмж:

Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцуудын талаар шүүгч, өмгөөлөгчдөд зориулсан албадлагын шинжтэй сургалт, үргэлжилсэн сургалт байнга зохион байгуулах хэрэгтэй. Түүнчлэн шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхэд шүүх ажиллагаанд Пактыг хэрэглэх явдал нөлөөлөхгүй байх нөхцлийг Оролцогч улс бүрдүүлэх шаардлагатай.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 4 дүгээр зөвлөмж



Оролцогч улс өмгөөлөгч, Монголын өмгөөлөгчдийн холбооны бие даасан байдлыг баталгаажуулахад бүхий л арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн улсын хэмжээнд эрх зүйн туслалцааны төвүүдийг хүн хүч, хөрөнгийн эх үүсвэрээр хангах замаар эрх зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал тавих шаардлагатай.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 22 дугаар зөвлөмж

2012 онд Монгол Улсын Засгийн газраас эрх зүйн туслалцааны хүн хүч нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулжээ. Тухайлбал, Хууль зүйн яамнаас хуульч сонгон шалгаруулах шалгалтыг зохион байгуулж, тодорхой тооны иргэдэд Хуульчийн гэрчилгээ олгож хүн хүч нэмэгдүүлсэн байна. Мөн өмгөөлөгчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний мэргэшсэн байдлыг сайжруулах үүднээс мэргэшлийн шалгаруулалтуудыг зохион байгуулсан байна.

Хөдөө, орон нутагт өмгөөллийн үйлчилгээний хүртээмж, хүрэлцээ хангалтгүй байгааг харгалзан Хууль зүйн сайдын 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/55 дугаар тушаалаар өмгөөлөгчийн мэргэшлийн шалгаруулалтыг Өвөрхангай аймгийн төвд зохион байгуулсан байна.

2012 онд нийт 81 хүнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ. Харин Эрх зүйн туслалцааны төвийн нийт 37 өмгөөлөгчийн гэрээг шинээр байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн нийт 37 эрх зүйн туслалцааны төвүүдэд үйл ажиллагааны санхүүжилт олгох тухай гэрээг боловсруулж батлуулсан байна.

Хууль зүйн яамнаас Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч, сурталчилгааны ажилтнууд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Завхан аймагт, эрх зүйн туслалцааны нийт өмгөөлөгчдөд ээлжит сургалт, семинарийг зохион байгуулжээ.

Тус яамнаас зохиосон “Эрх зүйн туслалцааны төв” аяны хүрээнд нийт 37 эрх зүйн туслалцааны төвийн ажилтнууд Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Тариат, Завхан аймгийн Тосонцэнгэл, Улиастай сумдад ажиллаж, 250 орчим иргэнд хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгч, эрх зүйн туслалцааны төвүүдийн үйл ажиллагааг сурталчлан орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээсэн байна.



4.18. Цэргийн дүйцүүлэх албаны талаар

Зөвлөмж:

Улс төр, шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар цэргийн алба хаахаас татгалзсан хүн бүрт зориулсан цэргийн дүйцүүлэх алба бий болгохыг Хороо зөвлөж байна. Гэхдээ дүйцүүлэх алба нь мөн чанар, зардал, цаг хугацааны хувьд алагчилсан буюу шийтгэлийн шинжтэй байж болохгүй.

НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 23 дугаар зөвлөмж

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт “Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн болон энэ хуульд заасан бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно” гэж заасан байдаг бөгөөд цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах анги, отряд, салбар хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба хаахаар хуульд заасан байдаг.

Уг албыг хаах хугацаа 24 сар байх бөгөөд гамшгаас хамгаалах ажиллагааны хойшлуулшгүй арга хэмжээ, улсын хил хамгаалалтын зайлшгүй шаардлагыг харгалзан Засгийн газар энэхүү хугацааг 3 хүртэл сараар сунгаж болдог. Үүнээс гадна мөн хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “... цэргийн жинхэнэ алба хаагаагүй 27 нас хүрсэн эрэгтэйчүүд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулж хаахаар тус хуульд заасан байна.

Үүний дагуу УИХ-ын 2009 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолоор “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”, “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ”, Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолоор “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ыг тус тус баталсан байдаг.

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах мөнгөн төлбөрийн хэмжээг хугацаат цэргийн албан хаагчийн хангамж, үйлчилгээний тухайн жилийн дундаж зардлаар тооцож Засгийн газар жил бүр тогтоодог.

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах, эсхүл төлбөрөөс чөлөөлөх үндэслэлийг сум, хорооны Засаг дарга, тухайн иргэний ажиллаж байгаа байгууллагын тодорхойлолт, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гэрлэлтийн бүртгэл, нийгмийн халамжийн



дэвтэр, эмнэлгийн магадлагааг тус тус үндэслэн цэрэг татлагын товчооноос иргэн бүрээр гаргаж, аймаг, дүүргийн Цэргийн штабт саналаа оруулдаг. Аймаг, дүүргийн Цэргийн штаб нь уг үндэслэл, саналыг магадлан хянаж, дүгнэлтийн хамтаар аймаг, дүүргийн Засаг даргад уламжлах бөгөөд эцсийн шийдвэрийг Засаг дарга гарган шийдвэрлэж байна. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэн Дайчилгааны тухай хуульд заасны дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад хамрагддаг байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийн энэ бүлэгт НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буй талаар холбогдох яам, газруудаас авсан мэдээллийг танилцууллаа⁷³. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 362 дугаар тогтоолоор “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай үндэсний илтгэл бэлтгэх журам”-ыг баталсан байдаг. Тус журмаар олон улсын конвенциудыг яамд, Засгийн газрын байгууллагуудад хариуцуулж өгчээ. Харамсалтай нь энэ нь салангид, уялдаа холбоогүй байдалд хүргэж байгаагаас Засгийн газрын илтгэлийн агуулга, мэдээлэл тун хангалтгүй, хэлбэрийн төдий болж хувирч байна. НҮБ-ын түвшинд улс орнуудын тайланг хэлэлцэхдээ дан ганц гэрээний хүрээнд хамаарах асуудлаар хязгаарлагдахгүйгээр бусад гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буй тухай ч асуудаг. Гэтэл тайлан боловсруулж байгаа албан хаагчид нь аргачлал, мэдээлэл муутай байгаа нь тайлангийн чанарт сөргөөр нөлөөлдөг.

Түүнчлэн НҮБ-ын хүний эрхийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг албан ёсоор орчуулдаггүй, олон нийтэд түгээдэггүйгээс зөвлөмжийн талаарх мэдлэг ойлголт, мэдээлэл хомс байна. Иймд салбар бүрийн төлөөлөл бүхий тогтмол үйл ажиллагаатай бүтцийг бий болгох нь зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ч, ээлжит тайланг чанартай цаг хугацаанд нь бэлтгэн хүргүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

НҮБ-ын гэрээний хороодын үйл ажиллагаа, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн аль аль нь улс орныг чичлэн шүүмжлэхийг чухалчлах бус харин хүний эрхийн нөхцөл байдлыг нь үнэлж, анхаарал хандуулах, зөрчил, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн асуудлыг нааштайгаар шийдвэрлэх чадавхийг бэхжүүлэх, улс орнуудад нэг нэгнийхээ шилдэг туршлагаас суралцах боломж олгох зорилготой байдаг учраас НҮБ-ын гэрээ конвенцийг хэрэгжүүлэх, хэрхэн хэрэгжүүлж буй тухай тайланг чанаржуулах, зөвлөмжийг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай билээ.

⁷³Хүний эрхийн үндэсний байгууллагын тухай мэдээллээс бусад хэсэг хамаарна.



**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС ШИЙДВЭР
ГАРГУУЛАХААР ДАРААХ САНАЛЫГ УЛСЫН
ИХ ХУРАЛД ХҮРГҮҮЛЖ БАЙНА**

**Уул уурхайн хөгжлийн хүний эрхэд үзүүлж
буй нөлөөтэй холбоотойгоор:**

1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрсэдсэн, бие эрхтэн, сэтгэл санааны хохирол учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх механизмыг бий болгох, хохирол нэхэмжлэх эрхийг тодорхой болгох;
2. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийгээгүй, Ашигт малтмалын тухай хуулийг зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах, нутгийн иргэдэд нөхөн сэргээлтийн үйл явц, үр дүнгийн талаар санал өгөх боломжийг олгох, хяналтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад олгох;
3. Нүүрс, төмрийн хүдэр зэрэг овор ихтэй ашигт малтмал ашиглах бол тухайн орон нутгийн иргэдийн хүний эрх, эрх чөлөөг хангахад шаардагдах төмөр зам, хатуу хучилттай замыг байгуулсны дараа олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл олгох зохицуулалтыг хуульчлах, мөн уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой автомашины болон замын даац, ашиглалтын талаарх бодлого, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн батлах;
4. Уул уурхайн салбарт ажиллагсдын ажлын аюулгүй байрыг бий болгох асуудлаарх Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Уул уурхайн үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох, иргэд, уул уурхайн салбарт ажиллагсдыг гэмтэл осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх механизмыг ажиллуулах, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах ажлыг төрөөс зохион байгуулах;
5. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгоор “Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах тухай” конвенцид нэгдэж орох, ашигт малтмал хайх, олборлох, байгаль



орчныг нөхөн сэргээх болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Хүүхдийн эрхийн чиглэлээр:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн гуравдугаар нэмэлт протоколд нэгдэн орох;
2. Хүүхдийн эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох;
3. Бүх нийтийн ерөнхий боловсрол, суурь боловсрол олгох нөхцлийг бүрдүүлсэн, шашны тусгай сургалттай сургуулиудыг үндэсний хэмжээнд бүсчилэн шинээр байгуулах;
4. Тусгай сургуулиудын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сургуулийн онцлогт тохируулах, цэцэрлэг, дотуур байр бүхий ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс бүрдсэн цогцолборуудыг үндэсний хэмжээнд шинээр байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх, боловсрол, нийгэм, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангуулах чиглэлээр бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах;
5. Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах.

ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн асуудлаар:

1. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүний эрхийн Хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн лесбиан, гей, бисексуал, трансжендер хүний эрхэд хамаарах зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
2. Лесбиан, гей, бисексуал, трансжендер хүмүүсийн талаарх нийгмийн сөрөг сэтгэл зүй, буруу хэвшмэл ойлголт, үзэл хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгааны идэвхтэй, үр нөлөөтэй арга хэмжээг бодлоготой авч хэрэгжүүлэх.



НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар:

НҮБ-ын гэрээний хороод, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, НҮБ-ын тусгай илтгэгч, ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж байх.

Хавсралт 1

“МОНГОЛ УЛС ДАХЬ УУЛ УУРХАЙН БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ОЛОН УЛСЫН БАГА ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

**Улаанбаатар хот, Монгол Улс
2012 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдөр**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” сэдэвт олон улсын бага хурлыг 2012 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Ази, Номхон Далайн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулган болон Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй зохион байгууллаа.

Хуралд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн аж ахуйн нэгж, хүний эрх, байгаль орчны чиглэлээр ажилладаг олон улсын болон үндэсний төрийн бус байгууллагууд, гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэд, малчид, бичил уурхай эрхлэгчид, Ази, Номхон Далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагууд, элчин сайдын яамд, НҮБ-ын хүний эрхийн шинжээч зэрэг 200 орчим хүн оролцов.

Хуралд оролцогчид хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас баримталж буй зөв зүйтэй, оновчтой бодлогыг сайшаав. Мөн уул уурхайн салбарын Монгол Улсад оруулж буй жинтэй хувь нэмрийг хүлээн зөвшөөрөхийн сацуу, уул уурхайн үйл ажиллагаанаас бий болсон сөрөг үр дагавар их байгааг хүлээн зөвшөөрлөө. Оролцогчид эдийн засгийн болон бусад үр өгөөжийг хамгийн дээд хэмжээгээр нэмэгдүүлэх, үр шимийг нь Монгол хүн бүрт хүртээх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар уул уурхайн сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд хүртэл бууруулахыг эрмэлзэж буйгаа илэрхийллээ.



Хуралд оролцогчид Монгол Улсын уул уурхайн бизнесийн бодлого, хууль эрх зүйн орчин хүний эрхэд суурилагагүй, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо дутмагаас шалтгаалж хүний эрх зөрчигдөж байгааг онцлон тэмдэглэлээ.

Хуралд оролцогчид НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн Удирдах Зарчмыг сайшаан дэмжиж, Удирдах үндсэн 3 зарчмын хүрээнд хамаарах хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тус тусын үүргээ шударгаар сахин биелүүлэхийг төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудад уриаллаа.

Төр уул уурхайн салбарт хүнээ хамгаалах бодлогод чиглэсэн бүхий л гэрээ хэлэлцээр болон Бизнес ба Хүний эрхийн Удирдах зарчмыг мөрдүүлэх шаардлагатай бөгөөд ингэхдээ хүний эрхэд суурилсан хууль тогтоомж, бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудал тулгамдаж байгааг санал нэгтэй цохон тэмдэглэлээ.

Хүний эрхэд суурилсан, хариуцлагатай уул уурхайн бизнесийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох бүх талууд хамтран ажиллаж, ахиц дэвшил гаргахыг эрмэлзэх нь нэн чухал болохыг онцлон тэмдэглэж, олон улсын бага хуралд оролцогчдын санал, дүгнэлтийг тусгасан дараах зөвлөмжийг гаргаж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД:

1. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгоор “Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах тухай” конвенц (Аархусын конвенц), уул уурхайн салбарт ажиллагсдын ажлын аюулгүй байрыг бий болгох асуудлаарх Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Уул уурхайн үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид тус тус нэгдэн орох;
2. Зөвхөн стратегийн ач холбогдолтой орд газрыг ашиглахаас бусад тохиолдолд бэлчээрийг уул уурхайн үйл ажиллагаанд ашиглахыг хориглох, өдгөө ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд бэлчээр ашиглаж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагааг тусгай бодлогоор нөхөн зохицуулах;
3. Ашигт малтмал хайх, олборлох, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;



4. Уурхайн олборлолтоос үүссэн талбай, нүх, суваг шуудуу, овоолго, хөрсний эвдрэлийн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн аж ахуйн нэгжээр заавал хийлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлтийн үйл явц, үр дүнгийн талаар санал өгөх боломжийг нутгийн иргэдэд олгох, хэрэв уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ үүргээ биелүүлээгүй бол аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгодог, дахин тусгай зөвшөөрөл олгодоггүй байх зохицуулалтыг бий болгож, хяналтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад олгох.
5. Нүүрс, төмрийн хүдэр зэрэг овор ихтэй ашигт малтмал ашиглах бол тухайн орон нутгийн иргэдийн хүний эрх, эрх чөлөөг хангахад шаардагдах төмөр зам, хатуу хучилттай замыг байгуулсны дараа олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл олгох зохицуулалтыг хуульчлах, мөн уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой автомашины болон замын даац, ашиглалтын талаарх бодлого, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн батлах;
6. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уурхайн талбайг бусдад дамжуулан түрээсэлж буюу худалдаж байгаагаас аливаа хохирлыг хариуцах эзэнгүй болгох, зарим иргэдийг зохион байгуулалтгүй, эмх замбараагүйгээр ашигт малтмал олборлох байдал руу түлхэх, хяналтгүй болгох, татвараас зайлсхийх, нөхөн сэргээлт хийлгүй орхих зэрэг дутагдал гарах үндэс болж байгаа тул ийм үйлдлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
7. Бичил уурхайчдыг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрхийг хангаж, хамгаалах эрх зүйн орчныг бий болгох, бичил уурхай эрхлэгчид болон орон нутгийн удирдлагуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр бичил уурхай эрхлэгчдээс авах орлогын албан татварын хэмжээг бодитой тогтоох;
8. Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан геологи хайгуулын ажлын төсөл, тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд бүхэлд нь нууцад хамааруулахаар заасныг өөрчлөх;
9. Ашигт малтмал хайх, ашиглах явцад байгаль орчинд хохирол учруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах;
10. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд болон иргэдэд хохирол учруулсантай холбоотой асуудлаар иргэн, иргэний нийгмийн



байгууллага, сонирхогч этгээд нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх механизмыг бий болгох;

11. Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, дэмжих, ажиллах нөхцлөөр хангахад чиглэгдсэн эрх зүйн орчныг бий болгох;
12. Иргэдийн ундны цэвэр усаар хангагдах эрхийг баталгаажуулах, Монгол Улсын гадаргын усны нөөцийн 70 хувийг бүрдүүлж буй сав газрын эхэд хамаарах хэсэг, газрын доорхи цэнгэг усны орд газруудыг улсын тусгай хамгаалалтад авах, усны нөөцийг нарийвчлан тогтоож, зөвхөн гадаргын усыг нөөцөлж, үйлдвэрлэлд ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, холбогдох байгууллагуудад олборлолтод шаардагдах усны нийт хэмжээ болон олборлолтын явцад ашиглаж буй усны хэрэглээгээ заавал тайлагнах зохицуулалтыг хуульд тусгах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

13. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч барагдуулах боломжгүй болсон тохиолдолд тухайн хохирогчид төр нөхөн төлбөр олгож, нөхөн төлбөр болон үүнтэй холбогдож гарсан бусад зардлыг буруутай этгээдээс гаргуулан авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Түүнчлэн үүний улмаас хүний амь нас эрсэдсэн, бие махбод, сэтгэл санааны хохирол учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх механизмыг тусгайлан бий болгох, хохирол нэхэмжлэх эрхийг тодорхой болгох;

14. Орон нутагт гарч байгаа хүний эрхийн зөрчил, гомдлыг шуурхай шалгаж, шийдвэрлэх, хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх чиг үүргээ бодитойгоор хэрэгжүүлэх бололцоог хангах үүднээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг орон нутагт төлөөлөгчтэй болгох;
15. Уул уурхайн салбарт гарсан зөрчил, маргаан, гомдлыг хараат бусаар, шуурхай шийдвэрлэх орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн оролцоотой механизмыг ил тод, нээлттэй байгуулах;

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ:**

16. “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай”, “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” болон “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” конвенциудыг хэрэгжүүлэх;
17. Их Британийн Гадаад Харилцааны Яам, АНУ-ын Төрийн Департамент болон олборлогч компаниуд, хүний эрхийн салбарт тэргүүлэгч төрийн бус байгууллагуудын хамтран гаргасан “Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчим”-д нэгдэх;
18. Өмнеговь аймгийн Гашуун сухайт хилийн боомтын ойролцоох Цагаан хадны нүүрс дамжуулан зөөвөрлөдөг цэгийг нэн даруй хааж, дахин ийм газар үүсгэхийг хориглосон шийдвэр гаргах;
19. Гол мөрөн, нуурын усны нөөцийг хамгаалах тухай хууль тогтоомж, зохицуулалтыг чанд хэрэгжүүлэх. Уурхайн талбай болон тухайн хүрээлэн буй орчин дахь усны чанарыг хадгалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усыг ариг гамтай хэрэглэх, усны алдагдлыг бууруулах стандартыг батлах, үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэж байгаа усны үнийг бодитой тогтоох, усыг дахин ашиглах технологийн шийдэл боловсруулах, уг шийдлийг практикт нэвтрүүлэхийг дэмжих;
20. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг нийтэд мэдээлэх тухай Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.10 дахь заалтыг чанд хэрэгжүүлэх;
21. Яам, агентлаг болон төрийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, бизнесийн байгууллагад хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмаа шинэчлэх;
22. Иргэд, төрийн бүх шатны байгууллагуудад мэдлэг олгох олон улсын холбогдох гэрээ, үндэсний хууль тогтоомжийн талаарх сургалт, сурталчилгаанд шаардагдах хөрөнгийг төсөвлөж, зарцуулах;
23. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг хянан шалгах үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудын ажилтнуудыг чадавхижуулах, хүрэлцээтэй нөөц, хэрэгцээтэй тоног төхөөрөмжөөр хангаж энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, хараат бусаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх;



24. Холбогдох байгууллагуудын цацраг идэвхит, химийн хортой бодисыг хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, бүртгэх, тээвэрлэх, хэрэглэх, хадгалах, устгах бүхий л үйл ажиллагаанд тавих нэгдсэн хяналтын тогтолцоог бий болгох;
25. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон зарим орд газрыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны үнэлгээг хийсний үндсэн дээр цаашид ашиглах эсэх асуудлаар шийдвэр гаргах;
26. Нөлөөллийн үнэлгээг олон улсын стандартуудын дагуу эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засгийн ашиг орлого болон хот, аймаг, сумын төв орчмын уул уурхайн үйл ажиллагааны дэд бүтэц болон бусад шаардлагатай хүрээг хамруулан хийх. Нөлөөллийн үнэлгээг уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдэд ойлгомжтой, энгийн хэлээр мэдээлэх, үнэлгээний зөвлөмжид тулгуурлан цаашид хийх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ тэдний оролцоог хангах;
27. Бичил уурхайчдыг бүртгэлжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, олборлосон бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах шударга зохицуулалтыг бий болгох, бичил уурхайн үйл ажиллагаанд саад учруулж буй одоогийн зохицуулалт, холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох, уурхайн хамрах хүрээ, тооноос хамааруулан аймгийн Хөдөлмөрийн хэлтэст уул уурхайн асуудал хариуцсан тусгай мэргэжилтнийг ажиллуулах;
28. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийг ажлын байраар хангах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, зохион байгуулалттай, хариуцлагатай бичил уурхай болж өөрчлөгдөхөд нь дэмжлэг үзүүлж ажиллах;
29. Уул уурхайн үйл ажиллагаа өргөжиж байгаа орон нутгийн нийгмийн асуудалд анхааралтай хандаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх;
30. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, албан тушаалтан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх;
31. Иргэдийн оролцоогүй хийгдсэн, тухайн улс орны иргэдийн эрх, ашигт хохирол учруулахуйц зүйл, заалт агуулсан тогтвортой байдлын гэрээгээ өөрчилсний төлөө хөгжиж буй улс орнуудад олон улсын



шүүхээс хариуцлага тооцож байгаа явдалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох хүсэлтийг НҮБ-ын Бизнес ба Хүний эрх Ажлын хэсгийн гишүүдэд тавих.

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГУУДАД:

32. Иргэдийн эрх, эрх чөлөөг дээдлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэн хэрэгжүүлэх. Орон нутгийн иргэдийн хүний эрхийн талаарх болон нутгийн захиргаа, бизнес эрхлэгчидтэй хэрхэн харилцах тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх;
33. Уул уурхайн компанитай хийх хамтын ажиллагааны гэрээнд аймаг, сумыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө, байгаль орчинд нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөнд багтсан зорилт, үйл ажиллагааг тусгах, иргэдэд ил тод байлгах;
34. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой зөрчил маргааныг шийдвэрлэхдээ гурван талт зөвшилцлийн механизмыг өргөн ашиглах, иргэний нийгмийн төлөөллийг нутгийн иргэд өөрсдөө сонгодог байх;
35. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарсан хохирлыг нөхөн төлүүлэх явдлыг баталгаажуулахын тулд төр, иргэний нийгмийн болон холбогдох бусад байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллах. Хохирлыг тооцохдоо зөвхөн малын тоо толгойн хорогдол, малын ашиг шимийн алдагдал, малчдын амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөө зэргээр хязгаарлахгүй байх.

УУЛ УУРХАЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД:

36. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд нэн тэргүүнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:
 - а. Усны нөөцийг зүй зохистой, хариуцлагатай хэрэглэх, бохирдлоос сэргийлэх явдлыг хангах. Хэрэв болгоомжгүй байдлаас ус бохирдсон тохиолдолд сөрөг нөлөөг бууруулах боломжит арга хэмжээг авах, хамаарах бүх этгээдэд нэн даруй мэдэгдэх;
 - б. Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх, доройтсон тохиолдолд өмнөх байдалд нь оруулах;
 - в. Малчид, сум, багийн захиргааны байгууллагатай хамтран уул уурхайн талбайд болон түүний ойр орчимд



малчид болон мал эндэхээс хамгаалах урьдчилан сэргийлсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

37. Их Британийн Гадаад Харилцааны Яам, АНУ-ын Төрийн Департамент болон олборлогч компаниуд, хүний эрхийн салбарт тэргүүлэгч төрийн бус байгууллагуудын хамтран гаргасан “Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчим”-д нэгдэх;
38. Бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх нийгмийн хариуцлагаа хүлээн зөвшөөрөх;
39. Бизнесийн гол стратегийн нэг хэсэг болох “хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ”-г төсөл, хөтөлбөр тус бүр дээр тогтмол хийх;
40. Олон улсын шилдэг туршлагад тулгуурлан “Хүний эрхийн бодлого” боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
41. Хүний эрхийн чиглэлээр гомдол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгох;
42. Үйл ажиллагаагаа ил тод явуулах, мэдээллээ иргэдэд ойлгомжтой, энгийн үг хэллэгээр хүргэхэд анхаарах;
43. Хэрэв хүний эрх зөрчигдсөн бол үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч, дотоодын болон олон улсын хууль тогтоомж, шилдэг туршлагад нийцүүлэн зөрчигдсэн эрхийг нэн даруй сэргээх;
44. Монголчуудын нүүдлийн соёл, уламжлалын талаар, ялангуяа тэдний амьжиргаанд уул уурхайн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж байгааг судалж, уламжлалт зан заншил, эрхийг нь хүндэтгэх.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД:

45. Нөлөөллөө тэлэх зорилгоор аливаа асуудлаар холбогдох байгууллагууд, ялангуяа Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх;
46. Уул уурхай болон байгаль орчны асуудлаар олон нийтийг сургахад төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;
47. Уул уурхайн салбар дахь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тодорхой асуудалд холбогдох байгууллага, ялангуяа Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон олон нийтийн анхаарлыг хандуулах;



48. Бусад байгууллагуудтай хамтран ажиллах замаар уул уурхайтай холбоотой шийдвэр гаргахад хамаарал бүхий талуудын тэгш оролцоог хангах явдлыг институтчилэх нөлөөллийн үйл ажиллагааг улам идэвхжүүлэх;
49. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, тухайн төлөөлөгчид уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн үйл явцыг шалгах боломж олгох.

**ЭНЭХҮҮ ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ, ТӨРИЙН, ОЛОН
УЛСЫН БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУД,
ИРГЭДИЙН ХУРАЛД ТАВЬСАН ИЛТГЭЛ, ДЭВШҮҮЛСЭН САНАЛЫГ ТӨРИЙН
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРТ ТУСГУУЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ
МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ ХАРИУЦУУЛАВ.**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

*Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн
Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Ази-Номхон далайн чуулганы НБДНГазар
НҮБ-ын “Бизнес ба Хүний эрх” Ажлын хэсэг
НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар
Филиппин Улсын Хүний эрхийн Комисс*

*Монгол Улсын Уул уурхайн яам
Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Монгол Улсын Хөдөлмөрийн яам
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Дундговь аймгийн Засаг дарга*

*Швейцарийн элчин сайдын яам
Швейцарийн хөгжлийн агентлаг
Рио Тинто групп
Моментум Интернэшнл Партнершип ОУ-ын ТББ
Оксфам ОУ-ын ТББ
Эмнести Интернэшнл ОУ-ын ТББ
Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
Монголын байгаль орчны иргэний зөвлөл ТББ
Хил хязгааргүй алхам ТББ*



Хавсралт 2



**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС
АЛБАН ШААРДЛАГА**

15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр,
Утас: 26-29-31, 26-29-71, Факс: (976-11) 32-02-84, 32-71-36,
E-mail: info@mn-nhrc.org; http://www.mn-nhrc.org

2013.01.14. № 4/01

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ГАНТӨМӨР, ХӨДӨЛМӨРИЙН
САЙД Д.САНЖМЯТАВ, ХҮН АМЫН
ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД С.ЭРДЭНЭ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД Н.УДВАЛ НАРТ

Шаардлага хүргүүлэх тухай

Хүний эрхийн Үндэсний Комисс нь ерөнхий боловсролын тусгай сургуулиудад суралцаж буй хүүхдүүдийн сурч боловсрох, эрүүл, аюулгүй байх, хөгжих, оролцох, хамгаалуулах эрх нь Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг үнэлж, хэрэгжилтийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 25, 29, 116, Хан-Уул дүүргийн 63, Баянгол дүүргийн 70, Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулиудад 2012 оны 11 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаад дүгнэлт хийж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон холбогдох яамдад дараах шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

1. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу тусгай сургуулиудын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сургуулийн онцлогт тохируулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангуулах чиглэлээр бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах;

2. Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтоохдоо тусгай сургуулийн онцлог, хэрэгцээг үндэслэж байх, мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт зааснаар нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох заалтыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх;

3. Согог зүйч тусгай сургуулийн багш нарыг тусгайлан бэлтгэх, өндөр хөгжилтэй орнуудад улсын зардлаар сургах, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуульд согог зүйч, нөхөн сэргээх эмчилгээний эмч бэлтгэх анги нээх, Монгол Улсын Боловсролын их сургуульд тусгай хэрэгцээт боловсролын талаарх давтан, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлэх;



4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогоос хамааран, ялангуяа өөртөө үйлчлэх чадваргүй, аливаа үйл хөдөлгөөнөө бие даан удирдах боломжгүй (хувцаслах, хооллох, бие засах, тоглох, суралцах, сургуульдаа ирэх, буцах, олон нийтийн ажилд оролцох гэх мэт) хүүхдэд байнга дэмжлэг туслалцаа үзүүлэх туслах багш нарын орон тоог бий болгож ажиллуулах;

5. Хөгжлийн бэрхшээлийн улмаас суралцагчид сэтгэл гутралд амархан ордог, бусадтай зөрчилдөх магадлал өндөр байдаг онцлогийг харгалзан тусгай сургууль бүрт мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоог бий болгож ажиллуулах;

6. Тусгай сургуульд суралцаж байгаа хүүхдийг нөхөн сэргээх, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад шаардлагатай зүйлсээр болон хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслийн зардлыг бодитой тогтоон төсөвлөх, тусгай сургууль бүрийг суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн тээврийн хэрэгслээр хангах;

7. Холбогдох мэргэжлийн байгууллагаар зарим сургуулиудын байрыг иж бүрэн засварлаж шинэчлэх асуудлаар дүгнэлт гаргуулж, цэвэр, бохир ус, дулааны хуучин шугам сүлжээг солих асуудлыг шийдвэрлэх;

8. Замын хөдөлгөөний ачаалал ихтэй хэсэгт байрлан үйл ажиллагаа явуулж байгаа зарим тусгай сургуулийн орчин тойрны зам, зорчих, хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ээлтэй, аюулгүй байдлаар өөрчлөх;

9. Хүүхдийн бие эрхтний онцлогоос шалтгаалан дархлаа султай, хурдан ядардаг байдлыг харгалзан тусгай сургуульд суралцагчдыг анги харгалзахгүйгээр "Үдийн хоол" хөтөлбөрт бүрэн хамруулах;

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээ, түвшин бүрт нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар шинэчлэн батлах, үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тусгай хэрэгцээнд нийцсэн, эдэлгээ даахуйц чанартай сурах бичгүүдийг хэвлэх, хүрэлцэхүйц тоогоор түгээх;

11. Тусгай сургуулиуд дахь эмч нарын анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлэх, хүүхдүүдийн өвчний онцлог бүрээс шалтгаалан тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй болгох, эмч, сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх, эмнэлгийн үйлчилгээг олон улсын жишиг стандартад нийцүүлэн өөрчлөх, үүнд хангалттай санхүүжилтийг төсөвлөх;

12. Боловсролын чанарыг нэмэгдүүлэхийн тулд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс хамаарч, нэг ангид суралцах суралцагчдын тоог бууруулж, анги дүүргэлтийн нормативыг дахин шинэчлэх;

13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх суурь судалгааны ажлын арга зүй, шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулж, улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь судалгааг хийж, сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг тусгай сургуульд хамруулах арга хэмжээ авах;

14. Тусгай сургуулийн багш, ажилтнуудын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудалд төрөөс үзүүлэх халамж, үйлчилгээг нэмэгдүүлэх;



15. Тусгай сургуулийн багш, ажилтнуудын мэргэжлээс шалтгаалсан өвчин, ажлын байрны хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох, хөнгөлөлттэй нөхцлөөр тэтгэвэр тогтоолгох асуудлыг судалж шийдвэрлэх;

16. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд татан оролцуулахын тулд чанартай боловсрол олгох зорилгоор цэцэрлэг, дотуур байр бүхий ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвөөс бүрдсэн цогцолборуудыг үндэсний хэмжээнд байгуулах санаачлагыг дэмжих, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын орчинг бүрдүүлэх.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу шаардлагын мөрөөр тодорхой арга хэмжээг авч, хуульд заасан хугацааны дотор авсан арга хэмжээний тухай бичгээр хариу мэдэгдэнэ үү.

Тусгай сургуульд суралцагч хүүхдүүдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр одоогийн дагаж мөрдөж буй дүрэм, журам, стандарт, норм, нормативийг шинэчлэх, шинээр баталж мөрдүүлэхэд салбарын яамд нягт хамтран ажиллахыг хүсч байна.

ДАРГА

ГИШҮҮН

ГИШҮҮН



Ж.БЯМБАДОРЖ

Ж.ДАШДОРЖ

П.ОЮУНЧИМЭГ



Хавсралт 3

Олон Улсын Хүний эрхийн конвенцуудын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын илтгэлүүдийн тайлагналт

№	Гэрээ	Тайлагнах журам	Хүргүүлсэн илтгэл	Хүргүүлсэн огноо	Хүлээгдэж буй илтгэл	Хүргүүлсэн байх огноо	Хоцорсон хугацаа
1	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш Хороо шаардсан тухай бүрт тайлагнана. (Ихэнх тохиолдолд 4 жил тутам)	1 дүгээр илтгэл	1978.12.20	6 дугаар илтгэл	2015.04.01	
			2 дугаар илтгэл	1985.08.02			
			3 дугаар илтгэл	1990.11.29			
			4 дүгээр илтгэл	1998.04.20			
			5 дугаар илтгэл	2009.09.14			
2	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш 5 жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1977.10.19 1979.12.06 1981.10.27	5 дугаар илтгэл	2015	
			2 дугаар илтгэл	1983.10.25 1986.08.27			
			3 дугаар илтгэл	1998.04.21			
			4 дүгээр илтгэл	2011.12			
3	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1983.11.18	8-9 дүгээр илтгэл	2014.09.03	
			2 дугаар илтгэл	1987.03.17			
			3 дугаар илтгэл	1998.12.08			
			3.4 дүгээр илтгэл	1998.12.08			
			5.6.7 дугаар илтгэл	2007.04.12			

4	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш 2 жил тутамд тайлагнана.	1 дүгээр илтгэл	1971.07.30	19-20-21 дүгээр илтгэл	2010.05.09	2 жил 11 сар
			2 дугаар илтгэл	1972.08.07			
			3 дугаар илтгэл	1975.04.09			
			4 дүгээр илтгэл	1978.05.05			
			5 дугаар илтгэл	1979.11.05			
			6 дугаар илтгэл	1981.06.22			
			7 дугаар илтгэл	1982.04.12			
			8 дугаар илтгэл	1984.12.26			
			9 дүгээр илтгэл	1987.02.12			
			10 дугаар илтгэл	1988.10.18			
			1998.04.20				
			16,17,18 дугаар илтгэл	2005.09.27			
5	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	2009.09.23	2 дугаар илтгэл	2014.11.19	
6	Хүүхдийн эрхийн тухай конвенц	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш таван жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1994.12.20			
			2 дугаар илтгэл	2003.05.06		2014.10.20	
			3,4 дүгээр илтгэл	2008.03.31			
7	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	Нэгдэж орсон улсын хувьд уг Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор, түүний дараа 5 жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	2008.03.31	2 дугаар илтгэл	2013.03.31	



8	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, Хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	Нэгдэж орсон улсын хувьд уг Протокол хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор, түүний дараа 5 жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	2008.03.31	2 дугаар илтгэл	2013.03.31
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	2012.02.10 Хугацаанаас 8 сар хоцорсон	2 дугаар илтгэл	2017-2018
10	Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29 дүгээр конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2013	Ээлжит илтгэл	2015 онд нэн даруй илгээх
11	Эвлэлдэн нэгдэх ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 87 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2012	Ээлжит илтгэл	2014 онд нэн даруй илгээх
12	Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээрийн тухай ОУХБ-ын 98 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2010 2012	Ээлжит илтгэл	2014 онд нэн даруй илгээх
13	Төлш шан хөлс олгох тухай ОУХБ-ын 100 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2011	Ээлжит илтгэл	2013.09.01
14	Эхчүүдийг хамгаалах тухай ОУХБ-ын 103 дугаар конвенц	Гишүүн улс бүр 5 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2008	Ээлжит илтгэл	2013.09.01
15	Албадан хөдөлмөрийг устгах тухай ОУХБ-ын 105 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2013	Ээлжит илтгэл	2015 онд нэн даруй илгээх
16	Ялгаарлан гадурхахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай ОУХБ-ын 111 дүгээр конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2011	Ээлжит илтгэл	2013.09.01

17	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай ОУХБ-ын 122 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2011	Ээлжит илтгэл	2013.09.01	
18	Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 123 дугаар конвенц	Гишүүн улс бүр 5 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2008	Ээлжит илтгэл	2013 онд нэн даруй илгээх	
19	Үйлдвэрийн газарт ажилгчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгох бололцооны тухай ОУХБ-ын 135 дугаар конвенц	Гишүүн улс бүр 5 жил тутам тайлагнана.	-	-	-	-	
20	Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2008	Ээлжит илтгэл	2010	3 жил
21	Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай ОУХБ-ын 144 дүгээр конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2010.11	Ээлжит илтгэл	2012	1 жил
22	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУХБ-ын 155 дугаар конвенц	Гишүүн улс бүр 5 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2009	Ээлжит илтгэл	2014	
23	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт.	Гишүүн улс бүр 5 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2004.09	Ээлжит илтгэл	2009	4 жил



24	Хөдөлмөр эрхлэлтийн тухай ОУХБ-ын 159 дугаар конвенц	Гишүүн улс бүр 2 жил тутам тайлагнана.	Ээлжит илтгэл	2008	Ээлжит илтгэл	2010	2 жил
----	--	--	---------------	------	---------------	------	-------

Хаяг:
 “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
 Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
 И-мэйл: tugin_medelele@parliament.mn
 Утас: 262420
 Хэвлэлийн хуудас: 7.25
Индекс: 14003